



“ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗОХИСТОЙ БОДЛОГО” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Боловсруулсан: Багийн ахлагч Д.Мөнхцэцэг (Экономиксийн тэнхимийн багш)

Багийн гишүүн: П.Гантөмөр, Ph.D (Экономиксийн тэнхимийн профессор)

2015 он

*Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь
зөвхөн судлаачийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд
Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно.*

УДИРТГАЛ

Манай улсад орж буй гадаадын хөрөнгө оруулалт (ГХО) нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглох, гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад монголын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгодог. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу дэд бүтэц, боловсруулах, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл эрхэлж байгаа хөрөнгө оруулагчдад орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгож, технологийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмжийг импортлоход хөнгөлөлт, чөлөөлөлт олгодог байна.

Гэтэл Монгол улсад орох гадаадын хөрөнгө оруулалтын урсгал 2012-2013 онд 43,52%, 2013-2014 онд 60,7%-иар¹ тус тус буурсан байна. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт 2010-2011 онд 35,8%, 2012-2013 онд 61,9%, 2013-2014 онд 60 хувиар тус тус буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын уул уурхайн салбарт орж буй хувийн жин 2011, 2012, 2013 онуудад харгалзан 0,82, 0,69, 0,72 байгаа нь уг хөрөнгө оруулалтын дийлэнх нь тухайн салбарт төвлөрч байгааг илтгэж байгаа юм.

ГХО-ын дотогшлох урсгал эрс буурч, гадагшлах урсгал нэмэгдэхийн хэрээр манай эдийн засагт гадаад өр, төсвийн алдагдал, валютын ханш, ажилгүйдэл зэрэг олон асуудлууд үүссээр байна. Энэ байдал нь бид өнөөгийн хөрөнгө оруулалтын орчин болон хөрөнгө оруулалтыг татах бодлогод анхаарах, мөн хөрөнгө оруулагч компани болон өөрийн улс орны эрх ашигт нийцсэн оновчтой бодлогыг боловсруулах зайлшгүй нөхцөл байдал үүссэнийг илтгэн харуулж байна.

Иймд гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох, уул уурхайгаас бусад салбар руу гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалыг залахын тулд өөрийн улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогыг судлах, гадаадын шууд хөрөнгө оруулалтын давуу болоод сул талыг илрүүлэх, цаашилбал гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар Монгол Улсын өнгөрсөн хугацаанд баримталж байсан болон өнөөгийн цаг хугацаанд баримталж буй бодлогын хэрэгжилт, эдийн засагт түүний үзүүлж буй нөлөөллийг шинжлэх замаар санал, зөвлөмж боловсруулах хэрэгцээ, шаардлага үүссээр байна.

Иймийн учир Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогын болон макро эдийн засгийн орчинг судлах, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулах талаар хийсэн судалгааны ажлын үр дүнд тулгуурлан санал зөвлөмж өгөхийн тулд энэхүү сэдвийн хүрээнд бодлогын судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

¹ www.1212.mn

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улс “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-даа эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын үүрэг, ач холбогдлыг дараах гурван байдлаар үнэлж байгаагаа тусгасан байна. Нэгдүгээрт, гадаадын аль нэг орноос орж ирэх хөрөнгө оруулалт нь нийт гадаадын хөрөнгө оруулалтын 1/3-аас багагүй байх бодлого баримталж, гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлан, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална. Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалтаар дамжуулан дотоодын капитал хуримтлалыг нэмэгдүүлж, удирдлагын ур чадвар, технологийг сайжруулснаар дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулна. Гуравдугаарт, дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулснаар хилийн чанадад хөрөнгө оруулалт, худалдаа хийх дотоодын аж ахуйн нэгжүүдийг бий болгосноор экспортын баримжаатай эдийн засгийн өсөлтийг хангана гэжээ. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлж чадвал богино болон урт хугацааны хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой байхаар хөгжлийн бодлого боловсруулагдсан байгааг илтгэнэ.

1990 онд чөлөөт эдийн тогтолцоо руу шилжих алхмыг эхлүүлж, 1993 онд гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа баталснаар манай улсын худалдааны нийт эргэлт нэмэгдэж, хөрөнгө оруулалтын урсгал хурдассан юм. 2000 оны эхэн үеэс уул уурхайн салбарын үйл ажиллагаа идэвхжиж, түүнийг даган нийтийн хоол, жижиглэн болон бөөний худалдааны салбарын үйлдвэрлэл сэргэсэн хэдий ч хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт буурах хандлагатай болсон байв. Гэвч манай улс жижиг эдийн засагтай учраас дан ганц уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэлийн нийт хэмжээ нь өсөж эхэлсэн юм. (Хүснэгт 1)

2000-аад оныг хүртэл хөдөө аж ахуйн салбар нь голлох нөлөөтэй байсан манай эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж уул уурхайн гүйцэтгэх үүрэг ач холбогдол нэмэгдэв. 2011 оны эдийн засгийн өндөр өсөлтийн уг шалтгаан нь ч уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт огцом нэмэгдсэнтэй холбоотой байсан. 2014 оны байдлаар ДНБ-ий 17,6%-ийг уул уурхай, олборлолтын салбараас, 16,4%-ийг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбараас, 14%-ийг хөдөө аж ахуйн салбараас, 10,6%-ийг боловсруулах үйлдвэрлэлээс бий болгожээ.

Түүнчлэн манай худалдааны гол түнш Хятадын эдийн засгийн өсөлт саарч, нүүрс, зэс зэрэг ашигт малтмалын дэлхийн зах зээл дээрх үнэ буурч байгаа нь манай экспортын эрэлтийг бууруулах гадаад хүчин зүйл болж байна. 2012 оноос хойш гадаадаас орж ирэх шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурахын зэрэгцээ (Зураг 1) ДНБ-д засгийн газрын өрийн эзлэх хувь, инфляцийн түвшин, авилгын индекс, валютын ханш зэрэг макро эдийн засгийн орчинг тодорхойлогч гол

үзүүлэлтүүд муудсан (Хүснэгт 1) төлөвтэй байна. Худалдааны нийт эргэлт 11 тэрбум долларт хүрч өссөн хэдий ч ДНБ-д бараа, үйлчилгээний экспорт, импортын эзлэх хувийн жин буурчээ.

Хүснэгт 1. 2014 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд						
Хүн ам						
Нийт (сая)	2996					
Улаанбаатар (сая)	1363					
Хотын (нийт хүн амд эзлэх хувь)	66%					
ДНБ	2008	2011	2013	2014		
Оны үнээр, тэрбум төгрөг	6556	13174	19174	21937*		
I хүнд ноогдох, оны үнээр, мян. төг	2480	4728	6614	7403*		
Худалдаа	2008	2011	2013	2014	Эдийн засгийн топ үйл ажиллагаа (ДНБ-д эзлэх хувь)	
Нийт эргэлт (тэрбум ам.доллар)	5,8	11,4	10,6	11,0	Уул уурхай, олборлолт	17,6%
Бараа, үйлчилгээний экспорт (ДНБ-д эзлэх хувь)	39%	37%	22%	26%	Бөөний болон жижиглэнгийн худалдаа	16,4%
Бараа, үйлчилгээний импорт (ДНБ-д эзлэх хувь)	49%	50%	33%	24%	Хөдөө аж ахуй	14,0%
					Боловсруулах үйлдвэрлэл	10,6%
					Тээвэрлэлт ба хадгалалт	4,5%
					Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6,1%
					Барилга	5,8%
Макро эдийн засгийн орчин	2008	2011	2013	2014	Ашигт малтмалын гол нөөц	
Засгийн газрын өр (ДНБ-д эзлэх хувь)	40%	43%	56%	57%	Зэс	Нүүрс
Инфляци (жилийн дундаж түвшин)	28	9.2	10.5	12.8	Алт	Төмрийн хүдэр
Авилгын индекс	3	2.7	3.8	3.9	Фосфор	Цайр
Валютын ханш (₮/\$)	1166	1266	1524	1817	Уран	Мөнгө


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо,

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл

Уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан, хий, усан хангамж, хог хаягдлын менежментийг аж үйлдвэр хэсэгт оруулсан болно.

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татагч гол төсөл болох “Оюутолгой” төсөл нь хөрөнгө оруулагч тал болон Монголын засгийн газрын маргаантай асуудлаас болж 2013 оны 8 сараас эхлэн түр зогссон төдийгүй 2016 он сонгуулийн жил болж байгаатай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулагч нарт байдлыг харзнах, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхгүйгээр түр хүлээх нөхцөлийг үүсгээд байгаа тул шууд хөрөнгө оруулалтын дотогшлох урсгал эрс буурч байна. Зураг 1-ээс харахад 2008-2013 оны хооронд нийт гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалын дунджаар 2%-тай тэнцэх хөрөнгө гадагш гардаг байсан бол 2014 онд энэ харьцаа 28% хүртлээ өсчээ.

Зураг 1. Монгол Улсад орсон болон Монгол Улсаас гадаад улсад хийсэн ШХО




Зураг 2. Монгол Улсад орж ирсэн ШХО болон эдийн засгийн өсөлтийн хамаарал



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэлүүд, Монголбанкны төлбөрийн тэнцлийн мэдээлэл

Эдийн засгийн өсөлт ГХО-аас шууд хамааралтай (Зураг 2). Гэтэл ГХО-ын дийлэнх хувь нь зөвхөн уул уурхайн салбарт ордог, тэр дотроо дан ганц “Оюутолгой” төслөөс шууд хамаардаг учраас манай эдийн засаг ганц салбараас хамаарсан, эмзэг бүтэцтэй болоод байна. 2009.10.06-нд үзэглэгдэж, 2013 оны 8 сард түр зогсох хүртлээ “Оюутолгой” төслийн хөрөнгө оруулалт эрчимтэйгээр орж ирж байсан гэж үзвэл төсөлд оруулсан 7 гаран тэрбум долларын хөрөнгө оруулалт нь 2010-2013 онд орж ирсэн нийт хөрөнгө оруулалтын 54%-ыг, уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын 85%-ыг бүрдүүлсэн байна. Түүнчлэн “Оюутолгой”-н нийт борлуулалт 2 тэрбум доллар байхад нэрлэсэн ДНБ 11,5 тэрбум доллар байгаа нь манай улсын жилийн нийт үйлдвэрлэлийн 17% нь зөвхөн “Оюутолгой”-гоос хамаарч байгааг илтгэнэ.

Зураг 3. Уул уурхайн болон уул уурхайгаас бусад салбарт орсон ГШХО-ын өсөлт



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар, 2014 оны өсөлтийн хувь нь Монголбанкны төлбөрийн тэнцлийн мэдээлэл

“Оюутолгой”-н хөрөнгө оруулалт эрчимтэй орж ирж байсан үеүдэд уул уурхайгаас бусад салбарын хөрөнгө оруулалт мөн даган өсөж (Зураг 3 – 2010,

2011 он) байсан хэдий ч мөнгөн дүнгээр тооцоход нийт хөрөнгө оруулалтын 1/5 хэсэгтэй тэнцэж байв.

Хүснэгт 2-оос харахад өнөөгийн байдлаар манай улсад гадаадын хөрөнгө оруулалттай 13'256 компани байдгийн 43% нь 2005-2008 оны хооронд орж ирсэн ба 2013, 2014 онд гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо эрс буурчээ. 2015 оны 3-р сарын байдлаар БНХАУ-ын хөрөнгө оруулалттай компани нийт компанийн 48,6%-ыг бүрдүүлж, 2015 оны 1-р улиралд тус улсаас нийт 8,4 сая долларын хөрөнгө оруулалт орж ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84%-аар буурсан байна. БНСУ болон АНУ-аас орж ирсэн шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2014 оны 1-р улиралтай харьцуулахад 2015 оны 1-р улиралд өссөн бол бусад улсуудын хөрөнгө оруулалтын хэмжээ буурчээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ хамгийн ихээр буурсан улс нь ОХУ, Их Британийн Виржини арлууд байна.

Хүснэгт 2. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо болон хөрөнгө оруулалтын хэмжээ, улсаар


№	Улсын нэр	%	Нийт	1990-2004	2005-2008	2009-2012	2013	2014	2015.03	Монгол Улсад орсон ШХО	
										2015 оны 1-р улирал, сая \$	2015Q1/2014Q1, өөрчлөлтийн хувь
1	БНХАУ	48,6	6439	1534	3094	1455	166	190	28	8,4	-84%
2	БНСУ	17,4	2309	632	1111	453	65	48	8	10,5	21%
3	ОХУ	6,4	851	433	282	109	14	13	4	-1,4	-115%
4	Япон	4,2	551	190	203	132	14	12	4	5,0	-84%
5	АНУ	2,3	303	98	118	76	8	3	0	7,1	12%
6	Британи Виржини Арлууд	2,0	267	27	64	165	2	9	4	-4,3	-147%
7	Герман	1,5	204	102	54	40	7	1	0	0,5	-88%
8	Сингапур	1,6	210	52	45	91	15	7	1	9,2	-45%
9	БНХАУ (Гонг Конг)	1,5	192	54	38	75	17	8	0	19,0	-93%
10	Канад	1,0	131	38	48	39	3	3	1	1,9	-69%
11	Австрали	1,0	120	18	29	66	4	3	0	2,2	-62%
	НИЙТ ГХОК-ИЙН ТОО	100	13'256	3691	5636	3090	390	335	113	-109,2	-

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар, Монголбанк - гадаад секторын тойм

2015 оны 1-р улирлын байдлаар шууд хөрөнгө оруулалтын нийт мөнгөн дүн -109,2 сая доллар буюу сөрөг утгатай гарсан нь “Тайлант хугацаанд аж ахуйн нэгжүүдийн толгой компаниас авсан зээлийн эргэн төлөлт их хэмжээгээр хийгдсэн тул гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал сөрөг дүнтэй гарлаа. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалд жинтэй хувь нэмэр эзэлдэг БНХАУ, Гонг Конгоос хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад харгалзан 84%, 93%-аар буурчээ.” гэж Монголбанкны гадаад секторын тоймд тайлбарлажээ.

ГШХО-ын дотогшлох урсгалыг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 2009 оныг хүртэл БНХАУ хамгийн их хөрөнгө оруулагч улс байсан бол 2010 онд Английн Виржини Арал, 2011 оноос хойш Нидерланд, Люксембург улсаас орж ирэх хөрөнгө оруулалтын урсгал давамгайлах болов. (Зураг 4)

Зураг 4. Монгол Улсад оруулсан ГШХО-ын урсгал, улсаар, мянган ам.доллараар



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар

Гадаадын хувь, оролцоотой хамгийн том 20 компанийн долоо нь уул уурхайн салбарт, дөрөв нь банкны салбарт үйл ажиллагаа явуулдаг болох нь Хүснэгт 5-аас харагдаж байна. Түүнчлэн гадаадын томоохон хувь, оролцоотой компаниуд нь татварын диваажин гэгддэг Нидерланд, Английн Виржинийн Арлууд,

Люксембург улсуудад бүртгэлтэй байна.

Хүснэгт 3. Гадаадын хувь, оролцоотой хамгийн том 20 компани

Эрэмбэ	Компанийн нэр	Орж ирсэн хугацаа	Нийт хөрөнгө (сая доллар)	Гадаадын хувь (%)	Үйл ажиллагааны чиглэл	Оролцоотой талууд
1	Oyu Tolgoi	2000	108,5	66	Уул уурхай	Нидерланд, Английн Виржини Арлууд, Монгол
2	Peabody Winsway Resources	2007	61,0	100	Уул уурхай	Нидерланд
3	Chinggis Khaan Bank	2006	32,6	100	Банк	Английн Виржини Арал
4	Tethys Mining	2004	26,9	100	Уул уурхай	Швейцарь
5	Boldtomor Yороо Gol	2004	18,9	100	Уул уурхай	Английн Виржини Арал
6	Goyo	2006	18,0	100	Ноос, ноолуур	Сингапур
7	Khan Bank	2004	20,6	66	Банк	Япон, Монгол, Хятад, Хонг-Конг, АНУ
8	MCS Asia Pacific	2005	23	55	Ус, ундаа	Сингапур, Монгол
9	Areva Mongolia	2005	12,5	100	Уул уурхай	Франц
10	Mobicom Corporation	1995	10,7	79	Харилцаа, холбоо	Нидерланд, Монгол
11	Ulaanbaatar University	1995	6,7	98	Боловсрол	БНСУ, АНУ, Монгол
12	Wagner Asia Equipment	1996	6,4	100	Машин, тоног төхөөрөмж	АНУ
13	Sky Resort	2008	20,9	26	Аялал, жуулчлал	Монгол, Английн Виржини Арал
14	Central Asian Cement	2003	5,5	98	Барилга	Хятад, Хонг-Конг, АНУ, НВУ, Монгол, Бельги, Нидерланд, Сингапур
15	Mongolrosvestment	2007	10,5	49	Уул уурхай	Монгол, ОХУ
16	Trade and Development Bank	2002	3,8	80	Банк	Люксембург, Монгол, АНУ
17	Qing Hua-MAC-Nariin Sukhait	2002	3,6	50	Уул уурхай	Хятад, Монгол
18	National Investment Bank	2006	3,2	44	Банк	Монгол, Кайман Арал, Хятад, Хонг-Конг
19	Sunjin Group	2006	2,3	100	Аялал, жуулчлал	БНСУ
20	Seoul Group	1996	1,1	95	Үл хөдлөх хөрөнгө	БНСУ, Монгол
	Нийт		405,5	79		

Эх сурвалж¹: Хөрөнгө оруулалтын газар

1980.01.27-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц”-д 1988.04.11-нд нэгдэн орсон. Тус конвенцийн 26 дугаар зүйл.

Аливаа хүчин төгөлдөр гэрээг түүнд оролцогчид заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд түүнийг үнэнч шударгаар хэрэгжүүлнэ” гэсний дагуу Монгол Улс аливаа олон улсын гэрээнд нэгдэн орсноор түүнийг заавал биелүүлэхийг энэхүү гэрээгээр хүлээн зөвшөөрсөн юм. Энэ гэрээнд нийт 111 улс нэгдэн орсон байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2. “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан нь Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орсноор үндэсний хууль, тогтоомжийг түүнд нийцүүлэн, заавал дагаж мөрдөхийг хуульчилсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрхзүйн зохицуулалттай холбоотой олон талт гэрээ, конвенцэд Монгол улс нэгдэн орсон байдлыг Хүснэгт 4-д (Монгол улс нэгдэн орсон огноогоор эрэмбэлэн) харуулав.

Хүснэгт 4. Монгол Улс нэгдсэн орсон гадаадын хөрөнгө оруулалтын эрхзүйн зохицуулалттай холбоотой олон талт хэлэлцээрүүдийн жагсаалт

Гэрээний нэр	Байгуулагдсан огноо	Хүчин төгөлдөр болсон огноо	Монгол улс нэгдэн орсон огноо
Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц	1974.06.12	1988.08.01	1974
Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенц	1965.03.18	1966.10.14	1996.05.28
Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр	1994.04.15	1995.01.01	1996.12.26
Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц	1980.04.11	1988.01.01	1997.07.09
Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт ангентлагийг үүсгэн байгуулах конвенц	1985.10.11	1988.04.12	1998.07.23

Үүнээс гадна орлогын албан татварыг давхардуулж ноогдуулахгүй байх болон татвар төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийг нийт 28 оронтой хийсэн байна.

Хүснэгт 5. Монгол Улсаас бусад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ноогдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийн жагсаалт, 2013 оны 3-р сарын байдлаар

Улс	Огноо	Улс	Огноо
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1993.01.01	Бельгийн Вант Улс	1999.01.01
Бүгд Найрамдах Солонгос Улс	1993.01.01	Бүгд Найрамдах Казахстан Улс	2000.01.01
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Киргиз Улс	2000.01.01
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Польш Улс	2002.01.01
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	1997.01.01	Люксембургийн Вант Улс ²	2002.01.01

² UNCTAD, “Investment Policy Review – Mongolia ” 2013, хуудас 28.

Бүгд Найрамдах Турк Улс	1997.01.01	Бүгд Найрамдах Болгар Улс	2002.01.01
Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	1997.01.01	Швейцарын Холбооны Улс	2002.01.01
Бүгд Найрамдах Унгар Улс	1997.01.01	Украин Улс	2003.01.01
Малайз Улс	1997.01.01	Канад Улс	2003.01.01
Оросын Холбооны Улс	1998.01.01	Арабын Нэгдсэн Эмират Улс ³	2003.01.01
Бүгд Найрамдах Индонези Улс	1998.01.01	Бүгд Найрамдах Сингапур Улс	2005.01.01
Кувейт Улс ¹	1998.01.01	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	2005.01.01
Бүгд Найрамдах Франц Улс	1999.01.01	Бүгд Найрамдах Австри Улс	2005.01.01
Бүгд Найрамдах Чех Улс	1999.01.01	Нидерландын Вант Улс ⁴	2005.10.31

Эх сурвалж: Татварын ерөнхий газар

Тэмдэглэгээ:

- ¹ “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Кувейт Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.
- ² “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.
- ³ “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.
- ⁴ “Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Нидерландын Вант Улсын хоорондын хэлэлцээр”-ийн үйлчлэл 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр бус болно.

Худалдаа, нийтийн хоолны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо хуримтлагдсан дүнгээрээ хамгийн олон байгаа ба тэдгээр нь 2005-2008 оны хооронд эрчимтэйгээр орж ирж байжээ. 2015 оны 3-р сарын байдлаар мөн л энэ салбарт хамгийн олон компани буюу 104 компани бүртгэгдсэн хэдий ч 2014 оны статистик мэдээгээр бөөний болон жижиглэн худалдааны салбар -6,9%-аар, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбар -9,5%-аар тус тус буурсан байна. Хүснэгт 2-ын сүүлийн баганаас дүгнэхэд 2015 оны 3-р сарын байдлаар худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлалын салбарт цөөн тооны гадаадын хөрөнгө оруулалттай компани бүртгэгдсэн ба хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байдаг уул уурхайн салбарт гадаадын компани хараахан бүртгүүлээгүй байна.

Хүснэгт 3. Монгол Улсад бүртгэгдсэн ГХО-тай компанийн тоо, салбараар

№	Салбарын нэр	%	Нийт	1990-2004	2005-2008	2009-2012	2013	2014	2015.03
1	Худалдаа, нийтийн хоол	70,3	9241	969	4654	2864	346	304	104
2	Бусад	12,1	1584	860	583	94	28	15	4
3	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт	3,2	416	272	76	67	-	1	-
4	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	3,0	400	327	53	11	6	2	1

“ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗОХИСТОЙ БОДЛОГО”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

5	Аялал жуулчлал	2,4	318	176	127	9	2	-	4
6	Хөнгөн үйлдвэр	1,4	190	167	23	-	-	-	-
7	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1,4	182	172	7	2	-	1	-
8	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	1,2	158	149	8	1	-	-	-
9	Тээвэр	1,0	134	101	12	17	2	2	-
10	Мэдээлэл, холбооны технологи	0,8	110	72	31	5	1	1	-
11	ХАА, газар тариалан, МАА	0,9	114	86	14	7	1	6	-
12	Мебель, модон эдлэл	0,6	78	71	6	-	1	-	-
13	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	0,5	69	60	4	3	-	2	-
14	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	0,5	64	36	18	7	3	-	-
15	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	0,4	54	47	4	2	-	1	-
16	Эрчим хүч	0,3	44	39	5	-	-	-	-
17	Нийтийн ахуйн үйлчилгээ	0,3	40	36	4	-	-	-	-
18	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	0,2	29	23	6	-	-	-	-
19	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	0,2	21	21	-	-	-	-	-
20	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	0,1	8	7	1	-	-	-	-
	НИЙТ ГХОК-ИЙН ТОО	100	13'141	3691	5636	3089	390	335	113

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын газар

Салбар бүр дэх ГШХО-ын хэмжээг нийт ГШХО-ын хэмжээнд эзлэх хувиар илэрхийлсэн Хүснэгт 4-өөс харахад манай улс геологи, уул уурхайн эрэл хайгуул, худалдаа, нийтийн хоол, банк, санхүүгийн үйл ажиллагаа, инженер, барилга байгуулалмжийн салбараас бусад салбарт бараг хөрөнгө оруулалт татаж чаддаггүй болох нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд худалдаа, нийтийн хоолны салбарт орж ирэх хөрөнгийн урсгал абсолют болон харьцангуй утгаараа өсөж байгаа бол уул уурхайн салбарын ГХО-ын урсгал буурч байна.

Хүснэгт 4. Салбар бүр дэх ГШХО-ын хэмжээ, нийт ГШХО-д эзлэх хувь

№	Салбарууд	1990-2009		2010-2011		2012-2013		Эзлэх хувийн өөрчлөлт
		ГШХО (тэрбум ам.дол)	Эзлэх хувь	ГШХО (тэрбум ам.дол)	Эзлэх хувь	ГШХО (тэрбум ам.дол)	Эзлэх хувь	
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	2483.8	63%	4903.0	82%	3089.7	70%	-12%
2	Худалдаа, нийтийн хоол	754.9	19%	783.1	13%	1003.4	23%	10%
3	Бусад	211.5	5%	221.2	4%	47.6	1%	-3%
4	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	117.4	3%	37.1	1%	45.8	1%	0%
5	Хөнгөн үйлдвэр	78.5	2%	0.3	0%	0.4	0%	0%

6	Инженерийн барилга байгууламж, БМ-ын үйлдвэрлэл	61.5	2%	6.2	0%	50.4	1%	1%
7	МАН гаралтай түүхий эдийн боловсруулалт	22.7	1%	0.9	0%	1.1	0%	0%
8	Мэдээлэл, холбооны технологи	35.6	1%	9.1	0%	1.0	0%	0%
9	Аялал жуулчлал	23.9	1%	22.5	0%	12.6	0%	0%
10	Тээвэр	19.8	0%	10.3	0%	141.3	3%	3%
11	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	16.5	0%	8.4	0%	21.4	0%	0%
12	ХАА, газар тариалан, МАН	15.1	0%	1.0	0%	0.5	0%	0%
13	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	9.4	0%	0.5	0%	1.2	0%	0%
14	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	6.3	0%	8.4	0%	1.2	0%	0%
15	Мебель, модон эдлэл	4.5	0%	0.0	0%	0.1	0%	0%
16	Эрчим хүч	2.5	0%	0.0	0%	0.0	0%	0%
17	Нийтийн ахуйн үйлчилгээ	1.9	0%	0.1	0%	0.0	0%	0%
18	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	2.8	0%	0.0	0%	0.0	0%	0%
19	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	1.5	0%	0.0	0%	0.0	0%	0%
20	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	96.1	2%	0.0	0%	0.0	0%	0%
	Нийт ГШХО	3966	100%	6012	100%	4417	100%	-

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ГШХО-ЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Орц-гарцын загвар нь үйлдвэрлэлийн секторт эцсийн эрэлтийн янз бүрийн бүрэлдэхүүнүүдийн хуримтлагдсан нөлөө /шууд, шуд бус, өдөөгдсөн/-г үнэлэх боломж олгодог. Салбаруудын дотоод холбоосыг эдийн засгийн шинжилгээнд анх удаа хэрэглэсэн Леонтьевийн матриц, эсвэл, технологийн коэффициентийн матриц гэж нэрлэгддэг матрицыг ашиглан гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгчийн нөлөөг тодорхойлох асуудлыг авч үзэв.

Мөн орц-гарцын загвар нь онол, нарийн төвөгтэй практикийн асуудлуудыг шийдэх, нэрлэвэл, үндэсний эдийн засаг доторхи тусгаарлагдсан бүтцийн хоорондох харилцан хамаарлыг судлах боломж олгодог.

Салбар хоорондын хүснэгтийн онол, аргазүйн асуудлууд

1. Орц-гарцын хүснэгтийн шууд зардлын буюу орцын коэффициент

“Орцын коэффициент”-ууд нь түүхий эд материалын хэмжээг сектор бүр дэх үйлдвэрлэлийн нэг нэгжийг бий болгоход ашиглагдсан түүхий эд материалын орцод хувааснаар тодорхойлогддог. Эдгээр нь үндсэн суурь нэгжид харгалзах ба салбар бүрийн хувьд илэрхийлэгдсэн “орцын коэффициентийн хүснэгт”-

тэй холбоотой байдаг. Эдийн засагт зөвхөн 2 салбартай гэвэл үндсэн үйл ажиллагааны хүснэгтийг дараах байдлаар авч үзэж болно. Хүснэгт 8-ыг үзнэ үү.

Хүснэгт 8. Үндсэн үйл ажиллагааны хүснэгт (Загвар 1)

	Салбар 1	Салбар 2	Эцсийн эрэлт	Дотоодын нийт бүтээгдэхүүн
Салбар 1	x_{11}	x_{12}	F_1	X_1
Салбар 2	x_{21}	x_{22}	F_2	X_1
Нийт нэмэгдсэн өртөг	V_1	V_2		
Дотоодын нийт бүтээгдэхүүн	X_1	X_2		

Дээрх загварт тулгуурлан орц-гарцын загвараар үржүүлэгчийг тооцох янз бүрийн аргуудыг бид ашиглаж болно. Энэ судалгааны ажлын хүрээнд L.Voinea болон бусад судлаачдын (2010) ашигласан аргачлалд тулгуурлан шинжилгээг хийлээ. Судлаачдын судалгааны ажлаас үзвэл үржүүлэгчийн нөлөөний үнэлгээг салбар хоорондын хамаарлын системийн шийдээс гаргасан урвуу матрицад тулгуурлан шинжилсэн байв. Уг системийн суурь тэгшитгэлийг матрицан хэлбэрт дараах хэлбэрээр бичиж болно.

$$AX + Y = X \quad (1)$$

Энд:

A-технологийн коэффициентийн матриц

X-үйлдвэрлэлийн нийт салбаруудын багана вектор

Y-эцсийн эрэлтийн вектор

Матрицын хэлбэрт X-ийн шийдийг бичвэл доорх байдлаар илэрхийлэгдэнэ.

Үүнд:

$$X = (I - A)^{-1}Y$$

2. Урвуу матрицын коэффициентийн төрөл (Загварт импортыг оруулах нь)

Орц-гарцын хүснэгт ашиглан үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмрийг судлах шинжилгээнд гол асуудал бол импортыг оруулах явдалд оршдог. Импортыг хасч хялбаршуулсан загварыг $(I - A)^{-1}$ **төрлийн загвар** гэж нэрлэдэг. Дотоодын үйлдвэрлэлийн салбарууд болон өрхүүдэд хэрэглэгддэг янз бүрийн бараануудтай зэрэгцэн бараанууд импортлогддог ба хэрэглэгддэг.

Хүснэгт 9 нь импортыг оруулсан үндсэн үйл ажиллагааны хүснэгтийн загвар гэдгийг харуулна. Мөрт харгалзах барааны хувьд завсрын хэрэглээ (X_{ij}), эцсийн эрэлт (F_i) нь хоёул импортыг агуулсан нийлүүлэлтийг илэрхийлэх ба багана болон мөрүүд (үйлдвэрлэлийн) бие биетэйгээ тэнцүү, яагаад гэвэл, импорт сөрөг утгатайгаар илэрхийлэгдсэн.

Хүснэгт 9. Үндсэн үйл ажиллагааны хүснэгт (Загвар 2)

	Салбар 1	Салбар 2	Эцсийн эрэлт	Импорт	Дотоодын нийт бүтээгдэхүүн
Салбар 1	x_{11}	x_{12}	F_1	$-M_1$	X_1
Салбар 2	x_{21}	x_{22}	F_2	$-M_2$	X_2
Нийт нэмэгдсэн өртөг	V_1	V_2			
Дотоодын нийт бүтээгдэхүүн	X_1	X_2			

Орцын коэффициентуудад импорт агуулагдана. Энэ нь бүх үр дагаврууд дотоодын үйлдвэрлэлд түлхэц өгч буй эцсийн эрэлтээс үүсээд зогсохгүй, зарим нөлөө нь импортын өдөөлт байж болох юм гэдэг утгыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, дотоодын үйлдвэрлэлийн өдөөлтийг үнэн зөв тодорхойлохын тулд импортын нөлөөг оруулах ёстой. Иймээс урвуу матрицын коэффициентийг тооцоолох аргад импортын орцын тооцооллыг оруулна гэсэн үг юм.

$[I - (I - M)A]^{-1}$ төрлийн урвуу матрицын коэффициентийг Япон улсад түгээмэл ашигладаг. Урвуу матрицын коэффициентийг тооцоолох дараах ялгаатай аргууд өргөн ашиглагддаг. Эдгээрийн талаар товч авч үзье.

(1). төрөл

Ийм төрөл нь импортыг хассан байдлаар хялбаршуулсан загвар юм. Уг загварт импортыг экзоген байдлаар оруулж судалгааг хийдэг. 2 мөр, 2 баганатай суурь загварын хувьд нийлүүлэлт, эрэлтийн балансын тэгшитгэлийг дараах байдлаар дүрслэн бичиж болно.

$$\begin{cases} a_{11}X_1 + a_{12}X_2 + F_1 - M_1 = X_1 \\ a_{21}X_1 + a_{22}X_2 + F_2 - M_2 = X_2 \end{cases} \quad (2)$$

Матрицан бичлэг нь доорх хэлбэрт бичигддэг. Үүнд:

$$AX + F - M = X \quad (2)'$$

Энэ бол завсрын эрэлт (X), эцсийн эрэлт (F)-д импортын хэмжээ агуулагдсан “**Өрсөлдөөнт импортын төрөл**”-ийн загвар юм. X -ийн хувьд шийдийг олбол дараах хэлбэрт бичигдэнэ.

$$X = (I - A)^{-1}(F - M)$$

Уг загварт эцсийн эрэлт, импорт нь экзоген байдлаар тодорхойлогдоно. Зарим онцгой тохиолдлоос бусад үед импорт нь дотоодын үйлдвэрлэлээр өдөөгдсөн байж болох юм. Өөрөөр хэлбэл, үүнийг эндоген байдлаар тодорхойлогдсон гэж үзэж болох юм. Харин энэ загвар ховор ашиглагддаг байна.

(2). $[I - (I - M)A]^{-1}$ төрөл

Энэ загвар нь эцсийн эрэлт (F) нь дотоодын эцсийн эрэлт (Y), экспорт (E)-д хуваагдах ба дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ.

$$F = Y + E$$

Энэ тэгшитгэлийг [2]-д орлуулах замаар нийлүүлэлт-эрэлтийн балансын тэгшитгэлийг өөр нэг хэлбэрийн матрицан хэлбэрт бичиж болно.

$$AX + Y + E = X \quad [3]$$

Хүснэгтэд зөвхөн дамжин өнгөрөх үйл ажиллагаануудыг экспорттой нэгтгэх шаардлагагүй байдаг. Ингэхээр экспорт нь импортыг агуулахгүй гэж таамаглаж болох юм. Импортын коэффициентийг мөрийн хувьд дараах байдлаар тодорхойлдог.

$$m_i = \frac{M_i}{\sum_j a_{ij}X_j + Y_i}$$

Өөрөөр хэлбэл, “ m_i ” нь дотоодын нийт эрэлт доторхи “ i ” бүтээгдэхүүний импортын харьцааг, эсвэл, импортоос хамаарах байдлын зэргийг дүрсэлдэг. $(1 - m_i)$ нь бие даасан байдлын зэргийг харуулдаг.

[3]-ийг “ i ” мөрийн хувьд бичвэл:

$$\sum_j a_{ij}X_j + Y_i + E_i - M_i = X_i \quad [4]$$

Импортын коэффициентийн тодорхойлолтоос дараах адилтгалыг бичиж болох юм.

$$M_i = m_i(\sum_j a_{ij}X_j + Y_i) \quad [5]$$

[5]-г [4]-д орлуулах замаар дараах адилтгалыг гарган авч болно.

$$X_i - (1 - m_i)\sum_j a_{ij}X_j = (1 - m_i)Y_i + E_i \quad [6]$$

\hat{M} -ийг диагональ дээрх элементүүд нь импортын коэффициент (m_i)-тэй, диагоналиас бусад байрлал дахь элементүүд нь тэг байх диагональ матриц гэж таамаглаж болно.

$$\hat{M} = \begin{bmatrix} m_1 & \dots & 0 \\ \dots & \ddots & \dots \\ 0 & \dots & m_n \end{bmatrix}$$

[6]-аас дараах матрицан тэгшитгэлийг бичиж болно.

$$[I - (I - \hat{M})A]X = (I - \hat{M})Y + E \quad [7]$$

[7]-оос X-ийн хувьд шийдийг олж бичвэл:

$$X = [I - (I - \hat{M})A]^{-1} \cdot [(I - \hat{M})Y + E] \quad [8]$$

Дотоодын эцсийн эрэлт (Y), экспорт (E) өгөгдвөл дотоодын үйлдвэрлэл (X)-ийг нэг утгатай олж болно гэдгийг [8] томъёо харуулдаг.

Эцсийн эрэлт, эсвэл, завсрын эрэлтийн аль аль нь бүх секторуудад импортын орцын харьцаа тогтмол байх үеийн дотоодын үйлдвэрлэлийн орцын харьцааг $(I - \hat{M})A$ харуулдаг. Дээрхтэй адил таамаглалаар $(I - \hat{M})Y$ нь дотоодын үйлдвэрлэлийн хувьд дотоодын эцсийн эрэлтийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, мөрийн хувьд (эсвэл, импортын коэффициент) импортын харьцаа бүх бүтээгдэхүүний (үйлдвэрлэлийн) салбаруудад адил гэж таамагласан үеийн “Өрсөлдөөнт импортын төрөл”-ийн загвар юм. Энэ загварт суурилсан урвуу матрицын коэффициентийн хүснэгтийг Япон улсад өргөн ашигладаг.

(3) $(I - A^d)^{-1}$ төрөл

Уг загварт үндэслэсэн урвуу матрицын коэффициентууд импортын харьцаа салбараас салбарт ялгаатай байх үеийн шинжилгээнд хэрэглэгддэг “Өрсөлдөөнт бус импортын төрөл”-ийн загвар юм. Хүснэгт 10-д хялбаршуулсан өрсөлдөөнт бус импортын үндсэн үйл ажиллагааны хүснэгтийг харуулав.

Хүснэгт 10. Үндсэн үйл ажиллагааны хүснэгт (Загвар 3)

		Салбар 1	Салбар 2	Эцсийн эрэлт	Импорт	Дотоодын үйлдвэрлэл
Дотоод	Салбар 1	x_{11}^d	x_{12}^d	F_1^d		X_1
	Салбар 2	x_{21}^d	x_{22}^d	F_2^d		X_2
Импорт	Салбар 1	x_{11}^m	x_{12}^m	F_1^m	$-M_1$	
	Салбар 2	x_{21}^m	x_{22}^m	F_2^m	$-M_2$	
Нийт нэмэгдсэн өртөг		V_1	V_2			
Дотоодын үйлдвэрлэл		X_1	X_2			

Хүснэгт 10-аас ерөнхийдөө дараах тэгшитгэлүүдийг бичиж болно.

$$x_{ij} = x_{ii}^d + x_{ij}^m$$

$$F_i = F_i^d + F_i^m$$

Дотоодын үйлдвэрлэлийн хувьд эрэлт-нийлүүлэлтийн баланс доорхи байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

$$\begin{cases} x_{11}^d + x_{12}^d + F_1^d = X_1 \\ x_{21}^d + x_{22}^d + F_2^d = X_2 \end{cases} \quad [9]$$

Дотоодын завсрын бүтээгдэхүүний хувьд орцын коэффициентийг дараах томъёогоор тооцоолно.

$$a_{ij}^d = \frac{x_{ij}^d}{X_j}$$

Энэ тохиолдолд [9] тэгшитгэлийг дараах хэлбэрт бичих боломжтой.

$$\begin{cases} a_{11}^d X_1 + a_{12}^d X_2 + F_1^d = X_1 \\ a_{21}^d X_1 + a_{22}^d X_2 + F_2^d = X_2 \end{cases} \quad [9]'$$

[9]’-ийг доорх байдлаар матрицан хэлбэрт бичиж болох юм.

$$A^d X + F^d = X \quad [9]''$$

Энэ бол “**Өрсөлдөөнт бус импортын төрөл**”-ийн загвар юм. Завсрын эрэлт эцсийн эрэлт хоёул дотоодын эрэлтэд багтах ба импорт хасагдана.

[9]”-ийн шийдийг олбол:

$$X = (I - A^d)^{-1} F^d$$

Дотоодын үйлдвэрлэлийн эцсийн эрэлт (F^d) өгөгдсөн үед дотоодын үйлдвэрлэлийн түвшин (X)–г олж болно гэдгийг дээрх тэгшитгэл харуулдаг.

Өрсөлдөөнт импортын төрлийн загвартай холбогдох хамаарлыг дараах байдлаар авч үзэж болно. Импортын орцын коэффициентийн матриц A^m , импортын эцсийн эрэлтийн багана вектор F^m гэж тодорхойлогддог бол дараах адилтгал хангагдана.

$$\begin{aligned} A &= A^d + A^m \\ F &= F^d + F^m \end{aligned}$$

Дээрх тэгшитгэлд суурилбал эрэлт-нийлүүлэлтийн баланс дараах байдлаар хангагдана.

$$(A^d + A^m)X + (F^d + F^m) = X + M$$

Энэ бол **өрсөлдөөнт импортын төрлийн** загварын **үндсэн тэгшитгэл** болно. Бодит эдийн засагт дотоодын болон импортлогдсон бүтээгдэхүүний орцын харьцаа нь сектороос секторт ялгаатай байж болох юм. Урвуу матрицын коэффициент уг төрлийг [2] буюу $[I - (I - \hat{M})A]^{-1}$ -тай харьцуулсан үед ач холбогдол бүхий ялгаанууд тухайн хугацаанд уг секторуудад ажиглагдаж болох юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинжилгээ

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын салбаруудад үзүүлж буй нөлөөг 2010-2013 онуудын салбар хоорондын хүснэгт ашиглан шинжлэв. Салбар хоорондын хүснэгтэд тулгуурлан гаргасан 2010 оны урвуу матрицыг Хүснэгт 11 болон Хүснэгт 12-д харуулав. Уг хүснэгт нь 20 салбарын мэдээлэлд тулгуурласан урвуу матрицын хүснэгт юм.

Хүснэгт 11. 2010 оны салбар хоорондын хүснэгтээс гарган авсан урвуу матриц

	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	1.134413	0.015414	0.375639	0.013098	0.015812	0.067799	0.00898	0.00512	0.104971	0.010143
2	0.009236	1.051261	0.017218	0.183786	0.066605	0.047196	0.012603	0.004097	0.026328	0.015551
3	0.010236	0.042691	1.118921	0.03244	0.035126	0.199947	0.025087	0.013987	0.189634	0.027872
4	0.004794	0.041121	0.036986	1.780891	0.27348	0.035406	0.058392	0.012932	0.090474	0.035045
5	0.000989	0.00642	0.00468	0.081322	1.436262	0.011347	0.006796	0.002406	0.019578	0.005194
6	0.002407	0.072908	0.008174	0.019922	0.015902	1.071056	0.008422	0.003136	0.022006	0.009454
7	0.043274	0.049713	0.113808	0.080036	0.051543	0.114498	1.033685	0.048288	0.100083	0.038724
8	0.031647	0.040377	0.035523	0.038623	0.026991	0.043332	0.135777	1.123694	0.041232	0.032532
9	0.00121	0.010316	0.002976	0.003683	0.003853	0.005414	0.009166	0.003818	1.006842	0.006686
10	0.006485	0.010865	0.011387	0.006886	0.017036	0.026702	0.02668	0.0133	0.02336	1.105631
11	0.021537	0.026585	0.021286	0.014736	0.103839	0.02202	0.034311	0.020794	0.016631	0.010946
12	0.004021	0.007053	0.009083	0.004001	0.011763	0.012511	0.016843	0.006059	0.044805	0.073661
13	0.011878	0.013273	0.009749	0.006138	0.025862	0.016004	0.014494	0.005774	0.024934	0.025502
14	0.010276	0.006289	0.007986	0.003502	0.006403	0.007632	0.013158	0.017956	0.015036	0.009708
15	0.001596	0.007298	0.004152	0.004748	0.012566	0.034901	0.006686	0.008834	0.028355	0.014226
16	0.0005	0.002817	0.000907	0.002128	0.002532	0.003409	0.002196	0.001205	0.005789	0.010025
17	0.000357	0.001819	0.001134	0.000907	0.000664	0.004215	0.001688	0.003542	0.001899	0.002263
18	0.000168	0.000951	0.00029	0.000916	0.000763	0.000501	0.000572	0.000241	0.0008	0.000819
19	0.000307	0.001077	0.001032	0.001138	0.002247	0.001246	0.00131	0.003897	0.001162	0.001934
20	0	0	0	0	0	0	0	0	0	0

Хүснэгт 12. 2010 оны салбар хоорондын хүснэгтээс гарган авсан урвуу матриц - үргэлжлэл

	11	12	13	14	15	16	17	18	19	20
1	0.006789	0.009255	0.02063	0.017235	0.01272	0.03243	0.024355	0.018846	0.02147	0
2	0.010334	0.017726	0.016909	0.016071	0.011331	0.020411	0.019264	0.032751	0.015952	0
3	0.018748	0.026889	0.059491	0.04758	0.026562	0.060102	0.051072	0.0498	0.05371	0
4	0.010126	0.024246	0.045941	0.079523	0.05739	0.135989	0.126832	0.254822	0.091427	0
5	0.003844	0.003369	0.005838	0.009109	0.007957	0.014156	0.020852	0.02736	0.010127	0
6	0.006069	0.025985	0.015823	0.007955	0.005839	0.007966	0.007967	0.006555	0.007518	0
7	0.023568	0.021297	0.056567	0.055428	0.034206	0.036919	0.050148	0.046941	0.04781	0
8	0.018991	0.008399	0.050993	0.145923	0.021905	0.013065	0.016362	0.021902	0.036819	0
9	0.008388	0.001613	0.008966	0.01827	0.009467	0.001889	0.006589	0.012685	0.007608	0
10	0.050196	0.023073	0.046812	0.033326	0.078356	0.024003	0.030487	0.017965	0.032078	0
11	1.045232	0.009986	0.065044	0.015585	0.007581	0.005921	0.012548	0.02601	0.011965	0
12	0.055658	1.088356	0.034541	0.025932	0.011349	0.010322	0.024855	0.03352	0.047665	0
13	0.05878	0.010984	1.045855	0.014664	0.044242	0.020961	0.013287	0.016099	0.021076	0
14	0.015333	0.005397	0.014473	1.050143	0.01206	0.003118	0.004013	0.022927	0.017839	0
15	0.005717	0.005145	0.0236	0.028573	1.010773	0.012272	0.032029	0.00356	0.005829	0
16	0.006751	0.004758	0.005905	0.004144	0.014022	1.002415	0.005046	0.015926	0.021321	0
17	0.000957	0.000385	0.003986	0.001171	0.003194	0.000396	1.000504	0.000574	0.006776	0
18	0.000562	0.000661	0.006093	0.005053	0.003098	0.00056	0.000386	1.004431	0.002096	0
19	0.001808	0.000443	0.001033	0.001787	0.001233	0.000919	0.001167	0.001859	1.014967	0
20	0	0	0	0	0	0	0	0	0	1

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас манай улсын эдийн засаг ихээхэн хамааралтай гэдгийг хүн бүхэн онцолдог билээ. Иймээс гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтийн үзүүлэх нөлөөг зарим салбаруудын гадаадын шууд хөрөнгө оруулалтын өөрчлөлтөөр дамжуулан судлав. Үүний тулд 2010-2013 онуудын өгөгдлийг ашигласан бөгөөд шинжилгээнээс гарсан үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 13. Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд салбаруудын үзүүлж буй хариу үйлдэл, хувиар


№	Салбарууд / Онууд	2010	2011	2012	2013
1	ХАА, ойн ба загасны аж ахуй	0.00	0.02	0.012	0.004
2	Уул уурхай, олборлох аж үйлдвэр	0.00	0.92	0.544	0.241
3	Боловсруулах аж үйлдвэр	0.02	0.04	0.027	0.013
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл	0.14	0.15	0.134	0.035
5	Усан хангамж, хог хаягдлын менежмент	0.09	0.15	0.106	0.034
6	Барилга	0.03	0.06	0.046	0.018
7	Бөөний ба жижиглэнгийн худалдаа, автомашин засвар	0.59	0.10	0.052	0.025
8	Тээвэр, агуулах	0.06	0.19	0.066	0.041
9	Орон сууц, хүнсний үйлчилгээ	0.09	0.14	0.066	0.046
10	Мэдээлэл, харилцаа холбоо	0.04	0.08	0.046	0.018
11	Санхүү ба даатгалын үйл ажиллагаа	0.18	0.21	0.120	0.065
12	Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа	0.02	0.03	0.017	0.008
13	Мэргэжлийн, ШУ, техникийн үйл ажиллагаа	0.10	0.09	0.066	0.022
14	Захиргааны дэмжлэг үйлчилгээ	0.06	0.17	0.068	0.039
15	Төрийн захиргаа, батлан хамгаалах	0.02	0.03	0.011	0.005
16	Боловсрол	0.01	0.01	0.006	0.002
17	Эрүүл мэнд, нийгмийн ажил	0.01	0.02	0.009	0.004
18	Урлаг, үзвэр, амралт, чөлөөт цаг	0.01	0.02	0.017	0.006
19	Бусад үйлчилгээ	0.02	0.02	0.015	0.005
20	Бусад үйл ажиллагаа	0.00	0.00	0.000	0.000
Нийт өсөлт, хувиар		1.51	2.45	1.43	0.63

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт 1 хувиар нэмэгдсэн нөхцөлд 2010, 2011, 2012, 2013 онуудад харгалзан 1,51%, 2,45, 1,43%, 0,63%-ийн өсөлтийг эдийн засагт бий болгох байдлаар салбарууд хариу үйлдэл үзүүлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт нь 2011 оны эдийн засгийн өсөлтөд хамгийн ихээр нөлөөлсөн байна. 2010 онд цахилгаан дулааны үйлдвэрлэл 0,14%, бөөний ба жижиглэнгийн худалдаа, автомашин засварын үйлдвэрлэл 0,59%, санхүү ба даатгалын үйл ажиллагааны салбар 0,18%, мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны үйлдвэрлэл 0,1% хувиар өсөх байдлаар хариу үйлдэл үзүүлж бусад салбаруудаас өндөр өсөлттэй байна.

2011 онд уул уурхай, олборлох үйлдвэр 0,92%, цахилгаан дулаан, усан хангамж, хог хаягдлын менежментийн үйлдвэрлэл тус бүр 0,15%, тээвэр агуулах 0,19%, санхүү ба даатгалын үйл ажиллагаа 0,21%, захиргааны дэмжлэг үйлчилгээ 0,17% өсөх байдлаар хариу үйлдэл үзүүлжээ. Хүснэгт 13-ын үр дүнг Зураг 5-д үзүүллээ.

Зураг 5. Уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтийн салбаруудад үзүүлж буй нөлөө



Эх сурвалж: Судлаачдын тооцоо

График дүрслэлээс харвал 2011 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд уул уурхайн салбар, бөөний ба жижиглэнгийн худалдаа, автомашин засварын салбарын үйлдвэрлэл хамгийн ихээр өсөх байдлаар хариу үйлдэл үзүүлжээ. 2013 оныг үл харгалзвал цахилгаан дулааны үйлдвэрлэлийн өсөлт 2011-2012 онуудад өсөлтөө хадгалах байдлаар хариу үйлдэл үзүүлсэн байна.


Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас гадна дотоодын хөрөнгө оруулалтын өсөлтөд салбаруудын үзүүлж буй хариу үйлдлийг шинжлэх зайлшгүй шаардлагатай юм. Хөрөнгийн нийт хуримтлал буюу дотоодын хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд салбаруудын үзүүлж буй хариу үйлдлийг хүснэгт 6-д харуулаа.

Дотоодын хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд эдийн засгийн нийт гарц 2010, 2011, 2012, 2013 онуудад харгалзан 3,55%, 0,43%, 0,59%, 0,43%-ийн өсөлтөөр хариу үйлдэл үзүүлсэн болохыг хүснэгт 6-аас харж болно. Харин 2010 онд барилгын салбар 1,084%, 2011 онд уул уурхайн салбар 0,16%, 2012 онд мөн уул уурхайн салбар 0,226%, 2013 онд уул уурхайн салбар 0,173%-ийн өсөлтөөр хариу үйлдэл үзүүлсэн байна. 2009-2010 онд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 261,7%, 2010-2011 онд 194,9 хувиар өсч байхад 2011-2012 онд 9,6%-иар буурсан байна. Эндээс үзвэл 2010-2012 онуудын уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын огцом өсөлт уг салбарын өсөлтийг нэмэгдүүлэхэд хүргэсэн гэж дүгнэж болох юм. Харин 2012 онд буурсан ч гэсэн өмнөх хөрөнгө оруулалтын үр өгөөжийн инерци хадгалагдах замаар замаар тус салбарын гарцыг бусад салбаруудтай жишихэд ихээр нэмэгдэхэд хүргэсэн байж болох юм.

Хүснэгт 14. Дотоодын хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд салбаруудын үзүүлж буй хариу үйлдэл, хувиар

Салбарууд	2010	2011	2012	2013
Хөдөө аж ахуй	0.021	0.003	0.005	0.003
Уул уурхай	0.063	0.160	0.226	0.173
Боловсруулах үйлдвэрлэл	0.154	0.008	0.011	0.009
Цахилгаан	0.383	0.027	0.056	0.025
Усан хангамж	0.346	0.026	0.044	0.024
Барилга	1.084	0.010	0.019	0.013
Бөөний	0.115	0.018	0.022	0.018
Тээвэр	0.074	0.033	0.027	0.030
Зочид буудал	0.396	0.025	0.027	0.033
Мэдээлэл	0.054	0.014	0.019	0.013
Санхүү	0.166	0.037	0.050	0.047
Үл хөдлөх	0.032	0.005	0.007	0.006
Мэргэжлийн	0.284	0.015	0.027	0.016
Удирдлага	0.107	0.030	0.028	0.028
Төрийн удирдлага	0.086	0.004	0.005	0.004
Боловсрол	0.025	0.002	0.002	0.002
Эрүүл мэнд	0.033	0.003	0.004	0.003
Урлаг	0.074	0.004	0.007	0.005
Бусад үйлчилгээ	0.058	0.003	0.006	0.003
Бусад үйл ажиллагаа	0.000	0.000	0.000	0.000
Нийт өсөлт, хувиар	3.55	0.43	0.59	0.45

Зураг 8. Дотоодын хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд салбаруудын үзүүлж буй хариу үйлдэл, хувиар



Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Зураг 8-аас харвал уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт 2010 оныг үл харгалзвал жигд байна. Дотоодын хөрөнгө оруулалтын 1 хувийн өсөлтөд бүх салбарууд 2010 онд бусад жилүүдтэй харьцуулбал өсөлт өндөртэйгөөр хариу

үйлдэл үзүүлсэн болохыг зургаас нарийвчлан харж болно.

Монгол улсын салбарын эцсийн эрэлт болох эцсийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспортоос уул уурхай, олборлох аж үйлдвэрийн хамаарах хамаарлын шинжилгээний үр дүнг дараах тооцооллоос харж болно.

Дээрх тооцооллуудаас үзвэл дотоодын хөрөнгө оруулалтын өсөлтөд уул уурхайн салбарын үзүүлж буй хариу үйлдэл өндөр байв. Иймд 2010 оны салбар хоорондын хүснэгтэд тулгуурлан эцсийн эрэлт болон завсрын үйлдвэрлэлд нэмэр оруулагч салбаруудаас уул уурхай, олборлох аж үйлдвэрийн хамаарах хамаарлыг шинжлэх асуудлыг гүйцэтгэлээ.

Хүснэгт 15. Эцсийн эрэлт болон завсрын үйлдвэрлэлд нэмэр оруулагч салбаруудаас уул уурхай, олборлох аж үйлдвэрийн хамаарах хамаарал, хувиар

Салбарууд	Эцсийн хэрэглээний зардал				Хөрөнгийн нийт хуримтлал				Экспорт			
	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
Хөдөө аж ахуй	44%	42%	38%	30%	39%	40%	48%	59%	17%	18%	14%	11%
Уул уурхай	1%	1%	2%	2%	24%	17%	24%	18%	75%	82%	74%	80%
Боловсруулах үйлдвэрлэл	68%	63%	69%	67%	11%	10%	5%	8%	21%	27%	26%	25%
Цахилгаан	91%	92%	93%	97%	6%	6%	5%	2%	3%	2%	2%	1%
Усан хангамж	100%	63%	72%	72%	-3%	0%	6%	3%	3%	38%	22%	25%
Барилга	2%	2%	2%	2%	96%	97%	96%	96%	2%	2%	2%	2%
Бөөний	41%	31%	42%	54%	16%	26%	26%	32%	43%	43%	32%	13%
Тээвэр	68%	58%	56%	46%	1%	2%	0%	4%	31%	40%	44%	49%
Зочид буудал	30%	61%	58%	77%	1%	1%	1%	1%	70%	38%	42%	22%
Мэдээлэл	85%	86%	79%	87%	6%	3%	4%	1%	9%	11%	17%	12%
Санхүү	80%	78%	74%	90%	0%	0%	0%	0%	20%	22%	26%	10%
Үл хөдлөх	100%	100%	100%	100%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%
Мэргэжлийн	20%	14%	24%	23%	56%	38%	34%	15%	25%	47%	42%	62%
Удирдлага	91%	95%	93%	91%	0%	0%	0%	1%	9%	5%	6%	8%
Төрийн удирдлага	100%	100%	100%	100%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%
Боловсрол	99%	99%	99%	99%	0%	0%	0%	0%	1%	1%	1%	1%
Эрүүл мэнд	99%	99%	99%	99%	1%	1%	1%	1%	1%	1%	1%	1%
Урлаг	99%	100%	100%	100%	0%	0%	0%	0%	1%	0%	0%	0%
Бусад үйлчилгээ	99%	91%	90%	89%	0%	0%	0%	0%	1%	9%	10%	11%
Бусад үйл ажиллагаа	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Уул уурхай болон олборлох аж үйлдвэрийн салбар нь Монгол улсын уул уурхайн экспортын эцсийн эрэлтээс маш өндөр хамаарч байна. 2010 онд зочид буудлын салбарын үйлчилгээний экспортын эцсийн эрэлтээс 75 хувиар хамаарч байсан бол 2011 оноос хойш уг хамаарал 2 болон түүнээс дээш дахин хэмжээгээр буурсан байна. 2010-2012 онуудад тээврийн салбарын экспортын эцсийн эрэлтээс хамаарах хамаарал улам нэмэгдэж байгаагаас гадна барилгын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын эцсийн эрэлтээс жил бүр 96%-иар хамаарч байгааг харж болох юм.

Сангийн болон мөнгөний бодлогын аливаа өөрчлөлтүүд нь эдийн засагт үржүүлэгчийн нөлөөтэй байдаг. Тухайлбал, AD-AS болон Кейнсийн загварт тулгуурлан бүтээгдэхүүний зах зээлд сангийн болон мөнгөний бодлогын үзүүлэх нөлөөг авч үздэг. Харин салбар хоорондын тэнцлийн хүснэгтийн урвуу матрицыг ашиглан аливаа үзүүлэлтийн өөрчлөлтийн нөлөөг гарцын үржүүлэгчээр дамжуулан шинжлэх боломжтой юм. Онцолбол, $(I - A)^{-1}$ матрицын баганы нийлбэрийг гарцын үржүүлэгч гэж нэрлэсэн байдаг.³ Иймд урвуу матрицыг ашиглан Монгол улсад орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгчийг тооцон Хүснэгт 16-д харууллаа.

Хүснэгт 16. Гадаадын болон дотоодын нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгч

Салбарууд	GCF, multiplier				FDI multiplier			
	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
ХАА	0.0616	0.0488	0.0549	0.0829	0.0024	0.0036	0.0026	0.0010
Уул уурхай	0.1181	0.0749	0.0835	0.0600	0.1393	0.3977	0.1891	0.0768
Боловсруулах	0.0507	0.0416	0.0395	0.0346	0.0066	0.0116	0.0085	0.0034
Цахилгаан	0.0117	0.0075	0.0082	0.0085	0.0072	0.0104	0.0086	0.0023
Усан хангамж	0.0022	0.0017	0.0024	0.0021	0.0011	0.0019	0.0015	0.0005
Барилга	0.1197	0.1405	0.1811	0.1762	0.0101	0.0102	0.0148	0.0043
Худалдаа	0.0474	0.0555	0.0534	0.0552	0.0339	0.0819	0.0699	0.0317
Тээвэр	0.0163	0.0148	0.0161	0.0212	0.0095	0.0337	0.0314	0.0093
Орон сууц	0.0022	0.0031	0.0021	0.0028	0.0023	0.0055	0.0043	0.0015
Мэдээлэл	0.0074	0.0058	0.0071	0.0054	0.0023	0.0057	0.0036	0.0013
Санхүү	0.0079	0.0089	0.0107	0.0143	0.0066	0.0132	0.0101	0.0061
Үл хөдлөх	0.0034	0.0031	0.0031	0.0038	0.0016	0.0036	0.0021	0.0014
Мэргэжил	0.0141	0.0105	0.0130	0.0092	0.0023	0.0041	0.0037	0.0017
Захиргаа	0.0026	0.0026	0.0027	0.0047	0.0012	0.0039	0.0025	0.0018
Төр	0.005	0.0043	0.0023	0.0023	0.0012	0.0020	0.0011	0.0005
Боловсрол	0.0008	0.0002	0.0003	0.0003	0.0005	0.0006	0.0005	0.0002
Эрүүл мэнд	0.0011	0.0009	0.0010	0.0010	0.0015	0.0008	0.0005	0.0002
Урлаг	0.0003	0.0001	0.0001	0.0001	0.0002	0.0024	0.0012	0.0001
Үйлчилгээ	0.0003	0.0002	0.0003	0.0003	0.0002	0.0003	0.0003	0.0001
Бусад	0	0.0000	0.0000	0.0000	0.0023	0.0199	0.0032	0.0008

2010-2013 онуудад уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгч дотоодын нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгчээс давамгайл нөлөөтэй байна.

2010 онд цахилгаан ба дулаан, худалдаа, санхүү ба даатгалын салбарн дотоодын нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөр байсан бол 2011 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөр болсон байна. Орон сууцны салбарт 2010 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөр байсан бол 2011 оноос дотоодын нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөр болох хандлагатай болжээ.

³ Miller, Blair, 2009, p.246

Хөдөө аж ахуйн болон боловсруулах салбарт дотоодын нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгч гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгчээс байнга өндөр байна.

Зураг 7. Дотоодын болон ГШХО-ын үржүүлэгчдийн функциональ хамаарал, 2013 он



Эх сурвалж: судлаачийн тооцоолол

Зураг 7 хэвтээ тэнхлэгт дотоодын хөрөнгө оруулалт буюу хөрөнгийн нийт хуримтлалын үржүүлэгч, босоо тэнхлэгт гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгчийг сонгон хоёр үзүүлэлтийн функциональ хамаарлыг дүрслэн харууллаа. I мужид гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөртэй салбарууд агуулагдах ёстой. Гэвч ийм салбар байхгүй байна. Харин II мужид дотоодын хөрөнгө оруулалтын үржүүлэгч бага, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөртэй салбарууд байрлах бөгөөд манай улсын хувьд уул уурхай, олборлох үйлдвэрийн гадаадын шууд хөрөнгө оруулалтын үржүүлэгч бусад салбаруудаас харьцангуй дээгүүр байна. III мужид хоёр хөрөнгө оруулалтын үржүүлэгч багатай салбарууд агуулагдах ёстой бөгөөд олонхи салбаруудын дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын үржүүлэгч нэлээд доогуур байгаа нь харагдлаа. Харин IV мужид дотоодын хөрөнгө оруулалтын үржүүлэгч өндөр, гадаадын хөрөнгө оруулалтын үржүүлэгч багатай салбарууд байрлах ёстой. Монгол улсын барилгын салбарыг дотоодын хөрөнгө оруулалтаар сайн дэмжвэл дотоодын үйлдвэрлэлийг ихээхэн нэмэгдүүлэх боломж байдаг гэдгийг илэрхийлж байна. Харин уул уурхайн салбарыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дэмжих шаардлагатай нь дээрх үр дүн харуулж байна.

Бүх салбарын хөрөнгө оруулалтыг 10 хувиар өсгөвөл үржүүлэгч хэрхэн өөрчлөгдөх болон салбаруудын үйлдвэрлэлд хэдэн хувийн өсөлт бий болох вэ? гэдэг асуултын хариултыг Хүснэгт 17-аас харж болно. 2010 оны салбар хоорондын хүснэгтэд тулгуурлан шинжилсэн гэдгийг онцолж байна.

Хүснэгт 17. Хөрөнгө оруулалтын 10 хувийн өсөлтийн салбаруудад үзүүлэх нөлөө

Салбарууд	GFCF	Салбарын үйлдвэрлэлийн өөрчлөлт, сая төгрөг	Салбарын үйлдвэрлэлийн өсөлт, хувиар	2010 оны салбарын үйлдвэрлэл, сая төгрөг	Салбарын үйлдвэрлэл, сая төгрөг	Хөрөнгө оруулалтын эзлэх хувь	Хөрөнгө оруулалт 10 хувь өссөний дараах үржүүлэгч	2010 оны үржүүлэгч
1	346354.2	543956.2	31.15	1746393.3	2290350	0.151	0.232	0.299
2	940135	1043155	25.32	4120112.1	5163267	0.182	0.218	0.270
3	186817.4	447788.8	19.63	2281119.9	2728909	0.068	0.179	0.250
4	3123.435	102953.4	16.17	636759.3	739712.7	0.004	0.048	0.064
5	-472.08	19413.65	18.05	107582.8	126996.5	-0.004	0.003	0.006
6	917875.9	1057464	80.17	1319038.6	2376502	0.386	0.432	0.732
7	217182.3	419050.2	20.89	2005615.6	2424666	0.090	0.173	0.227
8	12639.27	144027.5	9.82	1467200.9	1611228	0.008	0.063	0.083
9	1235.64	19813.42	8.42	235449.8	255263.2	0.005	0.012	0.015
10	14689.5	65397.57	13.49	484964.7	550362.3	0.027	0.055	0.069
11	0	70050.79	18.92	370276.3	440327.1	0.000	0.034	0.046
12	656.88	29789.39	3.29	905346.3	935135.7	0.001	0.019	0.025
13	84012.6	124656.8	37.56	331912	456568.8	0.184	0.206	0.271
14	157.71	22624.01	12.78	177046.4	199670.4	0.001	0.011	0.015
15	0	44134.08	6.17	715101.3	759235.4	0.000	0.021	0.033
16	4.41	7295.848	1.29	564654.1	571949.9	0.000	0.004	0.005
17	3161.97	9863.992	3.22	306420.3	316284.3	0.010	0.013	0.014
18	90.09	2214.104	3.78	58648.6	60862.7	0.001	0.003	0.004
19	80.535	2994.111	3.45	86690.1	89684.21	0.001	0.002	0.003
20	0	0	0.00	103.8	103.8	0.000	0.000	0.000
Эдийн засгийн өсөлт, хувиар			16.7					

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

2015 онд эдийн засгийн өсөлтийг 10,2% байхаар төлөвлөсөн билээ. Харин шинжилгээний үр дүнгээс үзвэл бүх салбарын хөрөнгө оруулалтын 10 хувийн өсөлт нь эдийн засагт 16,7 хувийн өсөлтийг бий болгож байна.

Хөрөнгийн нийт капитал хуримтлал (GCF)-ын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө

$(I - A)^{-1}$ матриц нь аналитик болон урьдчилан таамаглалын симуляциудыг хийх боломжийг олгодог. Тухайлбал, эцсийн эрэлтийн өөрчлөлтийн үзүүлэх нөлөөг тодорхойлох асуудал энд багтаж болно. Нийгмийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэдэг гэдгийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөг авч үзэх болно. Салбарын түвшинд өгөгдсөн хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөтэй холбоотой асуудлууд урган гарч болох юм. Энэ нь хөрөнгө оруулалт буюу нийт тогтмол капиталын хуримтлалын өөрчлөлтөд гарц хэрхэн өөрчлөгдөх байдлаар хариу үйлдэл үзүүлж байна вэ? гэдэг асуултад хариулт өгөхөд хүргэдэг. Анхны таамаглал бол симуляци хийхтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хязгаарыг

хэрхэн тогтоох вэ? гэдэгт оршино. Бид хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хязгаарыг ± 5 байхаар сонгосон бөгөөд энэ нь эдийн засагт гарч буй өөрчлөлтийг тодорхойлоход хангалттай гэж үзсэн болно.

Хүснэгт 18. Салбар бүрийн хөрөнгийн нийт капитал хуримтлалын $\pm 5\%$ -ийн өөрчлөлтөд гарцын үзүүлж буй хариу үйлдэл

Салбарууд	2010		2011		2012		2013	
	5	-5	5	-5	5	-5	5	-5
ХАА	1.0069	0.9931	1.0157	0.9843	1.0174	0.9826	1.0228	0.9772
Уул уурхай	1.0007	0.9993	1.0087	0.9913	1.0120	0.9880	1.0094	0.9906
Боловсруулах	1.0039	0.9961	1.0088	0.9912	1.0082	0.9918	1.0075	0.9925
Цахилгаан	1.0012	0.9988	1.0073	0.9927	1.0083	0.9917	1.0090	0.9910
Усан хангамж	1.0015	0.9985	1.0080	0.9920	1.0100	0.9900	1.0090	0.9910
Барилга	1.008	0.9920	1.0437	0.9563	1.0421	0.9579	1.0430	0.9570
Бөөний	1.0011	0.9989	1.0134	0.9866	1.0143	0.9857	1.0165	0.9835
Тээвэр	1.0012	0.9988	1.0049	0.9951	1.0056	0.9944	1.0076	0.9924
Зочид буудал	1.0009	0.9991	1.0055	0.9945	1.0037	0.9963	1.0055	0.9945
Мэдээлэл	1.002	0.9980	1.0068	0.9932	1.0075	0.9925	1.0069	0.9931
Санхүү	1.0013	0.9987	1.0097	0.9903	1.0118	0.9882	1.0131	0.9869
Үл хөдлөх	1.0009	0.9991	1.0020	0.9980	1.0021	0.9979	1.0025	0.9975
Мэргэжлийн	1.0042	0.9958	1.0131	0.9869	1.0154	0.9846	1.0082	0.9918
Удирдлага	1.0014	0.9986	1.0075	0.9925	1.0061	0.9939	1.0071	0.9929
Төрийн удирдлага	1.0016	0.9984	1.0030	0.9970	1.0016	0.9984	1.0016	0.9984
Боловсрол	1.0004	0.9996	1.0002	0.9998	1.0003	0.9997	1.0002	0.9998
Эрүүл мэнд	1.001	0.9990	1.0016	0.9984	1.0016	0.9984	1.0016	0.9984
Урлаг	1.0008	0.9992	1.0010	0.9990	1.0010	0.9990	1.0009	0.9991
Үйлчилгээ	1.0008	0.9992	1.0006	0.9994	1.0012	0.9988	1.0011	0.9989
Үйл ажиллагаа	1	1.0000	1.0000	1.0000	1.0000	1.0000	1.0000	1.0000
Нийт	1.0015	0.9985	1.0116	0.9884	1.0135	0.9865	1.0137	0.9863

Эх сурвалж: судлаачийн тооцоолол


Симуялцийг орц-гарцын загварт тулгуурлан хийх ба анхны өгөгдөлтэй харьцуулах замаар үнэлэлт өгөх болно. Нийт тогтмол капиталын хуримтлалын өөрчлөлтөд гарц хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг дараах хүснэгтээс харж болох юм.

2010-2013 онуудын салбаруудын задаргаан дахь хөрөнгийн нийт капитал хуримтлалыг 5 хувиар өсгөсөн тохиолдолд нийт эдийн засагт 2010 онд 0,15%, 2011 онд 1,16%, 2012 онд 1,35%, 1,37%-ийн өсөлтийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, монгол улсын хөрөнгийн нийт капитал хуримтлалын түвшин жил бүр нэмэгдсэн учраас эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө өссөөр байгааг харж болох юм.

Үүнээс гадна 2010 онд ХАА, боловсруулах зэрэг салбарууд харгалзан 0,69%, 0,39% хувиар өсөх замаар хөрөнгийн нийт капитал хуримтлалын 5%-ийн өсөлтөд хариу үйлдэл үзүүлж байна.


ХАА, уул уурхай, усан хангамж, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашин засвар, санхүү, мэргэжлийн удирдлага зэрэг салбаруудын гарц өндөр өсөлттэйгөөр хариу үйлдэл үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс гарч байна.

Хүснэгт 19. GCF-ийн 5%-ийн өсөлтөд өндөр өсөлттэйгээр хариу үйлдэл үзүүлж буй салбарууд, хувиар



Эх сурвалж: судлаачийн тооцоолол

Хүснэгт 20. GCF-ийн 5%-ийн өсөлтөд харьцангуй доогуур өсөлттэйгээр хариу үйлдэл үзүүлж буй салбарууд, хувиар



Эх сурвалж: судлаачийн тооцоолол

Үр дүн

Монгол Улсын эдийн засагт ГШХО-ын үзүүлэх нөлөөг салбар хоорондын балансад тулгуурлан шинжлэхэд дараах хүснэгтэд үзүүлсэн үр дүн гарлаа.

Хүснэгт 21. ГШХО болон нийт хөрөнгө оруулалтын үржүүлэгч

№	Салбарууд	ГШХО-оос хамааралтай	Дотоодын Хөрөнгө оруулалтаас хамааралтай	ГШХО-оос хамааралтай болсон
1	ХАА, ойн ба загасны аж ахуй			
2	Уул уурхай, олборлох аж үйлдвэр			
3	Боловсруулах аж үйлдвэр			
4	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл			
5	Усан хангамж, хог хаягдлын менежмент			
6	Барилга			
7	Бөөний ба жижиглэнгийн худалдаа, автомашин засвар			
8	Тээвэр, агуулах			
9	Орон сууц, хүнсний үйлчилгээ			
10	Мэдээлэл, харилцаа холбоо			
11	Санхүү ба даатгалын үйл ажиллагаа			
12	Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа			
13	Мэргэжлийн, ШУ, техникийн үйл ажиллагаа			
14	Захиргааны дэмжлэг үйлчилгээ			
15	Төрийн захиргаа, батлан хамгаалах			
16	Боловсрол			
17	Эрүүл мэнд, нийгмийн ажил			
18	Урлаг, үзвэр, амралт, чөлөөт цаг			
19	Бусад үйлчилгээ			
20	Бусад үйл ажиллагаа			

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Цахилгаан дулааны салбар ГШХО-оос хамаарч байна. 2010 оны байдлаар хөдөө аж ахуй, ойн ба загасны аж ахуй, уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийн болон бусад ихэнх салбарууд дотоодын нийт хөрөнгө оруулалтаас хамааралтай байсан бол 2011 оноос ГШХО-оос хамааралтай болсон байна.

Эцсийн эрэлтээс уул уурхай, олборлох үйлдвэрийн хамаарах хамаарлыг судлахад дараах үр дүнг гарч байна. Үүнд:

- Уул уурхайн салбар нь уул уурхайн салбарын экспортын эцсийн эрэлтээс 75-82%-иар хамаардаг.
- Цахилгаан дулааны үйлдвэрлэлийн эцсийн хэрэглээнээс 91-97 хувиар хамаардаг.
- Тээвэр, агуулахын болон мэргэжлийн шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны экспортын эцсийн эрэлтээс хамаарах хамаарал өссөөр байна.
- Хөдөө аж ахуйн эцсийн хэрэглээний болон экспортын эцсийн эрэлтээс хамаарах хамаарал буурч харин хөдөө аж ахуйд оруулж буй хөрөнгө

- оруулалтын эцсийн эрэлтээс ихээхэн хамааралтай болсоор байна.
- Бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашин засварын эцсийн хэрэглээний эрэлт, экспортын эрэлтээс ижил түвшинд хамаардаг, гэвч уг салбарын хөрөнгө оруулалтаас хамаарах хамаарал нэмэгдсээр байна.
 - 2010, 2011, 2012, 2013 онуудад нийт гарц харгалзан 0,15%, 1,16%, 1,35%, 1,37%-иар өсөх байдлаар хариу үйлдэл үзүүлж байна.
 - ХАА, уул уурхай, барилга, бөөний ба жижиглэнгийн худалдаа, автомашин засвар, санхүү ба даатгал, мэргэжлийн удирдлага зэрэг салбарууд өндөр өсөлттэйгөөр хариу үйлдэл үзүүлж байв.
 - 2010 оныг үл харгалзвал барилгын салбар жигд өсөх байдлаар хариу үйлдэл үзүүлж байна.

ГШХО-Д НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Байршил нь ГШХО-ыг татах чухал зүйлсийн нэг мөн хэмээн Даннин (Dunning, 1993) үзсэн. Шац, Винаблес (Shatz & Venables, 2000) нар ГШХО-ыг босоо болон хэвтээ хэмээн хоёр хэлбэрт ангилсан. Үндэстэн дамнасан корпораци (ҮДК) үйлдвэрлэлийн процессоо олон улсад тархааж үе шат бүрийг өөр улсад байрлуулах нь босоо ГШХО юм. Энэ нь хөдөлмөрийн ур чадварын ялгаа, түүхий эд материал, завсрын бүтээгдэхүүн, мэдлэгийн дам нөлөө зэрэг хүчин зүйлсийн хувьд үйлдвэрлэлийн зардлаа бууруулах сонирхлоос голчлон үүднэ. Босоо ГШХО нь бүтээгдэхүүний үе шат бүрийн хооронд зөөх шаардлага үүсгэдэг тул ихэвчлэн гадаад худалдааг бий болгож байдаг. Ижил үйл ажиллагааг өөр улсуудад явуулахыг хэвтээ ГШХО гэдэг. Тээврийн зардал, тарифын зардлыг багасгах, тухайн зах зээл дэх пүүсийн өрсөлдөөний байр суурийг нэмэгдүүлэх зорилгоор хэвтээ ГШХО-ыг хийх талтай. Энэ хэлбэрийн ГШХО нь ихэвчлэн тухайн орон нутгийн зах зээлд үйлчлэх зорилготой гадаад худалдааг орлодог (Shatz & Venables, 2000).

Нэг үйлдвэр нь аль аль зорилгыг гүйцэлдүүлдэг бол босоо болон хэвтээ ГШХО-ын хооронд ялгахад хүндрэлтэй болдог (Shatz & Venables, 2000). Түүнчлэн гадаадад үйлдвэрлэх шалтгаан хугацааны явцад өөрчлөгдөж болно (Dunning, 1993). Бүхий л ГШХО нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх ерөнхий стратегийн бүрдэл хэсэг гэж үзвэл ялгаатай хэлбэрийн ГШХО-уудын хоорондын ялгаа бүдгэрч ирдэг. Тус стратеги нь тийнхүү байршлын тодорхойлогч хүчин зүйлийг нэг утгатайгаар тодорхойлох асуудлыг хүндрэлтэй болгодог (Noorbakhsh, Paloni, & Youssef, 2001).

ГШХО-ын байршилтай холбоотой тодорхойлогч хүчин зүйлсийн талаарх судалгаанууд үйлдвэрлэлийн зардал, дэд бүтэц, хүн капитал, валютын ханш, зах зээлийн хэмжээ зэрэг ГШХО-нд нөлөөлөх цөөн хувьсагчдыг санал болгодог. Зарим хүчин зүйлс нь бүх хэлбэрийн ГШХО-нд нөлөөлөх талтай. Хэдий тийм боловч босоо болон хэвтээ ГШХО хийх стратегийн зорилгууд хоорондоо ялгаатай байдаг тул зарим хүчин зүйлс нь тухайн хэлбэрийн ГШХО-нд бусад

хэлбэрийн ГШХО-нд үзүүлэх нөлөөллөөсөө илүүгээр нөлөөлдөг байж болох юм (Ewe-Ghee, 2001).

Үйлдвэрлэлийн зардал бага байх тусам ГШХО хийхэд илүү таатай болно. Тиймээс цалингийн зардал болон ГШХО-ын хооронд сөрөг хамаарал байна. Гэвч тус хамаарлын ач холбогдлын талаар эмпирик үр дүн янз бүр байдаг (Billington, 1999), (Ewe-Ghee, 2001). Чен, Кван (Cheng & Kwan, 2000) нар бодит цалингийн зардал нь Хятад дахь ГШХО-нд сөргөөр нөлөөлж байгааг харуулсан. Хүүний түвшин нь хөрөнгийн зардлын хэмжүүр билээ. Хүүний түвшин өндөр байх нь хөрөнгө оруулалтын зардлыг өсгөх тул хүүний түвшин болон ГШХО нь сөрөг хамааралтай байна. Лав, Леж-Хидалго (Love & Lage-Hidalgo, 2000), Ердал, Татогл (Erdal & Tatoglu, 2002) нарын судалгаагаар хүүний түвшин өсөх нь ГШХО-ыг бууруулж байгаа нь харагдсан.

Хөрөнгө хүлээн авагч улсын дэд бүтэц сайн байх нь ГШХО-нд таатай нөлөө үзүүлнэ. Дэд бүтэц сайн байснаар үйлдвэрлэлийн болон эцсийн бүтээгдэхүүнийг түгээх үйл ажиллагааг хөнгөвчилж өгдөг. Тиймээс дэд бүтэц болон ГШХО-ын хоорондын хамаарал эерэг байна. Гэвч дэд бүтцийг бүрэн илэрхийлэх үзүүлэлт байдаггүй. Харин тээвэр, холбооны чанарыг төлөөлөх үзүүлэлтүүдийг ихэвчлэн ашигладаг. Ихэнх эмпирик судалгааны ажлуудад дэд бүтцийг төлөөлөх хувьсагч болон ГШХО нь өндөр ач холбогдол бүхий эерэг хамааралтай болох нь харагдсан (Billington, 1999), (Cheng & Kwan, 2000).

Хүн капитал сайн байх тусам ГШХО хийх нь илүү ашигтай байдаг. Хөрөнгө хүлээн авагч улсын хүн капитал нь түүн рүү орох ГШХО-ын тодорхойлогч болох талаар онолын үндэслэл байдаг. Жишээлбэл, хөгжиж буй орнууд дахь хүн капиталын хомсдол нь тэдгээр орон дахь гадаадын хөрөнгө оруулалтыг хойш нь татдаг гэж Лукас (Lucas, 1990) үзсэн. Хөрөнгө хүлээн авагч улсын ур чадвар бүхий хөдөлмөрийн олоцтой байдал нь ҮДК-ийн чухал шаардлага бөгөөд энэ нь ГШХО-ын хэмжээнд нөлөөлдөг болохыг харуулсан загварыг гаргаж ирсэн. Хөдөлмөр ур чадвар, боловсролын түвшин нь тухайн улс дахь ГШХО-ын хэмжээ болон ҮДК-ийн тухайн улсад хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаанд нөлөөлж байдаг хэмээн Даннинг (Dunning, 1993) үзсэн (Noorbakhsh, Paloni, & Youssef, 2001). Тийнхүү хүн капитал болон ГШХО-ын хоорондын хамаарал эерэг байна. Ноорбакш, Палони, Иосеф (Noorbakhsh, Paloni, & Youssef, 2001) нарын судалгаагаар хүн капитал нь ГШХО-нд нэлээдгүй эерэг нөлөөтэй бөгөөд энэхүү нөлөө хугацаа өнгөрөх тусам улам чухал болж байгаа нь харагдсан. Чен, Кван (Cheng & Kwan, 2000) нарын судалгаагаар хүн капиталын Хятад дахь ГШХО-нд үзүүлэх нөлөө эерэг боловч ач холбогдолгүй байв.

Хөрөнгө оруулагч пүүсийн гадаадаас худалдаж авах хөрөнгийн зардалд үзүүлэх нөлөөгөөр дамжин валютын ханшийн хөдөлгөөн нь ГШХО-нд нөлөөлж байдаг (Froot & Stein, 1991). Тухайлбал, тухайн улс дахь валютын ханш чангарснаар тухайн улсаас худалдан авах хөрөнгийн зардлыг өсгөх тул ГШХО-нд нь сөргөөр нөлөөлнө (Love & Lage-Hidalgo, 2000), (Erdal & Tatoglu, 2002). Ердал, Татогл

(Erdal & Tatoglu, 2002) нарын судалгаагаар валютын ханш нь ГШХО-нд сөрөг нөлөөтэй болох нь харагдсан.

Ерөнхийдөө хөрөнгө хүлээн авагч улсын зах зээлийн хэмжээ том байх тусам ГШХО-нд илүү таатай байдаг. Том зах зээл нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт их байх нөхцөл бөгөөд өргөжилтийн хэмнэлт хүртэх боломж олгодог (Caves, 1971), (Erdal & Tatoglu, 2002) тул хэвтээ ГШХО-нд эерэг нөлөөтэй. Гэвч босоо ГШХО нь хөрөнгө хүлээн авагч улсын зах зээлийн хэмжээнээс хамаарахгүй. Тийнхүү ГШХО болон зах зээлийн хэмжээний хоорондын хамаарал эерэг байна (Ewe-Ghee, 2001). Мөн ҮДК-ийн зах зээлийн хэмжээний талаарх ойлголт нь хөрөнгө хүлээн авагч улсын өсөлтийн түвшинтэй холбоотой байж болно. Ихэнх судалгаагаар БДНБ, НХНБДНБ-ээр төлөөлүүлсэн зах зээлийн хэмжээ нь ГШХО-нд эерэг нөлөөтэй болох нь харагдсан (Billington, 1999), (Cheng & Kwan, 2000), (Shatz & Venables, 2000). Энэ нь нэг талаараа дэлхийн ихэнх ГШХО нь хэвтээ хэлбэр байдагтай холбоотой юм (Ewe-Ghee, 2001).

Дээр дурдсан хувьсагчдаас гадна хөшүүрэг (мөнгөний болон сангийн), эдийн засгийн тусгай бүс (чөлөөт худалдаа, экспорт бэлтгэх бүх г.м), бизнес, хөрөнгө оруулалтын орчин, тээврийн зардал, улс төрийн тогтвортой байдал зэрэг хувьсагчид ГШХО-нд нөлөөлж болохыг судалгаачид дурддаг (Noorbakhsh, Paloni, & Youssef, 2001). Гэвч эдгээр хүчин зүйлс нь эмпирикээр авч үзэхэд хүндрэлтэй байдаг.

ГШХО-ын тодорхойлогч хүчин зүйлсийн талаарх ихэнх судалгаанууд хөндлөн болон панел өгөгдөл ашиглах хандлагатай байдаг. Гэсэн хэдий ч хугацааны цуваан өгөгдлийг ашигласан судалгаанууд байдаг (Yang & Groenewold, 2000), (Love & Lage-Hidalgo, 2000), (Erdal & Tatoglu, 2002). Янг, Гроенволд (Yang & Groenewold, 2000) нар 1985-94 оны хоорондох улирлын өгөгдөл ашиглан Австрали дахь ГШХО-ын тодорхойлогчдыг шинжилсэн. ГШХО-ыг хүүний түвшин, БДНБ, валютын ханш, эдийн засгийн нээлттэй байдал, хөдөлмөрийн маргааны хэмжигдэхүүн, цалингийн зардлаас хамааруулсан. Хүүний түвшин, цалингийн зардал, эдийн засгийн нээлттэй байдал, хөдөлмөрийн маргааны хэмжигдэхүүн нь Австрали дахь ГШХО-ын чухал тодорхойлогч болох нь харагдсан. Тус загвар нь түүвэр дэх хөдөлгөөнийг сайн тайлбарлаж байсан бөгөөд түүврийн эхэн үед илүү сайн байсан.

Ердагл, Татогл (Erdal & Tatoglu, 2002) болон Лав, Леж-Хидалго (Love & Lage-Hidalgo, 2000) нар судалгаандаа коинтегрейшний шинжилгээг ашигласан. Ердагл, Татогл (Erdal & Tatoglu, 2002) судалгаандаа 1980-1998 оны хоорондох жилийн өгөгдөл ашиглан Турк дэх ГШХО-ын тодорхойлогчдыг шинжилсэн. Зах зээлийн хэмжээ, дэд бүтэц, эдийн засгийн нээлттэй байдал нь ГШХО-ыг татсан бол валютын ханш, эдийн засгийн тогтворгүй байдал нь сөргөөр нөлөөлсөн болох нь харагдсан. Лав, Леж-Хидалго (Love & Lage-Hidalgo, 2000) нар судалгаандаа ГШХО-ын байршилтай холбоотой тодорхойлогч хүчин

зүйлсийн энгийн загварыг боловсруулж АНУ-аас Мексик рүү хийсэн ГШХО дээр 1967-1994 оны хоорондох жилийн өгөгдөл ашиглан шалгасан. Дотоодын эрэлт, хүчин зүйлсийн харьцангуй өртөг нь ГШХО-ын чухал тодорхойлогч болох нь харагдсан бөгөөд энэ нь зах зээлийн хэмжээ болон хямд хөдөлмөрийн таамаглалыг дэмжиж байгаа юм. Загварын богино хугацааны хамаарлаас валютын ханш нь хөрөнгө оруулалтын хугацааны шийдвэрт нөлөөлдөг болох нь харагдсан.

Арга зүй

ГШХО нь хөрөнгө хүлээн авагч улсын валютын ханш, зах зээлийн хэмжээ, байгалийн баялагыг хэмжээ, үнийн түвшин зэрэг үзүүлэлтээр тайлбарлагдах боломжтой байдаг. Үүний тулд дараах тэгшитгэлийг үнэлнэ.

$$\ln FDI_t = \beta_{10} + \beta_{11} \ln RGDP_t + \beta_{12} \ln EXR_t + \beta_{13} \ln CPI_t + \beta_{14} \ln NAT_t + u_{1,t} \quad (1)$$

Энд \ln -натураль логарифм, FDI_t -ГШХО, CPI_t -үйлдвэрлэлийн зардлыг төлөөлсөн үзүүлэлт буюу үнийн түвшин, EXR_t -төгрөгийн бусад валюттай харьцах нэрлэсэн ханш, $RGDP_t$ -зах зээлийн хэмжээг төлөөлсөн бодит ДНБ, NAT_t -нийт эскпортод уул уурхай гаралтай бүтээгдэхүүний эзлэх хувь, $u_{i,t}$ ($i = 1, 2$)-санамсаргүй хүчин зүйлс болно.

Хуурмаг хамаарал (spurious regression)-аас зайлсхийхийн тулд эмпирик үнэлгээний эхэнд нэгж язгуурын тест хийе. Үүний тулд Дики-Фюллер (Dickey & Fuller, 1979) болон Филлипс-Перроны (Phillips & Perron, 1988) нэгж язгуурын тестүүдийг ашиглая. Ижил эрэмбийн интегретед цуваанууд коинтегретед байж болохыг Энгле-Гранжер (Engle & Granger, 1987) дурдсан байдаг. Коинтегретед цуваанууд нь богино хугацаанд бие биенээсээ холдож болох хэдий ч урт хугацаанд тэдгээрийн хоорондын зай тогтмол эсвэл стационарь процесс байдаг. ($n \times 1$) цуваануудаас бүрдэх y_t векторын бүх цуваа нь ижил эрэмбийн интегретед бол түүнийг коинтегретед гэнэ. Тус вектор болон коинтегретийн ($n \times 1$) хэмжээст α' векторын шугаман эвлүүлэг α' y_t нь стационарь буюу 0 эрэмбийн интегретед үзүүлэлт байдаг.

Тэгшитгэл (1а) дахь коинтегретийн үүсгэгч векторын тоог шалгахын тулд Иохансений коинтегретийн (Johansen cointegration) аргачлалыг ашиглана. Систем дэх коинтегретийн үүсгэгч векторын тоог шалгахад хэрэглэгдэх *хамгийн их хувийн утга, мөр* гэсэн хоёр төрлийн үнэний хувь бүхий харьцааг тооцоолоход Иохансений коинтегретийн аргыг ашиглана. Эдгээр харьцааг дараах байдлаар тооцно.

$$\lambda_{Max} = -T \ln(1 - \lambda_{r+1}), \quad r = 0, 1, 2, \dots, p - 1 \quad (2)$$

$$\lambda_{Trace} = -T \sum_{i=r+1}^p \ln(1 - \lambda_i), \quad r = 0, 1, 2, \dots, p - 1 \quad (3)$$

Энд T -түүврийн хэмжээ, $\lambda_i (i = 0, 1, 2, \dots, p; \lambda_1 > \lambda_2 \dots \lambda_p)$ хувийн утга болно. λ_{Max} тест нь r ширхэг коинтегрейшний вектортой гэсэн H_0 таамаглалын эсрэг $r + 1$ коинтегрейшний вектортой гэсэн H_a таамаглалыг шалгахад ашиглана. Өөрөөр хэлбэл тус тестийн хувьд шалгаж үзэх үндсэн таамаглал дараах дарааллаар явагдана. $H_0 : r = 0$ -г $H_a : r = 1$ -ийн эсрэг; $H_0 : r \leq 1$ -г $H_a : r = 2$ -ын эсрэг; ... ; $H_0 : r \leq p - 1$ -г $H_a : r = p$ -ийн эсрэг гэх мэт. Тухайлбал, $H_0 : r = 0$ таамаглал 95%-ийн итгэх түвшний хувьд үгүйсгэгдэж $H_0 : r \leq 1, \dots, H_0 : r \leq p-1$ нь үгүйсгэгдээгүй бол λ_{Max} тестийн хувьд коинтегрейшний нэг вектор байх юм. λ_{Trace} тест нь системд хамгийн ихдээ r ширхэг коинтегрейшний вектор байна гэсэн таамаглалыг шалгадаг. Тус тестийн хувьд шалгаж үзэх үндсэн таамаглал нь дараах дарааллаар явагдана. $H_0 : r = 0$ -ийг $H_a : r \geq 1$ -ийн эсрэг; $H_0 : r \leq 1$ -ийг $H_a : r \geq 2$ -ийн эсрэг, $H_0 : r \leq p - 1$ -ийг $H_a : r = p$ -ийн эсрэг гэх мэт. Тухайлбал $H_0 : r = 0$ таамаглал 95%-ийн итгэх түвшний хувьд үгүйсгэгдэж $H_0 : r \leq 1, \dots, H_0 : r \leq p-1$ нь үгүйсгэгдээгүй бол λ_{Trace} тестийн хувьд хамгийн багадаа коинтегрейшний нэг вектор байх юм.

Филлипс, Перрон (Phillips & Perron, 1988) нар урт хугацааны хамаарлын асимптот үр ашигтай үнэлгээний хэд хэдэн хандлагыг тоймлон авч үзсэн. Нэгж язгууртай үед ХБК-ын үнэлэгч зэрэг уламжлалт аргууд нь асимптот гажуудал, үр ашиггүй байдал, стандарт бус асимптотын тархалт зэргээс шалтгаалан дүгнэлт гаргахад тохиромжгүй байдгийг онцолсон. Манай судалгааны хувьд богино хугацааны бус урт хугацааны хамаарлыг сонирхож байгаа. Тиймээс Филлипс-Хансений (Phillips & Hansen, 1990) FMLS үнэлэгчийг ашиглана. Тус үнэлэгч нь эндожинеити байсан ч нийцтэй бөгөөд асимптот үр ашигтай байдаг (Lynde & Richmond, 1993). Мөн төгсгөлөг түүвэрт сайн үр дүнтэй байжээ (Phillips & Hansen, 1990).

Өгөгдөл

Судалгааны түүврийн хугацаагаар өгөгдлийн олдцоос хамааран 2000-2014 оны хоорондох улирлын тоон мэдээллийг ашигасан. ГШХО (FDI_t)-аар нийт цэвэр орох ГШХО-ын хэмжээний улирлын нөлөөллийг засварласан дүнг авсан. Үнийн түвшинг (CPI_t)-ийг ХҮИ-р тооцсон. Бодит ДНБ ($RGDP_t$)-ээр улирлын нөлөөллийг хасч авч үзсэн бол валютын ханшаар (EXR_t)-аар төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийг авч үзсэн. Байгалийн баялагыг (NAT_t)-аар нийт экспортод байгалийн баялагын экспортын эзлэх хувиар авч үзсэн. Бүх хувьсагчдын логарифмчилсон болно.

Хүснэгт 27. Дики-Фюллер, Филлипс-Перроны нэгж язгуурын тестийн үр дүн

	$t\gamma$ -трендгүй	$Z(t\gamma)$ -трендгүй	
$\ln FDI_t$	-1.45	-1.01	I(1)
$\Delta \ln FDI_t$	-7.37	-16.56	
$\ln CPI_t$	1.29	1.11	I(1)
$\Delta \ln CPI_t$	-6.09	-6.16	
$\ln RGDP_t$	0.12	0.956	I(1)
$\Delta \ln RGDP_t$	-8.73	-9.28	

$\ln EXR_t$	-1.18	-1.28	I(1)
$\Delta \ln EXR_t$	-6.41	-6.42	
$\ln NAT_t$	-2.51	-2.43	I(1)
$\Delta \ln NAT_t$	-10.16	-20.36	

Жич: \ln -натурал логарифм, Δ -1-р эрэмбийн ялгавар, t_γ -Дики-Фюллерийн t статистик, $Z(t_\gamma)$ -Филлипс-Перроны t статистик. Дрифттэй (трендгүй) $t_\gamma(Z(t_\gamma))$ -ийн 25 түүвэртэй үеийн 1% болон 5%-ийн ач холбогдлын түвшний критик утга нь харгалзан -3.72, -2.99 болно.

Үр дүн

Дики-Фюллер, Филлипс-Перроны нэгж язгуурын статистикуудыг Хүснэгт 27-д харууллаа. Дики-Фюллерийн статистикуудыг тооцоход ашигласан хожимдлын утгыг АИС шинжүүрээр тодорхойлсон. Нэгж язгуурын хоёр тестийн үр дүнгээс бүх хувьсагчид нь түвшний хувьд стационар биш боловч нэгдүгээр эрэмбийн ялгавар авсаны дараагаар стационар болж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, ГШХО, бодит ДНБ, үнийн түвшин (ХҮИ), валютын ханш, нийт экспортод уул уурхайн экспортын эзлэх дүн зэрэг нь нэгдүгээр эрэмбийн интегрейted үзүүлэлтүүд байна. Ижил эрэмбийн интегрейted үзүүлэлтүүд коинтегрейted байх боломжтой. Тэгвэл одоо коинтегрейшний тест хийе.

Хүснэгт 28. Иохансений үнэний хувь бүхий харьцааны статистикийн үр дүн

H_0 :	$r = 0$	$r \leq 1$	$r \leq 2$	$r \leq 3$	$r \leq 4$	
Maximum eigenvalue test						
	λ_{Max} статистик	37.94449	23.41491	11.59125	8.742223	0.952304
критик утга	33.87687	27.58434	21.13162	14.26460	3.841466	
Trace test						
	λ_{Trace} статистик	82.64518	44.70069	21.28578	9.694527	0.952304
критик утга	69.81889	47.85613	29.79707	15.49471	3.841466	

Жич: Загварын оновчтой хэмжээг АИС шинжүүрээр шалгах замаар VAR загвараар үнэлсэн.

Иохансений коинтегрейшний аргын үр дүнг Хүснэгт 1-д харууллаа. λ_{Max} , λ_{Trace} статистикуудыг огтлолцын коэффициентын хязгаарлалтгүй, трендгүйгээр тооцсон. Хоёр загварын хувьд λ_{Max} , λ_{Trace} тестүүдийн үр дүнгээс $H_0 : r = 0$ таамаглал 5%-ийн түвшинд үгүйсгэгдэж $H_0 : r \leq 1, r \leq 2, r \leq 3, r \leq 4, r \leq 5$ таамаглалууд үгүйсгэгдэхгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь үнэлэгдсэн загвар бүрийн хувьд **нэг коинтегрейшний вектор** оршин байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл ГШХО болон түүний тодорхойлогчдын хооронд урт хугацааны хамаарал байгаа юм. Одоо үнэлгээг VECM (Vector error correction model)-ын тусламжтай үнэлгээг гүйцэтгэе:

Хүснэгт 24. VECM үнэлгээний үр дүн

Vector Error Correction Estimates

Date: 06/29/15 Time: 07:16

Sample (adjusted): 2000Q3 2012Q4

Included observations: 50 after adjustments

Standard errors in () & t-statistics in []

Cointegrating Eq:	CointEq1				
LN_FDI (-1)	1.000000				
LOG_RGDP(-1)	-9.612688 (2.50120) [-3.84323]				
LOG_EXR(-1)	-8.535962 (3.00283) [-2.84264]				
LOG_CPI_SA(-1)	3.520351 (2.38079) [1.47865]				
LOG_NAT(-1)	3.593211 (0.62722) [5.72878]				
C	113.3140				

Error Correction:	D(LN_FDI)	D(LOG_RGDP)	D(LOG_EXR)	D(LOG_CPI)	D(LOG_NAT)
CointEq1	-0.227401 (0.10776) [-2.11029]	0.009054 (0.00658) [1.37675]	0.006934 (0.00639) [1.08559]	0.011139 (0.00488) [2.28301]	-0.163892 (0.03706) [-4.42229]
D(LN_FDI_ADJ(-1))	-0.365801 (0.14078) [-2.59833]	0.008745 (0.00859) [1.01785]	-0.009910 (0.00835) [-1.18743]	-0.003532 (0.00637) [-0.55414]	0.194198 (0.04842) [4.01082]
D(LOG_RGDP(-1))	-4.891750 (2.30725) [-2.12017]	-0.179598 (0.14080) [-1.27554]	-0.059973 (0.13677) [-0.43850]	-0.010514 (0.10447) [-0.10064]	-1.084859 (0.79351) [-1.36716]
D(LOG_EXR(-1))	-5.306980 (2.68218) [-1.97861]	0.002144 (0.16368) [0.01310]	0.085121 (0.15899) [0.53537]	-0.040550 (0.12145) [-0.33389]	-0.524552 (0.92246) [-0.56864]

D(LOG_CPI_SA(-1))	3.325179 (3.47908) [0.95576]	0.017792 (0.21231) [0.08380]	0.072340 (0.20623) [0.35077]	-0.003723 (0.15753) [-0.02363]	2.336960 (1.19653) [1.95311]
D(LOG_NAT(-1))	0.475270 (0.37516) [1.26685]	-0.060816 (0.02289) [-2.65638]	-0.017674 (0.02224) [-0.79472]	-0.025079 (0.01699) [-1.47636]	0.021626 (0.12903) [0.16761]
C	0.172199 (0.12654) [1.36081]	0.023586 (0.00772) [3.05426]	0.006103 (0.00750) [0.81355]	0.022916 (0.00573) [3.99943]	-0.019280 (0.04352) [-0.44301]
R-squared	0.346315	0.260053	0.077467	0.144445	0.441804
Adj. R-squared	0.255103	0.156804	-0.051259	0.025065	0.363916
Sum sq. resid	15.18737	0.056560	0.053367	0.031137	1.796398
S.E. equation	0.594302	0.036268	0.035229	0.026909	0.204393
F-statistic	3.796815	2.518709	0.601796	1.209960	5.672308
Log likelihood	-41.15795	98.66519	100.1178	113.5876	12.20907
Akaike AIC	1.926318	-3.666608	-3.724711	-4.263504	-0.208363
Schwarz SC	2.194001	-3.398924	-3.457028	-3.995821	0.059321
Mean dependent	0.092200	0.020255	0.005733	0.021807	0.024131
S.D. dependent	0.688587	0.039496	0.034359	0.027253	0.256277
Determinant resid covariance (dof adj.)		1.06E-11			
Determinant resid covariance		5.00E-12			
Log likelihood		295.8007			
Akaike information criterion		-10.23203			
Schwarz criterion		-8.702410			

Үнэлгээний үр дүнг Хүснэгт 29-д харууллаа. Загварт үнийн түвшнээс бусад бүх тайлбарлагч хувьсагчид 1% болон 5%-ийн түвшинд статистикийн ач холбогдолтой байна.

Урт хугацааны хамаарал

Тэгшитгэлийн үр дүнгээс урт хугацааны ко-интеграциг буюу **тэнцвэрийн хамаарал** дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ.

$$\ln FDI_t = -113 + 9.6 \cdot \ln RGDP_t + 8.5 \cdot \ln EXR_t - 3.6 \cdot \ln NAT_t + u_{1,t} \quad (1)$$

[3.84]
[2.84]
[-5.73]

Тэгшитгэлийн үр дүнгээс харахад бодит ДНБ болон төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш ГШХО-тай **урт хугацаанд эерэг** хамааралтай бол байгалийн баялаг сөрөг хамааралтай байдаг нь тогтоогдлоо. Урт хугацаанд бодит ДНБ 1%-иар өсөх нь ГШХО-ыг 9.6%-иар, нэрлэсэн ханш 1%-иар өсөх (сулрах)

нь ГШХО-ыг 8.5-иар өсгөдөг. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах нь ам.доллар болон бусад валютаар хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагч нарт ханшийн дахин үнэлгээний ашиг олох боломжийг олгодог. Иймд ГШХО болон нэрлэсэн ханшийн хооронд урт хугацааны эерэг хамаарал оршин байдаг байна.

Харин нийт экспортод уул уурхайн экспортын эзлэх хэмжээ (байгалийн баялаг) нэмэгдэх нь урт хугацаанд ГШХО-ын эзлэх хэмжээг бууруулдаг нь судалгаагаар харагдлаа. Ezeoha ба Cattaneo (2011), Asiedu (2002) нарын судалгааны үр дүнгээр Африкийн орнуудад байгалийн баялаг нь ГШХО-ыг татах хамгийн гол үзүүлэлт болдог гэж гарсан байдаг.

Гэвч Roelhekke ба van der Ploeg (2010) нарын судалгааны үр дүнгээр Африкийн орнуудын хувьд урт хугацаанд байгалийн баялаг болон ГШХО-ын хооронд сөрөг хамаарал ажиглагдсан байдаг. Энэхүү судалгааны үр дүнгээр баялагын нөөц ашиглалт болон гадаадын хөрөнгө оруулагч ба засгийн газрын зарцуулалт нь нээлттэй бус орчинд байгалийн баялаг ашигласны төлбөрийг иргэдийн зарцуулалтанд хуваарилах дээр зардал төсөвлөхийн тулд тухайн улсын удирдлага (ruling elite) нь гадаадын хөрөнгө оруулагч нартай нэгдсэн нөхцөлд урт хугацаанд ГШХО гадагшилдаг гэдгийг тогтоосон. Түүнчлэн Durnev and Guriev (2007) судалгаагаар дээрмийн шинжтэй (predatory) засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдыг улам бүр нээлттэй бус бөгөөд үр ашиггүй болгоход хүргэдэг гэдэг үр дүн гарсан байдаг. Энэхүү үр дүн нь ялангуяа орлого нь нефтийн үнэтэй өндөр коррляцтай байдаг аж үйлдвэрийн салбарт хүчтэй ажиглагдсан байдаг.

ГШХО-ЫГ ШИНГЭЭХ ЧАДВАРЫН СУДАЛГАА


Сүүлийн хэдэн арван жилийн олон улсын худалдаа, капиталын шилжилтийн өсөлтөд үндэстэн дамнасан үйлдвэрүүд (ҮДҮ) ихээхэн хувь нэмэр оруулж байна. Нэг улсаас гадаад улсуудад үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдан, хянаж буй пүүсүүийг үндэстэн дамнасан үйлдвэр гэдэг. Эдгээр том пүүсүүд нь ихэвчлэн Хойд Америк, Европ, Япон улсуудад байдаг ба сүүлийн үед Өмнөд Солонгос, Тайвань зэрэг шинэ, өндөр орлоготой улсуудын үндэстэн дамнасан үйлдвэрийн тоо нэмэгдэж байна. Мөн Бразил зэрэг дунджаас дээгүүр орлоготой орнууд, Хятад зэрэг дунджаас доогуур орлоготой хэдий ч хурдтай өсөж байгаа орнуудын ҮДҮ-ийн өсөлт нь дараагийн байруудад явж байгаа аж. Хэрвээ тухайн пүүс гадаад улсын салбартаа нийт хөрөнгийн 10 болон түүнээс дээш хувийн хөрөнгийг оруулсан бол энэ хоёр пүүсийг үндэстэн дамнасан үйлдвэрүүд гэж нэрлэнэ.⁴ Үндэстэн дамнасан үйлдвэрүүдийн үйл ажиллагаа нь үндсэндээ хоёр төрөлтэй байдаг. Үүнд: (1) түнш компани нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нь давтан үйлдвэрлэх; (2) түнш компани нь үйлдвэрлэлийн процессын зарим хэсгийг гадаадад байршин үйлдвэрлэх. Үйл ажиллагааны эдгээр төрлөөс хамаараад ГШХО-ыг хэвтээ болон босоо гэж хоёр ангилдаг. Хэвтээ хөрөнгө оруулалт нь толгой болон түнш компаниуд нь ижил төрлийн үйлдвэрлэл явуулах үед үүсдэг ба томоохон хэрэглэгчидтэй ойрхон байрлалыг сонгож, байршдаг тул энэ төрлийн хөрөнгө оруулалтын шийдвэрт тээврийн зардал, ажилчдын цалингийн зардал зэрэг үйлдвэрлэлийн зардал маш чухал нөлөөтэй байдаг. Харин босоо ГШХО гэдэг нь толгой болон түнш компаниуд нөөц, зардал дээр тулгуурлан бүтээгдэхүүний ялгаатай хэсгүүдийг үйлдвэрлэх үед үүсдэг. Босоо ГШХО-ын жишээ нь, компьютерын нимгэн ялтасны үйлдвэрлэл болон түүнтэй холбоотой судалгаа, хөгжүүлэлтийн ажил нь маш нарийн ур чадвар шаарддаг тул ихэвчлэн АНУ, Ирланд, Израйл улсуудад байрладаг, харин дараагийн үед болох угсралт, хяналтын үйлдвэрүүд нь хөдөлмөрийн оролцоо ихтэй тул Малайз, Филиппин, Коста Рика, Хятад зэрэг улсад байрладаг байна.

ГШХО-ын дотогшлох урсгал нэмэгдсэнээр тухайн улсад гадаадын хөрөнгө болоод ур чадвар сайтай ажиллах хүч, технологи, ажлын байрны шилжилт нэмэгддэг. Хятад, Өмнөд Солонгос, Малайз, Сингапур зэрэг Зүүн Азийн бар орнуудын ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалтын үр шимээр өндөр хөгжлийн түвшинд хүрчээ. ГШХО-ын асуудалд улс орон бүр өөр өөрийн онцлогтой бодлогыг боловсруулснаар түүнийг хөгжлийнхөө гол түлхүүр болгож чаддаг байна.

Дэлхийн нийт улсуудад орж буй шууд хөрөнгө оруулалтын урсгал нь 2005 оноос хойш өсөж байгаа (Зураг 8) хэдий ч 2000-аад оны эхэн үе, 2009, 2012 онуудад ШХО-ын нийт урсгал багассан ба нийт ШХО-ын багахан хувь нь шилжилтийн эдийн засагтай орнуудад, нэлээд хувь нь хөгжиж буй орнуудад орсон байна. Улс бүрээр авч үзвэл, 2013 оны байдлаар АНУ, Хятад, Английн Виржини Арал, ОХУ, Хонг-Конг, Бразил зэрэг улсууд шууд хөрөнгө оруулалтыг хамгийн ихээр татжээ.

⁴ Krugman Paul R., Obstfeld Maurice, Melitz Marc J., 2013, International Economics, Textbook, p.180

Зураг 8. ГШХО-ын дотогшлох урсгал




Эх сурвалж: UNCTAD


Дэлхий нийтэд нэмэгдэн урсаж буй ШХО-аас манай улс 2011, 2012 онуудад хамгийн их мөнгөн дүнтэй хөрөнгө оруулалтыг татсан бол 2005-2008 онд хамгийн олон буюу 5636 гадаадын аж ахуйн нэгжийг өөрийн орондоо байршуулжээ. Бид өөрийн орны онцлогт тохирсон гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулахын тулд эхлээд дэлхийн бусад улсуудад гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг хэрхэн бүрдүүлж, түүнийг хэрхэн үр ашигтай зарцуулсан талаар болон манай улс хэр хэмжээний гадаадын хөрөнгийг шингээх чадвартай байгаагаа нарийвчлан судлах шаардлагатай юм.

Монгол Улстай адил далайд гарцгүй Азербайжан болон Кыргыз, жижиг эдийн засаг болох Габон, Намиби, уул уурхайн бүтээгдэхүүнээ ашиглан амжилттай хөгжиж байгаа Чили болон Перу, ижил бүс нутагт оршин байдаг Казакстан, Узбекистан, хил залгаа оршдог Хятад болон ОХУ-ыг сонгон харьцуулан судаллаа.

Зураг 9. Бизнес эрхлэхэд хялбар байдлын эрэмбэ, 2014 он



Зураг 10. Монгол Улсад бизнес эрхлэхэд хялбар байдлыг тогтоох үзүүлэлт бүрийн эрэмбэ, 2014 он



Эх сурвалж: World Bank Group, Doing Business 2015

Дээрх зураглалаас харахад сонгосон орнуудаас Перу болон Чили улсууд нь бизнес эрхлэхэд хамгийн таатай орчныг бүрдүүлж, эдийн засгаа амжилттай сайн хөгжүүлж байгаа бол Монгол Улс энэ үзүүлэлтээр 144 орны дундаж цэг дээр байна. Харин бизнес эрхлэхэд хялбар байдлын эрэмбийг тогтоодог үзүүлэлт бүрээр нь ялган ажиглавал манай улс эрчим хүчний хангамж авах, татвар төлөх, гадаад худалдаа хийх, төлбөрийн чадваргүй байдлаа шийдвэрлэхэд сонгосон бусад орнуудтай харьцуулахад төвөгтэй байдаг гэсэн үзүүлэлт гарчээ. Ялангуяа гадаад худалдаа хийх, эрчим хүчний хангамж авах үйл ажиллагаа ямар хүндрэлтэй байдаг ба энэ нь манай улсад бизнес эрхлэхэд хялбар байдлын индексийг хойш татсан байгааг дараах хүснэгтээс харах боломжтой. Монгол Улсын хувьд экспорт, импорт хийхэд бүрдүүлдэг материалын тоо олон, зарцуулах хугацаа уртаас гадна нэг контейнерыг тээвэрлэх зардал өндөртэй аж. Харин эрчим хүний хангамж авахын тулд зөвшөөрөл авах үе шат олонтойгоос гадна нэгжийн зардал өндөртэй байдаг байна. Эрчим хүчний хангамж авах үйл ажиллагааг хэрхэн сайжруулж болох вэ гэдгийг бодлогын туршлагыг Чили, Намиби, Перу, Казакстан улсуудаас, гадаад худалдаа хийх үйл явцыг хэрхэн хялбар болгох вэ гэдэг зохион байгуулалтын туршлагыг мөн Чили, Перу, Хятад зэрэг улсуудаас суралцах хэрэгтэй байна.

ГШХО-ын шингээх чадварыг тодорхойлох нь

Олон улсын макро эдийн засгийн болон гадаадын хөрөнгө оруулалт, түүний дотор ГШХО-ын төлөв байдал, бодлогын онцлог, өөрчлөлтүүдийн талаар нэгдсэн мэдээллийг цуглуулж, жил бүр тайлан илтгэл бичдэг хэд хэдэн байгууллага байдаг бөгөөд тэдгээрийн нэг нь НҮБ-ын Худалдаа болон Хөгжлийн Бага Хурал (United Nations Conference on Trade and Development-UNCTAD) юм. Тус байгууллагаас дэлхийн 237 орны ГШХО-тай холбоотой хэд хэдэн индексүүдийг жил бүр тооцдог байна. Тэдгээр индексүүдийн нэг болох ГШХО-ын гүйцэтгэлийн индекс нь дэлхийн нийт ШХО-ын урсгалд тухайн улсын ШХО-ын эзлэх хувийг дэлхийн нийт ДНБ-д тухайн улсын ДНБ-ий эзлэх хувьд харьцуулсан харьцаа бөгөөд тухайн улсын эдийн засгийн хэмжээнд харгалзуулан улс бүрийг хүлээн авч буй ГШХО-оор нь эрэмбэлдэг.

$$IND_i = \frac{FDI_i / FDI_w}{GDP_i / GDP_w}$$


Энд, IND_i - *i* дугаар орын ГШХО-ын дотогшилох урсгалын гүйцэтгэлийн индекс
 FDI_i - *i* дугаар оронд орж ирсэн ГШХО-ын хэмжээ
 FDI_w - Дэлхийн ГШХО-ын дотогшилох урсгал
 GDP_i - *i* дугаар орны ДНБ
 GDP_w - Дэлхийн ДНБ

Энэ индекс нь тухайн улсын зах зээлийн хэмжээнээс бусад хүчин зүйлс болох бизнесийн орчин, эдийн засгийн болон бодлогын тогтвортой байдал, байгалийн нөөцийн төрх байдал, дэд бүтэц, ур чадвар болон технологи, ГШХО-ын

дэмжлэгийн үр ашигтай байдал эсвэл өмч хувьчлалд оролцох боломж зэрэг хүчин зүйлүүдийн нөлөөллийг товойлгон харуулдаг.⁵ Уг индексийн утга 1-ээс их бол тухайн улс эдийн засгийн хэмжээтэйгээ харьцуулахад харьцангуй их ГШХО-ыг хүлээн авдаг болохыг харуулах ба индексийн утга 1-ээс бага гарвал харьцангуй бага ГШХО-ыг хүлээн авсныг харуулна. Сөрөг утга нь тухайн хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт ороогүйг илтгэнэ.

НҮБ-ын Худалдаа болон Хөгжлийн Бага Хурлаас жил бүр дээрх индексүүдийг тооцон улс орнуудыг эрэмбэлдэг хэдий ч индексүүдийн утгыг авах эх сурвалж хязгаарлагдмал, хаалттай байдаг байна. Иймд тус байгууллагын аргачлалд тулгуурлан 1990-2013 онуудын гүйцэтгэлийн индексийг тооцож, зарим харьцуулалтыг хийлээ. Зураг 11-аас харахад хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнууд өөрийн эдийн засгийн хэмжээтэйгээ харьцуулахад харьцангуй их ШХО-ыг татдаг бол хөгжингүй орнууд ШХО-ыг харьцангуй багаар татдаг байна. Түүнчлэн өр ихтэй ядуу орнууд, анхдагч түүхий эд экспортлогч гол орнууд, газрын тос болон байгалийн хий экспортлогч гол орнууд нь өөрийн эдийн засгийн хэмжээнээсээ харьцангуй ихээр ШХО-ыг татдаг бол хөгжингүй, аж үйлдвэржсэн, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлогч орнуудын гүйцэтгэлийн индекс 1 болон түүнээс бага байгаа нь эдгээр орнуудад хөрөнгийн дутагдал бага байдагтай холбоотой юм.

Зураг 11. 2013 оны ГШХО-ын шингээх чадварын индексийн харьцуулалт



Эх сурвалж: UNCTAD

Шингээх чадварын индексийн хэвийн түвшин 1 ба манай улстай адил төстэй шинжээр нь сонгосон улсуудын дундаж индекс 3-тай тэнцүү байгаа тул Монгол

Улс $1 \leq \frac{FDI_{MGL}/FDI_w}{GDP_{MGL}/GDP_w} \leq 3$ байхаар хөрөнгө оруулалтыг татвал шингээх чадвартай


байна. Энэ томъёоллыг бага зэрэг хувирган $1 \leq \frac{FDI_{MGL}/GDP_{MGL}}{FDI_w/GDP_w} \leq 3$ хэлбэрээр

бичиж болох ба НҮБ-ын Худалдаа болон Хөгжлийн Бага Хурлаас гаргадаг тоон мэдээллээс дүгнэвэл сүүлийн 10 жилийн дунджаар дэлхийн нийт ДНБ-ий 3 орчим хувьтай тэнцүү хөрөнгө шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр улсуудад орж

⁵ UNCTAD, 2002, World Investment Report

байна. Ингэж тооцвол $\frac{FDI_w}{GDP_w}$ харьцаа 0.03-тай тэнцэх бөгөөд манай улсын хувьд $0.03 \leq \frac{FDI_{MGL}}{GDP_{MGL}} \leq 0.09$ нөхцөл бүрдэх буюу бид ДНБ-ийхээ 3%-аас 9%-тай тэнцэх шууд хөрөнгө оруулалтыг татвал шингээх чадвартай байна.

Зураг 12. Сонгосон орнуудын ГШХО-ын шингээх чадварын харьцуулалт




Эх сурвалж: UNCTAD


Харин Монгол Улсын хувьд ижил төстэй байдлаар нь харьцуулан сонгосон бусад орнуудаас хамгийн өндөр гүйцэтгэлийн үзүүлэлттэй байгаа төдийгүй 2013 онд энэ индекс 8,9 гарсан нь өөрийн эдийн засгийн цар хүрээтэйгээ харьцуулахад 8,9 дахин их ШХО-ыг татаж чадсан байна гэж дүгнэж болно. Тооцсон индексийн динамикийг харвал сүүлийн жилүүдэд манай улсын гүйцэтгэлийн индекс өндөр гарсан ба энэ нь манай улс уул уурхайн салбарт томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой юм. Монгол Улсын ДНБ-ий хэмжээнээс үл хамааран бизнесийн орчин, эдийн засгийн болон бодлогын тогтвортой байдал, байгалийн нөөц, дэд бүтэц, ажиллах хүчний ур чадвар болон технологи, ГШХО-ын дэмжлэгийн үр ашигтай байдал, өмч хувьчлалд оролцох боломж зэрэг хүчин зүйлүүд маш бага хэмжээгээр өөрчлөгдөхөд манай улсад орж ирэх ГШХО их хэмжээгээр өсдөг болохыг харуулна. Өөрөөр хэлбэл, манай улсын эдийн засгийн хэмжээ/ДНБ/-нээс үл хамааран бизнесийн орчин, эдийн засгийн болон бодлогын тогтвортой байдал, байгалийн нөөцийн ашиглалт, дэд бүтэц, хөдөлмөрийн ур чадвар, технологи, ГШХО-ыг дэмжих бодлого зэргээс хамаарах ГШХО-ын мэдрэмж эерэг бөгөөд маш өндөр утгатай байна.

Сонгосон орнуудаас Хятад Улс 2013 онд нийт 124 тэрбум долларын ШХО-ыг татаж, АНУ-ын дараа хоёрдугаар байрт жагссан хэдий ч гүйцэтгэлийн индекс нь 0,7 гарсан нь эдийн засгийн хэмжээтэйгээ харьцуулахад энэ улс харьцангуй бага хөрөнгө оруулалт татсан байгааг илтгэнэ. Харин сонгосон Кыргыз, Чили, Намиби, Перу, Казакстан, ОХУ, Азербайжан, Габон зэрэг орнуудад гүйцэтгэлийн индекс эерэг бөгөөд харьцангуй өндөр утгатай гарчээ.


Зураг 13. 2011 оны ГШХО болон шингээх чадварын өөрчлөлт




Зураг 14. 2012 оны ГШХО болон шингээх чадварын өөрчлөлт



Зураг 16. 2013 оны ГШХО болон шингээх чадварын өөрчлөлт



Зураг 17. Монгол Улсын зам



2011 оноос хойш Монгол Улсад орох ШХО-ын хэмжээ эрс буурсан төдийгүй гүйцэтгэлийн индексийн өөрчлөлт ч сөрөг утгатай гарсныг ГШХО-ын өсөлт болон гүйцэтгэлийн индексийн өөрчлөлтийн хоорондын хамаарлыг үзүүлсэн Зураг 17-аас харж болно. Энэ нь манай улсад орж ирэх ШХО-ын хэмжээ мөнгөн дүнгээрээ буурч байгаагаас гадна эдийн засгийн цар хүрээний бус хүчин зүйлсийн улмаас ШХО-ын хэмжээ буурсныг гүйцэтгэлийн индексийн бууралт илэрхийлж байна.

Сонгосон орнуудын дотроос далайд гарцгүй Азербайжан, манай улстай ижил бүсэд оршиж буй Казакстан улсуудын хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд мөн гүйцэтгэлийн индекс болон ШХО-ын хэмжээ буурсан байна. Харин байгалийн

баялгаа ашиглан амжилттай хөгжиж буй Чили, Перу Улсуудын хувьд 2012 онд гүйцэтгэлийн индекс сайжирч, ШХО-ын дотогшлох урсгал нэмэгдсэн хэдий ч 2013 онд тэдгээр үзүүлэлтүүд нь буурчээ. Харин жижиг эдийн засаг болох Габон, хөрш ОХУ, далайд гарцгүй Кыргыз улсуудын хувьд ШХО-ын урсгал болон гүйцэтгэлийн индексүүд харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Хятад Улсын хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд ШХО-ын урсгал нь эдийн засгийн хэмжээтэйгээ харьцангуй пропорционалаар өөрчлөгдөж, тогтворжих хандлагатай болжээ.

Иймд бид судалгаандаа сонгож авсан орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримталж буй бодлогыг судална. Байгалийн баялгаа ашиглан хөгжиж буй Чили, Перу, далайд гарцгүй Кыргыз, жижиг эдийн засаг Габон, хөрш Хятад улсуудын хөрөнгө оруулалтын бодлогыг илүү түлхүү судлах нь ач холбогдол өндөртэй гэж үзэж байна.

Монгол Улстай ижил, төстэй орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, бодлого, зохицуулалт

Монгол Улстай адил далайд гарцгүй Азербайжан болон Кыргыз, жижиг эдийн засаг болох Габон, Намиби, уул уурхайн бүтээгдэхүүнээ ашиглан амжилттай хөгжиж байгаа Чили болон Перу, ижил бүс нутагт оршин байдаг Казакстан, Узбекистан, хил залгаа оршдог Хятад болон ОХУ, байгалийн баялаг нь эдийн засгийг нь улам хүндрүүлсэн Африкын Ангол, Нигери улсууд гадаадын хөрөнгө оруулалтын ямар орчинг бүрдүүлж, ямар бодлого баримталж байсан бэ гэдгийг харьцуулан судаллаа.

Хятад Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 1385,6 сая
Газар нутаг: 9'388'211м²
ДНБ-ий өсөлт: 7,3%
Инфляци: 2,57%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 6'560 ам.доллар
Экпортын 94% нь аж үйлдвэрийн, боловсруулсан бүтээгдэхүүн.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Хамгийн олон хүн амтай, хамгийн том зах зээл байхын хэрээр Хятад Улс дэлхийн нийт ГШХО-аас нэлээд ихийг татаж авдаг орон юм. 2013 онд 124 тэрбум ам.долларын ШХО-ыг татаж, АНУ-ын дараа хоёрдугаар байранд орж чаджээ. Түүнчлэн бизнес эрхлэхэд хялбар байдлын зэргээрээ 2014 онд 189

орноос 90-р байранд орж, авилгын индексээр 174 орноос 100-р байранд (2014 онд) жагсжээ. Хятад улс 2001 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д элсэж, гишүүн болсноор худалдаа, эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх болсон. Ингэж олон улсын шинэ орчин бий болсноор үндэстэн дамнасан корпорациуд хөдөлмөрийн зардал бага гэх мэт Хятадын таатай, давуу олон талыг ашиглах зорилгоор илүү их хөрөнгө оруулах болжээ. Хятад дэлхийд зах зээлийн багтаамжаар хамгийн том, улмаар хөдөлмөрийн зардал харьцангуй хямд, аж үйлдвэрийн суурь бааз сайтай, хөрөнгө оруулалтын таатай бодлого баримталдаг, макро эдийн засаг тогтвортой зэрэг хүчин зүйл ГШХО-ыг татах таатай орчинг бүрдүүлдэг байна.

1978 оноос хойш Хятад улс нь гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулах маш их хууль, дүрэм журам гаргасан. Тэдгээр хуульд БНХАУ-ын гадаадын бүрэн эзэмшилтэй аж ахуй нэгжийн хууль, Хятад, гадаадын хамтарсан аж ахуй нэгжийн тухай хууль, Хятад гадаадын хамтын үйлдвэрийн тухай хууль, гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй аж үйлдвэрийн тухай лавлах толь зэрэг ордог.

Хятадын ГШХО-ын бодлогын зорилтууд:

- Уламжлалт ХАА-аа өөрчилж, орчин үеийн ХАА болгон хөгжүүлэх, ХАА-ын аж үйлдвэрийг дэмжих;
- Зам тээврийн дэд бүтэц, эрчим хүчний эх үүсвэр, түүхий материал, бусад үндсэн суурь аж үйлдвэрүүдийг дэмжих;
- Электроник мэдээлэл, биоинженерчлэл, шинэ материал, нисэх хүчин сансар, орон нутгийн R&D төвүүд зэрэг технологит чиглэсэн аж үйлдвэрийн салбаруудыг дэмжих;
- Багаж хэрэгсэл, нэхмэл, хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж үйлдвэрүүд зэрэг уламжлалт аж үйлдвэрийн салбаруудыг өөрчлөх, тэдгээрийн тоног төхөөрөмж, үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулах дэвшилтэт, хэрэглээтэй технологиудыг ашиглах гадаадын бизнес эрхлэгчдийг дэмжих;
- Түүхий болон дахин сэргээгдэх боломжтой нөөцийг олон талаар ашиглах, хүрээлэн буй орчныг хамгаалах төслүүдийг дэмжих, нийтийн хэрэглээг орчин үеийн шинжтэй болгох;
- Экспортод чиглэсэн ГШХО-ын төслүүдийг дэмжих;
- Хятадын баруун бүсэд аж үйлдвэрүүдийг барих.

Эдгээр зорилго дундаас экспортыг дэмжих, технологийг шилжүүлэх нь Хятадын ГШХО-ын хамгийн чухал хоёр зорилго юм. Энэ хүрээнд дэд бүтэц, хөгжил муутай ХАА салбар, үйлдвэрлэлийн функцыг шинэчлэх, эрчим хүч, түүхий эд материалыг хэмнэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, шинэ технологи, тоног төхөөрөмжийг ашиглах, бохирдлыг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг дэмждэг.

Харин технологи нь аль хэдийн хөгжчихсөн, үйлдвэрлэл нь дотоодын эрэлтээс давсан, улсын монопол, ховор, үнэ цэнтэй ашигт малтмалын нөөцийн хайгуул, олборлолтын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарладаг.

Үндэсний аюулгүй байдал, нийтийн сонирхолд хор хөнөөлтэй, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, их хэмжээний газар нутаг ашиглаж, байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлэх, улсын батлан хамгаалахын аюулгүй байдалд халдсан, Хятадын ховор уламжлалт технологийг хэрэглэхэд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтуудыг хориглодог. Радио идэвхит бүтээгдэхүүний хайгуул, олборлолтыг хориглоно. Ерөнхий боловсролын салбарт хөрөнгө оруулахыг хориглодог ажээ.

Оросын Холбооны Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Манай улс хил залган орших, газар нутгийн хувьд ч, хүн амын хувьд ч мөн эдийн засгийн хувьд ч манай улсаас харьцангуй том Оросын холбооны улс нь бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр 189 орноос 62-т(2015), авилгын индексээр 175 орноос 136-д(2014) жагсдаг. Экспортын гол бүтээгдэхүүнүүд нь түлш, байгалийн хий, метал, ноос ноолууран бүтээгдэхүүн, эм. Импортын гол бүтээгдэхүүнүүд багаж хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, эмийн сангийн бүтээгдэхүүнүүд, пластик, хагас боловсруулсан метал, мах, жимс, самар, оптик эмийн багаж хэрэгсэл, төмөр, ган.

2014 оны 8 дугаар сард Оросын засгийн газар АНУ, Европын холбоо, Канад, Австрали болон Норвеги зэрэг улсуудаас оруулж ирэх хүнсний бүтээгдэхүүний импортдоо хориг тавьсан. Энэ нь дотоодын нийлүүлэгчдийн өрсөлдөөнийг хязгаарлах замаар өргөн хүрээтэй импортыг орлуулах бодлогыг дэмждэг боловч эдгээр бүтээгдэхүүнүүдийн дотоодын үйлдвэрлэлийн хомсдолтой байдал болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх бэрхшээл нь дотоодын үйлдвэрлэгчдийн ашгийг бууруулсан.

Дотоодын хөрөнгө оруулалтын хувьд Засгийн газар татварын тухай хуулийг баталж, 2014 оны 11 дүгээр сарын 24-нд гадаадын компаниудад хяналт тавь эхэлсэн.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(ЭЗХАХБ) нь 2010-12 онд Оросын хөрөнгө оруулалтын бодлогын хяналт хийсэн.

Хууль эрх зүйн бүтэц нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжиж байгаа боловч бодит байдал дээр хууль хэрэгждэггүй.

2012 оны 6 дугаар сард ерөнхийлөгч Путин бизнес эрхлэгчдыг сурталчлах хамгаалах нэмэлт арга хэмжээнүүдийг зохион байгуулах зорилгоор бизнес эрхлэгчдийн эрхийн төлөөх Омбудсманы байр суурийг бий болгосон. Гэсэн хэдий ч тус улсын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх механизм төгс дуусаагүй хэвээр байна.

Оросын төрийн албан хаагчид гадаадын хөрөнгө оруулалт болон технологи дамжуулах нь Оросын эдийн засгийн шинэчлэлд нэн чухал гэдгийг онцлон тэмдгэлсэн байдаг. Үүнтэй зэрэгцэн, Засгийн газарын салбарууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалт нь 2008 оны Стратегийн салбарын тухай хуулийн тусламжтайгаар улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратеги болсон.

Гадаадын хөрөнгө оруулалтын хяналтын Засгийн газрын комисс нь ОХУ-ын ГШХО-ыг хамгаалдаг. 2008 онд байгуулагдсан тус комиссын хяналт аж үйлдвэр рүү чиглэсэн ба хөрөнгө оруулалтын босго түвшинг авч үздэггүй.

Худалдаа, хөгжлийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын дагуу ОХУ-ын гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 19 тэрбум ам.доллар, 2014 онд 70 хувиар тус тус буурсан байна. 2014 онд ОХУ-ын капиталын гарах урсгал ойролцоогоор 150 тэрбум ам.доллар байсан ба энэ нь хамгийн өндөр урсгал болсон байна. Түүхээс авч үзэхэд ОХУ-д гадаадын шууд хөрөнгө оруулалтын өндөр хэлбэлзэлтэй байгаа нь онцлог байна. Жишээ нь: 2013 оны эрчим хүчний салбар дахь нэг талт худалдан авалтын гэрээ нь 15 тэрбум ам.доллартай тэнцэх ГШХО болсон байна. Үүнээс гадна ОХУ-ын ГШХО нь тойрог хэлбэрийн ГШХО-д орно учир нь хоёрдогч улсаар дамжин гардаг. Шинжээчид ерөнхийдөө тойрог хэлбэрийн ГШХО нь цэвэр ГШХО-аас бага өгөөжтэй гэж үздэг.

Намиби Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 2,3 сая
Газар нутаг: 823'290 м²
ДНБ-ий өсөлт: 4,7%
Инфляци: 5,6%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 5'870 ам.доллар
Экпортын 25% нь аж үйлдвэрийн, мөн 25% нь төмрийн хүдэр, метал, 26% нь хүнсний бүтээгдэхүүн.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Манай улстай харьцуулахад газар нутаг багатай, арай цөөн хүн амтай Намиби Улс нь Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр 189 орноос 88-д (2014 он) жагсаж, Transparency International-ээс зарладаг авилгын индексээр 174 орноос 55-д (2014 он) орсон байна.

Намиби Улс нь 1990 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын хууль”-аа баталсан бөгөөд “Худалдаа, аж үйлдвэрийн яам” нь гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг шийдвэрлэж байдаг. Уг хуулинд зааснаар гадаадын хөрөнгө оруулагчдад дотоодын хөрөнгө оруулагчидтай адил хандах ёстой гэж заасан боловч зарим төрлийн хязгаарлалт тавих эрх нь Намибигийн засгийн газарт байдаг. Жишээ нь, байгалийн нөөц ашиглах тусгай зөвшөөрлийг олгохдоо Засгийн газар орон нутгийн иргэдийн оролцоог харгалзан үзэх ёстой бөгөөд зарим төрлийн “стратегийн ашигт малтмал”-ыг ашиглах тохиолдолд нэмэлт хязгаарлалтуудыг авч болно. 2011 онд Намибигийн засгийн газар уран, алмаз, алт, зэс, газрын ховор металлуудыг стратегийн ашигт малтмал гэж зарласан. Ингэснээр өөрийн төрийн өмчит компаниудад стратегийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох замаар уул, уурхайн салбарт дотоодын компаниудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой байв. Мөн “Газрын шинэчлэлийн тухай” хуулиараа гадаадын иргэн хөдөө аж ахуйн газар худалдан авах харилцааг зохицуулсан. Газрын харилцаа эрхэлсэн сайдын зөвшөөрөлгүйгээр ямар ч гадаадын иргэн газар худалдан авах эрхгүй ажээ.⁶

Габон Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

АНУ, Хятад, Франц зэрэг оронуудыг гадаад худалдааныхаа гол түншүүдийг болгож чадсан, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлогч Габон улс нь манай улсаас цөөн хүн амтай, маш жижиг газар нутагтай орон ажээ.

⁶ <http://www.state.gov/e/eb/rls/othr/ics/2013/204701.htm>

2013 оны байдлаар Габон Улс:

Нийт хүн ам: 1,7 сая

Газар нутаг: 257'670м²

ДНБ-ий өсөлт: 6,0%

Инфляци: 0,48%

Нэг хүнд ноогдох ҮНБ: 10'650 ам.доллар

Экпортын 79% нь аж үйлдвэрийн, мөн 4%

нь нефть, 6% нь төмрийн хүдэр, метал.

2012 онд ДНБ-ийхээ 65,5%-тай тэнцэх

экспортыг гаргажээ.

Эх сурвалж: UNCTAD, Country profile

Гэвч бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээрээ 2014 оны байдлаар 189 орноос 144 орж, авилгын индексээр 174 орноос 94-т жагсан, 80-р байранд яваа Монгол Улсаас ч их авилгатай гэж зарлагджээ.

Хөрөнгө оруулалтын бодлогын тухайд Габон Улс нь бүхий л салбартаа гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхтэй дэмжинэ гэсэн боловч

тухайд эдийн засагт АНУ-ын оролцоо улам бүр нэмэгдэж байгаа нь шинээр хөрөнгө оруулагчдад цаг хугацаа их алдах саад болж байна. Гадаадын пүүсүүд газрын тос, уул уурхай, ойн модны салбарт үйл ажиллагаа явуулж, экспортын болон орлогын гол эх сурвалжаа олж авдаг. Габоны засгийн газар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор уул уурхай, газрын тос, ойн модны салбартаа ил тод байдлыг хангахаар үүрэг аван ажиллаж байгаа хэдий ч бодит байдалд биелэлээ олох сайн хууль гарахыг хөрөнгө оруулагчид хүлээсээр байгаа. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын хязгаарлагдмал хүчин чадал, байр сууриа олсон компаниуд дутагдалтай, үйлдвэрлэлийн зардал өндөр, дотоодын зах зээл нь жижиг, хөдөлмөрийн хууль нь хөшүүн, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц муутай, шүүх тогтолцоо данхгар, гаалийн дүрэм журмууд нь хэрэглээтэйгээ нийцтэй биш зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагчдад төвөгтэй байдаг. 1998 оны хөрөнгө оруулалтын тухай хуулиараа дотоод болон гадаадын бизнес эрхлэгчдэд ижил эрхийг олгохоор заасан ба уул уурхай, ойн аж ахуй, газрын тос, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулагчийг гааль, татварын урамшуулал олгож дэмжих бодлого явуулдаг ба гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай бодлогын баримт бичиг байдаггүй ажээ.⁷

Ботсван Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 2 сая

Газар нутаг: 566'730 км²

ДНБ-ий өсөлт: 4,1%

Инфляци: 5,88%

Нэг хүнд ноогдох ҮНБ: 7'770 ам.доллар

Экпортын 7% нь аж үйлдвэрийн, мөн

10% нь төмрийн хүдэр, метал.

Эх сурвалж: UNCTAD, Country profile

Газар нутаг болон хүн амын хэмжээгээр манай улстай харьцуулахад харьцангуй жижиг бөгөөд Монголтой ижил далайд гарцгүй Ботсван Улс нь бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр дэлхийн 189 орноос 74-т (2015 он) жагсдаг бол авилгын индексээр 175 орноос 31-т жагсдаг үзүүлэлттэй байна.

Экспортоор гаргадаг гол бараа нь алмаз, зэс, никел, кальжуулсан сода, мах болон нэхмэл бүтээгдэхүүн. Харин импортоор оруулж ирдэг гол бараа нь хүнсний бүтээгдэхүүн, багаж хэрэгсэл, цахилгаан бараа, тээврийн хэрэгсэл, нэхмэл бараа, шатахуун, модон болон цаасан бүтээгдэхүүн, төмөр болон төмрөөр хийсэн бүтээгдэхүүнүүд.

⁷ <http://www.state.gov/e/eb/rls/othr/ics/2013/204644.htm>

Эдийн засгийн орчин буюу хөгжлийн түүх

Чили, Кувейт зэрэг орнуудтай харьцуулах аргагүй боловч эрдэс баялагийн салбар, эдийн засгаа тогтвортой хөгжлүүлж чадсан, Африкт хамгийн амжилттай хөгжиж буй орон бол Ботсван. Их Британы ивээлд 80 гаруй жил байсан энэ орон 1966 оны 9 дүгээр сард тусгаар тогтнолоо зарласан. Энэ үйл явдалтай зэрэгцэн Орапа тосгоноос алмаз эрдэнэ олдож байж. Нэг үе мал аж ахуйгаас хамаарч байсан Ботсван улс уул уурхайн орон болох шилжилт эхэлсэн. Энэ үеэс Ботсваны эдийн засаг жилдээ 9 орчим хувиар өсч байсан бөгөөд энэ үед дэд бүтэц нь сайн хөгжсөн. Алмаз эрдэнийн дэлхийн хамгийн том уурхай болох Жаваненг Бостванд байдаг.

1980 он Ботсван улсад хүндхэн жил байсан. Ажилгүйдэл газар авсны зэрэгцээ эдийн засаг нь хүнд нөхцөлд орсон. Гэвч Ботсван олон намын системтэй ардчилсан орон байсан тул тал талаас тусламж авч хямралаас хурдан гарч чадсан.

Зөвхөн уул уурхай төдийгүй эдийн засаг ялангуяа бизнесийн орчноо сайжруулахын тулд тус улсын төр засаг ажилладаг нь дэд бүтцийн хөгжлөөр эдийн засгаа маш сайн хөгжүүлснээс нь харж болохоор байна. Мөн авилгын индексээр дээгүүр жагсдаг нь засаглал сайтай гэдгийг ч мөн харуулдаг.

Хууль, эрх зүйн орчин

Ботсван улс нь ХАА, алмаз, боловсрол, эрүүл мэнд, тээврийн салбар дахь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмждэг. 2012 онд Худалдаа, үйлдвэрийн яам нь Хөрөнгө оруулалтын бодлогыг хянан үзэх зорилгоор Хөрөнгө оруулалтыг дэмжих хуулийн саналыг оруулсан. 2014 оны 12 дугаар сард Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) нь Хөрөнгө оруулалтын бодлогын хяналттай болсон.

Ботсван Улсын Компанийн тухай хуульд зааснаар бизнес эрхлэх хүсэлтэй гадаадын иргэд Худалдааны хуульд заасны дагуу холбогдох тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

Тус улс нь зөвхөн өөрийн улсын иргэддээ зарим тусгай зөвшөөрлийг хязгаарладаггүй. Үүнд: мах нядалгааны газар, худалдааны байгууллага, шатахуун түгээгүүр, архины дэлгүүр, супермаркет, бар, тодорхой төрлийн ресторан, дэлгүүр, дуудлага худалдаа, машин угаалга, дотоодын цэвэрлэх үйлчилгээ, шинээр үйлдвэрлэгчид, оршуугын үйл ажиллагаа, үсчин түрээсийн үйлчилгээ, Засгийн газрын барилгын төсөл, авто зам, төмөр замын барилга, засвар мөн сургуулийн тавилгын үйлдвэрлэл, гагнуур, өрлөгчин. 1997 онд Ботсваны Засгийн газар хувьчлал руу чиглэсэн үйл ажиллагаа явуулсан. 2012 онд Уул уурхайн салбарын эзэмшилтэд хяналт тавьж эхэлсэн. 2014 онд Polaris II гэж нэрлэгдэх нэгэн том эдийн засгийн олон талт стратегийн дагуу уул уурхайн төв байгуулж, улс орны түлшний хангамжийг удирдах Ботсваны газрын тосны үйлдвэрийг байгуулсан. Үүгээрээ зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлж чадсан.

Бостваны Хөрөнгө оруулалт болон Худалдааны төв нь ГШХО-ыг хянадаг. Бостван нь бизнесийн орчинд зохих өрсөлдөөнийг бий болгохын тулд итгэлцлийн эсрэг хууль болон бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг ба энэ нь байгууллагууд хоорондоо нэгдэхэд хяналт тавьдаг.

Чили Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 17,6 сая

Газар нутаг: 743'532м²

ДНБ-ий өсөлт: 4,2%

Инфляци: 1,797%

Нэг хүнд ноогдох ҮНБ: 13'230 ам.доллар

Экпортын 57% нь уул уурхайн бүтээгдэхүүн,

21% нь хөдөө аж ахуйн түүхий эд материал,

13% нь аж үйлдвэрийн боловсруулсан

бүтээгдэхүүн.

Эх сурвалж: UNCTAD, Country profile

1810 онд шинээр байгуулагдсан бүгд найрамдах улсаа байгуулж, олон улсын худалдаа болон хөрөнгө оруултад нээлттэй байхаар зохион байгуулсан юм. Гэсэн ч 1930 он гэхэд худалдаа хийгээд хөрөнгө оруултад хориг саад бий болгожээ. Тухайлбал 1970 оны эхэн үед батлагдсан Андын пактын 24-р шийдвэрт зөвхөн гишүүн орны хооронд худалдаа, хөрөнгө

оруулалт болон техникийн хамтын ажиллагаа явуулах тухай дурьдсан байв. Гэсэн ч 1974 онд Гадаадын хөрөнгө оруулалтын хууль батлагдсанаар энэхүү байдал өөрчлөгдсөн юм. 1990 он гэхэд Чили нь чөлөөт худалдаа болон хөрөнгө оруулалтын гэрээ олон улсын тавцанд хийхдээ тэргүүлэх шинжтэй байв. Хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ (ХТХОГ) болон Чөлөөт худалдааны гэрээ (ЧХГ) нь Чилийн дэлхийн эдийн засагт нээлттэй оролцох гол бодлогын хэрэгсэл юм.

ХТХОГ-г байгуулах нь Чилийн гадаадын хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах түүнчлэн хөрөнгө оруулагчдыг татах аргачлал байв. 1991 онд Вашингтоны конвенцид гарын үсэг зурсан ба энэхүү конвенцоос Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийг байгуулсан. Энэ үеэс хойш Чили улс ХТХОГ байгуулахаар 51 улстай хэлэлцээрийн ширээнд сууж, 49 улстай гэрээ байгуулснаас 2010 оны байдлаар 36 оронтой энэхүү гэрээгээ хүчин төгөлдөр мөрдөж байна.

Эдийн засгийн мэдээллийн багаас үнэлсэн эрсдлийн жагсаалтад 2011 оны 4-р сарын байдлаар Чили улс нь дэлхийн хамгийн бага эрсдэлтэй улсын нэгт үнэлэгдсэн. Мүүдийгийн эрэмбээр Аa3, S&P индексээр А+ авсан нь дэлхийн хөгжингүй улс орнуудын түвшинд дөхөж байгааг илэрхийлнэ.

Дэлхийн менежмент ба хөгжлийн институцээс эрхлэн гаргасан Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2011-д Чили 25-д жагссан ба Латин Америкийн улс орнууд дундаа тэргүүлэх байр эзэлж байв. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын индексийн хувьд нийт 139 улсаас Чили 30-д жагсаж байна.

Эдийн засгийн мэдээллийн багийн 90 орчим хүчин зүйлс дээр тулгуурлан дэлхийн хамгийн том 82 эдийн засагт хийсэн судалгаанд Чили нь бизнес хийхэд хамгийн таатай улсын 15-р байрт жагсаж байв (Герман 14-т, АНУ 13-д жагсдаг).

Дэлхийн банкнаас гаргасан Бизнес эрхлэхүй индекс Чили 43-рт жагсаж байгаа нь 2010 оноос 6 байр урагшилсан үзүүлэлт юм. Жишээ болгон авахад өмчийг бүртгэх өдрийн тоо Чилид 31 хоног, Латин Америкт 43.9 хоног, OECD-ийн орнуудад 32.7 өдөр байдаг аж.

Хэритэж сангийн тайланд 2011 оны байдлаар Чили нь хамгийн чөлөөт эдийн засагтай улсын нэгээр шалгарсан байна. Нийт 77.4 оноотойгоор дэлхийд 11-т жагсаж байна. Энэ үзүүлэлтээр АНУ 9-д, Япон 20-д тус тус жагсдаг. Нөгөө талаас Фрейзерийн институтээс гаргадаг эдийн засгийн индекс 8.03 оноотойгоор 5-д жагссан нь АНУ-аас нэг байр дээгүүр байна.

Трансперанси Интернэшнлээс тооцсон авилгын индексээр 2010 онд Чили 7.2 оноотойгоор 21-д жагсаж байгаа нь мөн АНУ-аас нэг байр дээгүүр байна. 2009 онтой харьцуулахад энэхүү үзүүлэлт нь 0.5 оноогоор нэмэгдсэн бөгөөд Латин Америкийн бүх орныг гүйцэж, OECD-ийн орнуудтай зэрэгцэх болсон. 2003 оноос хууль эрх зүйн орчноо шинэчилж, сайжруулах замаар авилгын түвшин болон засаглалын чанараа сайжруулж чадсан байна.

Перу Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 30.4 сая

Газар нутаг: 280'000 км²

ДНБ-ий өсөлт: 5.2%

Инфляци: 2.82%

Нэг хүнд ноогдох ҮНБ: 6'270 ам.доллар

Экпортын 39% нь төмөр хүдэр болон метал,

16% нь хүнсний бүтээгдэхүүн, 13% нь түлш,

12% нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн.

Эх сурвалж: UNCTAD, Country profile

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд хамгийн хурдацтай өсч буй Латин Америкийн орнуудын нэг Перу Улс нь манай улстай харьцуулахад 10 дахин их хүн амтай боловч бараг 5 дахин бага газар нутагтай орон ажээ. Тус улс нь бизнес эрхлэх хялбар байдлын индексээр 189 орноос 35-д (2015) жагсдаг ба авилгын индексээр

175 орноос 85-д (2014) жагсдаг.

Эдийн засгийн мөчлөгийг дэмжих засгийн газрын зардал, хэрэглээ болон хувийн хөрөнгө оруулалт нь өсөлтийн гол хөдөлгөгч хүч нь болсон. Перугийн Засгийн газар бараг бүх салбарт гадаад болон дотоод хөрөнгө оруулалтыг татах зорилготой.

АНУ-Перугийн Худалдааг дэмжих хэлэлцээрээс 2 улсын иргэд ашиг хүртэж байсан. Тус гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Перу болон АНУ-ын хоорондын нийт худалдаа 9.1 тэрбум ам.доллараас 16.1 тэрбум ам.доллар болж өссөн байна. Перугийн Худалдааг дэмжих хэлэлцээр нь бүх хөрөнгө оруулалтыг хамгаалдаг. Перу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн болохыг эрмэлдэг. Үүний тулд гишүүн болоход саад болох зүйлсийг судалж эхэлсэн. Судалгаагаар Перу сайжруулах ёстой гол салбараа Боловсролын салбар хэмээн онцолсон. Боловсролын салбарт хөрөнгө оруулалт тусанаас ур чадвартай ажиллах хүчний дутагдалтай байна гэж үзсэн.

1993 оны Үндсэн хууль нь бараг бүх эдийн засгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрдөг. Үндсэн хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулагчид татвараас чөлөөлөх гэх мэт хөрөнгө оруулалтын урамшуулал, үр шимийг хүртэхдээ үндэсний хөрөнгө оруулагчдын адил эрх эдэлнэ. Перуд ГШХО-ыг дэмжих хэд хэдэн хууль байдаг. Үүнд: Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих хууль, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын өсөлтийн хууль эрх зүйн орчин, Олон нийтийн үйлчилгээний дэд бүтцийг дэмжих тухай хууль, ХАА, загасны аж ахуй, ойн аж ахуй, газрын тос, уул уурхай, эрчим хүчтэй холбоотой хууль, Төрийн өмчит аж ахуй нэгжийг дэмжих тухай хууль зэрэг байна.

Азербайжан Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 9.4 сая
Газар нутаг: 82'658 км²
ДНБ-ий өсөлт: 3%
Инфляци: 2,52%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 7'350 ам.доллар
Экпортын 94% нь түлш.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Сүүлийн хэдэн жилүүдэд эдийн засаг болон өсөлтөө нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дэлхийн зах зээлд нэвтрэх тал дээр анхааран ажиллаж байгаа жижиг газар нутагт их хүн амтай Азербайжан Улс нь бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээрээ

189 орноос 180-д (2015), авилгын индексээрээ 175 орноос 126-д (2014) жагсдаг. Мөн түүнчлэн өрсөлдөөний индексээрээ 144 орноос 38-д жагсдаг. Экспортын гол бүтээгдэхүүнүүд нь газрын тос болон байгалийн хий, багаж хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, хөвөн даавуу. Импортын гол бүтээгдэхүүнүүд нь багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүн, төмөр, эм.

Сүүлийн хэдхэн жилийн хугацаанд газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ буурсанаас үнэ нь буурсан, мөн газрын тосны орлогын хавсарсан нөлөө нь Азербайжаны Засгийн газар Дэлхийн худалдааны байгууллага(ДХБ)-д элсэх гэх мэт илүү их шинэчлэл хийх хэрэгтэй болсон.

Азербайжаны гадаадын хөрөнгө оруулалт нь олон улсын гэрээ хэлэлцээрийн тоо, түүнчлэн дотоодын хууль тогтоомжоор зохицуулагддаг. Үүнд: 1996 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Европын холбооны хамтын ажиллагааны гэрээ; 1992 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай хууль; 1995 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тухай хууль; 2010 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль; 2000 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Төрийн өмчийг хувьчлах тухай хууль; 2002 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн Азербайжаны төрийн өмчийг хувьчлах хоёр дахь хөтөлбөр; мөн түүнчлэн Азербайжаны эдийн засгийн тодорхой салбарт зохицуулах хууль тогтоомж. Энэ хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэсний хөрөнгө оруулагчийн ямар ч үйл ажиллагаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг зөвшөөрдөг.

Засгийн газар нь эрчим хүч, тээвэр, ХАА, аялал жуулчлал, мэдээлэл, харилцаа холбооны технологи зэрэг салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалт татдаг.

Хөрөнгө оруулалтын хязгаарлалттай салбарт үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалахтай холбоотой хүмүүс мөн түүнчлэн хөдөө аж ахуй, харилцаа холбоо зэрэг гол салбаруудын авч үзэн хянадаг. 2013 онд Азербайжаны УИХ-аас баталсан даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар заасны дагуу даатгалын компанийн өөрийн хөрөнгийн нэг хувь нь гадаадын хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй гэсэн заалтыг оруулсан.

Азербайжаны хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчид улс болон орон нутгийн өмч хувьчлах хөтөлбөр, орон нутгийн компаниудтай хамтарсан аж ахуйн нэгжээр дамжуулан эсвэл охин компани байгуулах замаар түүнчлэн төлөөлөгчийн газар байгуулан хөрөнгө оруулалт хийж болно.

Гадаадын хөрөнгө оруулалтын саад нь сайн засаглал, олон улсын нягтлан бүртгэлийн хэм хэмжээний үзэл баримтлалтай холбоотой хөрөнгө оруулагчид ээлтэй үйл ажиллагаанд зохицох Азербайжаны бизнесийг бий болгоход хүндрэлтэй байдагтай холбоотой.

Бүгд Найрамдах Кыргыз Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 5,5 сая
Газар нутаг: 191'800 км²
ДНБ-ий өсөлт: 5,0%
Инфляци: 6,61%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 1'200 ам.доллар
Экпортын 44% нь аж үйлдвэрийн, мөн 15% нь түлш, 10% нь төмрийн хүдэр, метал.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Бүгд Найрамдах Кыргыз Улс нь хөрөнгө оруулагчдын хувьд маш өндөр эрсдэлтэй орон юм. Учир нь хууль эрхзүйн орчин хангагдсан боловч шүүхийн тогтолцоо нь хараат бөгөөд хуулийн хэрэгжилт муу байдаг. Ялангуяа оюуны өмчийн эрх ихээр зөрчигддөг байна. Transparency International-ээс зарладаг авилгын индексээр 175 орноос 136-д (2014 он),

Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр 189 орноос 102-д (2014 он) жагссан байна.

Нөөцийн олборлолт гэх мэт улс төрийн хувьд мэдрэмжтэй салбарын хөрөнгө оруулагчдад дахин хэлэлцээрийн гэрээ хийхэд цаг хугацаа их шаарддаг нь Канадын эзэмшлийн Кумтор алтны уурхайн туршлага баталдаг.

Бүгд Найрамдах Кыргыз Улсын гадаадын шууд хөрөнгө жил бүр өссөөр байгаа нь тодорхой хэмжээгээр шинэ ажлын байр бий болгож буй ОХУ болон БНХАУ-ын дэд бүтэц дэх хөрөнгө оруулалттай холбоотой байна. Гэвч БНХАУ-ын дэд бүтцийн төслүүд нь зөвхөн Хятад улсын бараа бүтээгдэхүүний зах зээлийг дэмжихэд чиглэж байгаа бол ОХУ-ын эдийн засгийн хямрал амласан хөгжлийн туслалцааг хойшлуулахад хүргээд байна. Кыргыз улсын засгийн газар ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтөнд ГШХО чухал нөлөөтэй гэж үзэн, энэ өсөлтийг дэмжих эдийн засгийн хөгжлийн стратегийн чиглэлийг боловсруулжээ. Тиймээс бизнес эрхлэхэд оновчтой татварын бодлогын арга хэмжээг авсаар байна. Үүнээс гадна, Кыргыз улсын эрчим хүчний станц, зам, суваг элэгдэж хуучирсан учраас дэд бүтцийн асуудал тулгараад байна. Ялангуяа нийслэл

Бишкек хотод эрчим хүчний нийлүүлэлт дутагдаж, хотын хог хаягдал тулгамдсан асуудал болжээ. Дээр дурьдсанчлан Кыргыз улсын хамгийн том хөрөнгө оруулалтын төслүүд нь дэд бүтэц болон эрчим хүчний салбарынх байдаг бөгөөд ОХУ болон БНХАУ хөрөнгө оруулалтаар санхүүждэг. Гэвч хөрөнгө оруулалтын мөнгөний өгөөж урт хугацаанд ч тодорхой бус байна.

Бүгд Найрамдах Кыргыз Улсын ГШХО-ыг зохицуулах эрхзүйн орчны гол хууль болох “хөрөнгө оруулалтын тухай” 2003 оны хууль өнөөдрийг хүртэл хэвээр хадгалагдсаар байна. Кыргыз Улсын шүүхийн систем үр ашиггүй бөгөөд бие даасан бус байдаг ба хэргийг шийдвэрлэхэд олон жил зарцуулдаг.

Гадаад хяналтын тухай албан ёсны хязгаарлалтгүй ч засгийн газар улс төрийн мэдрэмтгий салбар дахь томоохон хөрөнгө оруулагчдаас өндөр хөдөлмөр эрхлэлт эсвэл орон нутгийн захирлуудын зөвлөлд бага суудал эзэмшихийг шаарддаг.

Казакстан Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 16,4 сая
Газар нутаг: 2'699'700 км²
ДНБ-ий өсөлт: 6,5%
Инфляци: 5,84%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 11'550 ам.доллар
Экпортын 76% нь аж үйлдвэрийн, 10% нь төмрийн хүдэр, метал, 10% нь түлш.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Казакстан Улс 1991 онд тусгаар тогтнолоо олж авснаас хойш зах зээлийн эдийн засгийг бий болгох чухал алхамуудыг хийж, ГШХО-ыг татах үр дүнтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. 2014 оны байдлаар Казакстан дахь нийт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 211.5 тэрбум

ам.доллар байсан бөгөөд үүнээс 129.3 тэрбум ам.доллар нь ГШХО-аар орж ирсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын дийлэнх нь газрын тос, байгалийн хийн салбарт хийгдсэн ба 2005 оноос 2014 оны есдүгээр сарын хоорондох Казакстан дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 14 тэрбум ам.долларыг АНУ хөрөнгө оруулж, тэргүүлэх эх үүсвэрийн нэг болжээ.

Казакстан улсын хүнд суртал, саад бэрхшээлийг арилгах арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа ба Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр 189 орноос 77-д (2014 он) жагссан байна. Гэсэн хэдий ч Казакстан улсад ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулагчдад авилга, хүнд суртал бэрхшээлтэй хэвээр байгаа бөгөөд авилгын индекс тооцдог Transparency International агентлагийн судалгаагаар 175 орноос 126-д (2014 он) орсон байна.

Казакстан улсын засгийн газар олон улсын хөрөнгө оруулагчидтай яриа хэлэлцээр хийн, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах ажлуудыг хийж байгаа ба ерөнхийлөгч Назарбаев гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд таатай уур амьсгалыг бий болгохоо олон нийтэд амласан байна. 2014 оны зургадугаар сард Казакстаны эдийн засгийн олборлолтын бус салбаруудыг дэмжих хөрөнгө оруулагчдад давуу олгохоор хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Казакстан улс нүүрс устөрөгч болон ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийн

эдийн засагт гол байр суурь эзлэдэг ба энэ салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдсэн хэвээр байна. Казакстан улсын хөрөнгө оруулалтын орчинг бүс нутагтаа хамгийн сайн гэж үздэг бөгөөд олон улсын компаниуд Казакстан улсад бүс нутгийн төвөө байгуулжээ.

Казакстан улсын гадаадын хөрөнгө оруулагчдад дараах хуулиуд үйлчилдэг. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын 2003 оны тухай хууль,
- Иргэний хууль
- Албан татварын хууль,
- Гаалийн тухай хууль,
- Валютын хяналтын тухай хууль,
- Засгийн газрын худалдан авалтын тухай хууль

Эдгээр хуулиудын хэрэгжилт засгийн газрын түвшин бүрт ялгаатай байдаг нь хөрөнгө оруулагчдад томоохон саад бий болгодог байна.

Казакстан улсын засгийн газар уул уурхай, төмөр замын тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, барилга, төмөрлөгийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эм, мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч, салхины болон нарны эрчим хүчний салбарт 20 сая ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай урамшууллыг олгоход бэлэн байна. 2009 онд орлогын албан татварыг 30 хувиас 20 хувь, нэмүү өртгийн албан татварыг 16 хувиас 12 хувь болгож тус тус бууруулсан байна.

Банк, даатгалын салбарт гадаадын хөрөнгийн оролцоог хязгаарлах ямар нэгэн бэрхшээл байхгүй ч гадаадын банк болон гадаадын даатгалын компанийн салбарууд Казакстанд үйл ажиллагаа явуулахыг хориглодог ба хөдөө аж ахуйн газрыг гадаадын хуулийн этгээд, хувь хүн эзэмшихийг хязгаарладаг байна.

Узбекистан Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

Нийт хүн ам: 28,9 сая
Газар нутаг: 425'400 км²
ДНБ-ий өсөлт: 6,99%
Инфляци: 12,00%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 1'880 ам.доллар
Экпортын 40% нь аж үйлдвэрийн, мөн 13% нь төмрийн хүдэр, метал, 10% нь хүнсний бүтээгдэхүүн.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Манай улстай харьцуулахад газар нутаг багатай ч бүс нутгийн хамгийн их хүн амтай Узбекистан Улс нь Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр 189 орноос 141-д (2014 он) жагсаж, Transparency International-ээс зарладаг авилгын индексээр 175 орноос доогуур байр буюу 166-д (2014 он) орсон байна.

Узбекистан Улсын засгийн газар оюуны өмчийн эрх, хөрөнгө оруулагч болон ажилчдын эрх зэрэг бизнес болон хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах хууль, журманд голчлон анхаарлаа хандуулдаг.

Узбекистан Улсын засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалт татах хүчин чармайлт их гаргасан хэдий ч сүүлийн дөрвөн жилийн хугацаанд ГШХО-ын хэмжээ огцом бууржээ. Узбекистан Улсын засгийн газар татварын хөнгөлөлт, гаалийн чөлөөлөлт зэрэг хэд хэдэн тусгай хөрөнгө оруулалтын бүс болон бусад урамшууллыг бий болгосон ч хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хязгаарлан, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нөлөө ихтэй тодорхой стратегийн аж үйлдвэрийн салбаруудад илүү анхаарал андуулсан байна.

Засгийн газар эсвэл төрийн харьяа байгууллагуудын дэмжлэггүй бол гадаадын хөрөнгө оруулагчдын Узбекистан дахь бизнесийн боломж хязгаарлагдмал байдаг. Засгийн газар нь импортыг орлуулах болон экспортын баримжаатай аж үйлдвэржилтийн бодлоготой нийцэж байгаа хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын төслийг талархан хүлээн авдаг боловч импортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг сааруулдаг байна. Уул уурхай, хөвөн даавууны боловсруулалт, тээвэр, газрын тос болон байгалийн хийн салбар зэрэг онцгой ач холбогдол бүхий эдийн засгийн чухал салбаруудын гадаадын хөрөнгө оруулалтыг нарийвчлан нягталж үздэг.

Узбекистан Улсын засгийн газар хөдөө аж ахуй, барилга, барилгын тоног төхөөрөмж, химийн бодис, петрохимийн үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа, эрчим хүч, уул уурхай, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эрүүл мэндийн технологи, мэдээлэл харилцаа холбоо, нэхмэл утас, бэлэн хувцас, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж болон бусад хангамжуудад хийх хөрөнгө оруулалтанд татварын урамшуулал санал болгох замаар ГШХО-ыг дэмжиж байна.

Гэвч гадаадын хөрөнгө оруулалтанд хэд хэдэн албан ёсны нэмэлт хязгаар байдаг. Агаарын тээвэр, төмөр зам, эрчим хүч, холын зайн цахилгаан холбооны сүлжээ болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой бусад салбарт гадаадын эзэмшил болон хяналтыг хориглодог. Харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, санхүү, даатгал, аялал жуулчлалын салбарууд арай бага хязгаарлалттай байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалт 30 хувиар хязгаарлагддаг бол санхүүгийн салбарын гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн тогтмол санхүүжилт шаардлагатай байгаа Узбекикийн компаниуд эсвэл банктай хамтарч үйл ажиллагаа явуулж болно. Харин аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалт аливаа бизнесийн 49 хувиас хэтэрч болохгүй.

Ангол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

2013 оны байдлаар Ангол Улс:
Нийт хүн ам: 21.5 сая
Газар нутаг: 1'246'700 км²
ДНБ-ий өсөлт: 7.5%
Инфляци: 8.78%
Нэг хүнд ноогдох ҮНБ: 5'010 ам.доллар
Экпортын 99% нь түлш.
Эх сурвалж: UNCTAD, Country profile

Ангол нь Африкийн газрын тосны 2 дахь том экспортлогч мөн АНУ-ын худалдааны 3 дахь хамгийн том түнш юм. Тус улсын экспортын гол бараанууд нь газрын тос, алмаз, боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүнүүд, кофе, загас, загасны аж ахуй, мод, даавуу. Харин

импортын гол бараанууд нь машин механизм, цахилгаан тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги, эм, хоол хүнс, нэхмэл, цэргийн бараа зэрэг болно. Олон жилийн турш колонидад байсан тус улс нь бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээрээ 189 орноос 181-т(2015), авилгын индексээр 175 орноос 161-т(2014) байна. Дэлхийн банкнаас бизнес эрхлэхэд хялбар байдлын индексээр ийм доогуур байгааг тусгай зөвшөөрөл олгох хугацаа хэт удаан байгаатай холбосон.

Эдийн засгийн орчин буюу хөгжлийн түүх

Ангол Улс нь 1975 оны 11 дүгээр сард Португалийн колоничлолоос ангижирч тусгаар тогтнолоо зарласан хэдий ч иргэний дайн 2002 он хүртэл үргэлжилжээ. 2002 оноос хойш Ангол хөсөр хаягдсан дэд бүтцээ дахин сэргээж эхэлсэн ба үүнээс хойш эдийн засаг нь сэргэсэн хэдий ч газрын тос, байгалийн хий, алмаз эрдэнийн асар их нөөцтэй боловч ядуу улс хэвээр л байв. Тухайн нутгаас олдох газрын тосны хэмжээ улам нэмэгдэж дээрээс нь дэлхийн зах зээл дээр үнэ нь ч өсөж байсан боловч тус салбарт авилга, хээл хахууль, төрийн буруу менежмент байсаар байв.

Авилга, хээл хахууль, хүний эрхийн зөрчил, алмаз эрдэнийн хууль бус хилийн худалдаа зэргээсээ болж гадаад хөрөнгө оруулагчдыг татаж чаддаггүй.

Ангол газрын тос, алмаз эрдэнэ, төмрийн хүдрийн баялагаас гадна алт ойн бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ гээд нөөц баялаг их боловч 27 жил үргэлжилсэн иргэний дайны улмаас ч тэр үү ядуурлын хэмжээ нь буурдаггүй хэвээр байгаа улс юм.

Хууль, эрх зүйн орчин

Анголын Засгийн газар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаа хөрөнгө оруулалтыг дэмжих зохицуулах байгууллага болох Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үндэсний газараар дамжуулан идэвхтэй хайдаг. Анголын хувийн хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулагчдад олгох боломжит ашиг, урамшууллын талаар заасан байдаг. Хөрөнгө оруулагчдыг сэтгэл хангалуун байлгах урамшууллын доод хэмжээ нь 2011 онд 100,000 ам.доллараас 1 сая ам.доллар хүртэл өссөн. Хөрөнгө оруулагчид урамшууллын эрхтэй хөрөнгө оруулалтын нөхцөл байгуулж ХХХОУГ-тай гэрээ хийх ёстой. Мөн 10 сая ам.доллараас 50 сая ам.долларын хоорондох хөрөнгө оруулалт нь Сайд нарын зөвлөлөөр батлагдсан байх ёстой, түүнчлэн 50 сая ам.доллараас их хөрөнгө оруулалтыг Ерөнхийлөгчийн хороонд танилцуулан зөвшөөрөл авах шаардлагатай.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хууль нь дараах хувийн байгууллагад хувийн хөрөнгө оруулалт хийхийг хориглодог. Үүнд: Батлан хамгаалах газар, Дотоодын улсын аюулгүй байдлыг хангах байгууллага, Төв банк болон Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа банк,

нисэх онгоцны байгууллага болон улсын онцгой үүрэг гүйцэтгэдэг нутгийн захиргаанууд.

Ангол буурай хөгжилтэй, санхүүгийн салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх мөн Анголын мөнгөн тэмдэгтийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн банкуудаар дамжуулан бүх төлбөр тооцоог кванзаар хийнэ гэсэн гадаад валютын хуулийг баталсан.

Нигери Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, 2014 он

2013 оны байдлаар Нигери Улс:

Нийт хүн ам: 173.6 сая

Газар нутаг: 910'770 км²

ДНБ-ий өсөлт: 6.6%

Инфляци: 8.48%

Нэг хүнд ноогдох ҮНБ: 2'710 ам.доллар

Экпортын 94% нь түлш.

Эх сурвалж: UNCTAD, Country profile

Газрын тосны нөөцөөрөө дэлхийд 10-т ордог Нигери улс нь Африкдаа хамгийн их хүн амтай мөн хамгийн газрын тосны нөөцтэй орон юм. Ту улс нь бизнес эрхлэхэд таатай байдлын индексээр 189 орноос 170-д жагсдаг бол авилгын индексээр 174 орноос 136-д жагсдаг байна. Зөвхөн газрын тосны

салбартаа найдсан Нигерийн эдийн засаг улс төрийн тогтворгүй байдал, макро эдийн засгийн ядуу бодлого болон авилгад удаан идэгдсэн. Экспортын гол бүтээгдэхүүнүүд нь газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний 95%, какао, резинэн чихэр. Импортын гол бүтээгдэхүүнүүд нь машин механизм, химийн бодис, тээврийн тоног төхөөрөмж, үйлдвэрлэсэн бараа, хоол хүнс, амьд амьтад.

Эдийн засгийн орчин буюу хөгжлийн түүх

Хүнс, тээврийн хэрэгсэл, техник химийн бүтээгдэхүүн гээд бараг бүхий л зүйлийг импортоор хангадаг энэ улс эрдэс баялагийн нөөцөөрөө хөшүүрэг хийн, хүн амых нь 70 хувийг эзэлсэн ядуурлаас гарахыг оролдож байна. Энэ салбарын орлогын 80% нь Засгийн газарт төвлөрч, 16% нь үйл ажиллагааны зардалд зарцуулагдаж, үлдсэн 4% нь хөрөнгө оруулагчдад үлддэг. Гэвч иргэдэд ганц хувь нь л очдог. Нигерийн эрх баригчид орлогоо хувиарлаж чаддаггүйн дээр буруу бодлого баримталдаг нь харагдаж байна. Мөн хүн амых нь хагас нь боловсрол эзэмшээгүй гээд энэ улсад дэд бүтэц дутагддаг.

2003-2007 онд эдийн засгийн шинэчлэл хийхээр Үндэсний эдийн засгийн хөгжүүлэх стратеги хэмээх хөтөлбөр боловсруулснаар ахуйн хэрэглээний цэвэр усны хомсдол, эрчим хүчний найдваргүй хангамж, усалгаа, авилга, хувийн салбарыг хөгжүүлэхэд саад болж байсан тотгорыг арилгах зэрэгт бага ч гэсэн ахиц орсон байна.

Хөрөнгө оруулалт муу байдгых нь нэг шалтгаан нь хэт өндөр татвартай холбоотой гэж үздэг. Тиймээс Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд татвараа бууруулсан. Мөн Дэлхийн хүмүүнлэгийн тусламжийн болон санхүүгийн байгууллагаас байнгын хандив, тусламж өгч төсөл хэрэгжүүлдэг.

Нигерийн гол хөгжилд хандах хөрөнгө оруулагчдын хандлага нь дараах хүчин зүйлсийг тусгасан байна.

1. Найра (Naira)-гийн бууралт
2. Гадаадын валют болон санхүүгийн тулгамдсан асуудлууд
3. Сонгууль
4. 2014 оны Эбола вирус нь Нигерийн хөрөнгө оруулагчдад сөргөөр нөлөөлж байсан.

Хууль, эрх зүйн орчин

1995 онд Нигерийн хөрөнгө оруулалтыг дэмжих комиссын тухай хуульд ГШХО-ын хязгаарлалт болон хяналт, бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, гадаадын эзэмшигч бүх салбарт 100% хөрөнгө оруулах боломж зэргийг оруулсан. Нигерийн хөрөнгө оруулалтыг дэмжих комиссын гаргасан хөрөнгө оруулалтын нэг цэгийн төвд шинээр бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулалтын захиргааны журмыг хялбарчлах зорилгоор төрийн болон төрийн оролцоотой 27 байгууллагыг оруулсан. Гадаадын хөрөнгө оруулагчид нь дотоодын хөрөнгө оруулагчдын адил эрхтэй байдаг. Улсын хүчтэй бодлого байхгүй ч гэсэн Нигерит бизнес болон хөрөнгө оруулалтын шийдэгдээгүй асуудлууд хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байсан.

Нигерийн засгийн газар импортоор бүтээгдэхүүнүүд оруулахаас илүүтэйгээр дотооддоо үйлдвэрлэхийг илүүд үзэж импортыг орлуулах бодлогыг дэмждэг.

Нигерийн бодлогын хянагчид газрын тос болон байгалийн хийн ГШХО-ыг төрөлжүүлэхийн тулд бүс нутгийн итерацийн давуу талыг ашиглан зохицуулалтыг сайжруулж, орон нутгийн аж үйлдвэрийн чадавхыг дэмжиж байна. Одоогоор Нигерийн хөрөнгө оруулалтын гадаад хяналтад ямар нэг хязгаарлалт байхгүй.

1995 оны Үндэсний хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд зааснаар гадаад болон дотоод хувийн хөрөнгө оруулалтыг хориглосон дараах салбарууд байна. Үүнд: зэвсэг олон сумны үйлдвэрлэл, сэтгэцэд нөлөөлөх бодис, мансууруулах эмийн үйлдвэрлэл, цэргийн хувцас хэрэглэлийн үйлдвэрлэл, Холбооны гүйцэтгэх зөвлөлийн хэрэгсэл багтана.

Хүснэгт 25. Сонгосон орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт

Улс, орнууд	Зохицуулалтын онцлог	Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны бодлого
Намиби Улс	Төрийн өмчит компаниудад стратегийн ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгон уул уурхайн салбарт дотоодын компаниудын оролцоог нэмэгдүүлсэн.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд гадаад хөрөнгө оруулагчид дотоод хөрөнгө оруулагчидтай ижил эрхтэй байна гэж заасан боловч Засгийн газар зарим нэг хязгаарлалтыг тавих эрхтэй. Жишээ нь тусгай зөвшөөрөл авах асуудалд.
Габон Улс	Шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын хязгаарлагдмал хүчин чадал, үйлдвэрлэлийн зардал өндөр дотоодын зах зээл нь жижиг, хөдөлмөрийн хууль нь хөшүүн, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтэц муутай, гаалийн дүрэм хэрэглээнд нийцдэггүй зэрэг асуудлууд нь гадаад хөрөнгө оруулагчдад төвөгтэй байдаг.	Хөрөнгө оруулалтын хуулиараа гадаад болон дотоод бизнес эрхлэгчид ижил эрхтэй гэж заасан ба уул уурхай, ойн аж ахуй, газрын тос, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулагчийг гааль татварын урамшуулал олгож, дэмжих бодлого явуулдаг.
Узбекистан Улс	Засгийн газар нь оюуны өмчийн эрх, хөрөнгө оруулагч болон ажилчдын эрх зэрэг бизнес болон хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах хууль, журманд голчлон анхаарлаа хандуулдаг. Импортыг орлуулах болон экспортын баримжаатай аж үйлдвэрийн бодлого баримталдаг.	Засгийн газар хөдөө аж ахуй, барилга, барилгын тоног төхөөрөмж, химийн бодис, петрохимийн үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа, эрчим хүч, уул уурхай, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эрүүл мэндийн технологи, мэдээлэл харилцаа холбоо, нэхмэл утас, бэлэн хувцас, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж болон бусад хангамжуудад хийх хөрөнгө оруулалтанд татварын урамшуулал санал болгох замаар ГШХО-ыг дэмждэг. Хэвлэл мэдээллийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг 30 хувиар хязгаарлагддаг, санхүүгийн салбарын гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн тогтмол санхүүжилт шаардлагатай байгаа Узбекистаны компаниуд эсвэл банктай хамтарч үйл ажиллагаа явуулж болно. Харин аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалт аливаа бизнесийн 49 хувиас хэтэрч болохгүй.
Бүгд Найрамдах Кыргыз Улс	Хууль эрхзүйн орчин хангагдсан боловч шүүхийн тогтолцоо нь хараат; Эдийн засгийн өсөлтөд ГШХО чухал нөлөөтэй гэж үзэн, энэ өсөлтийг дэмжих эдийн засгийн хөгжлийн стратегийн чиглэлийг боловсруулсан; Хамгийн том хөрөнгө оруулалтын төслүүд нь дэд бүтэц болон эрчим хүчний салбарынх байдаг.	ОХУ болон БНХАУ-ын дэд бүтэц дэх хөрөнгө оруулалттай холбоотойгоор ГШХО нь жил бүр өссөөр байгаа; Гадаад хяналтын тухай албан ёсны хязгаарлалтгүй ч засгийн газар улс төрийн мэдрэмтгий салбар дахь томоохон хөрөнгө оруулагчдаас өндөр хөдөлмөр эрхлэлт эсвэл орон нутгийн захирлуудын зөвлөлд бага суудал эзэмшихийг шаарддаг;

“ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЗОХИСТОЙ БОДЛОГО”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

<p>Казакстан Улс</p>	<p>Казакстан улсын засгийн газар уул уурхай, төмөр замын тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, барилга, төмөрлөгийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эм, мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч, салхины болон нарны эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай урамшуулалтай.</p>	<p>Банк, даатгалын салбарт гадаадын хөрөнгийн оролцоог хязгаарлах ямар нэгэн бэрхшээл байхгүй ч гадаадын банк болон гадаадын даатгалын компанийн салбарууд Казакстанд үйл ажиллагаа явуулахыг хориглодог ба хөдөө аж ахуйн газрыг гадаадын хуулийн этгээд, хувь хүн эзэмшихийг хязгаарладаг байна.</p>
<p>Ботсван Улс</p>	<p>Дэд бүтэц нь сайн хөгжсөн; Уул уурхайн салбарын эзэмшилтэд хяналт тавьж эхэлсэн; Газрын тосны үйлдвэр байгуулсан.</p>	<p>ХАА, алмаз, боловсрол, эрүүл мэнд, тээврийн салбар дахь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмждэг; Бизнес эрхлэх хүсэлтэй гадаадын иргэд Худалдааны хуульд заасны дагуу холбогдох тусгай зөвшөөрөл авах шаардлагатай;</p>
<p>Азербайжан Улс</p>	<p>Даатгалын компанийн өөрийн хөрөнгийн нэг хувь нь гадаадын хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй.</p>	<p>Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэсний хөрөнгө оруулагчийн ямар ч үйл ажиллагаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг зөвшөөрдөг; Эрчим хүч, тээвэр, ХАА, аялал жуулчлал, мэдээлэл, харилцаа холбооны тенологи зэрэг салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалт татдаг; Үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалахтай холбоотой байгууллага мөн түүнчлэн хөдөө аж ахуй, харилцаа холбоо зэрэг салбаруудад хязгаарладаг;</p>
<p>Оросын Холбооны Улс</p>	<p>Засгийн газар АНУ, Европын холбоо, Канад, Австрали болон Норвеги зэрэг улсуудаас оруулж ирэх хүнсний бүтээгдэхүүний импортдоо хориг тавьсан; өргөн хүрээтэй импортыг орлуулах бодлогыг дэмждэг; бизнес эрхлэгчдыг сурталчлах хамгаалах нэмэлт арга хэмжээнүүдийг зохион байгуулах зорилгоор бизнес эрхлэгчдийн эрхийн төлөөх Омбудсманы байр суурийг бий болгосон</p>	<p>Гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалт нь 2008 оны Стратегийн салбарын тухай хуулийн тусламжтайгаар улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратеги болсон ОХУ-ын ГШХО нь тойрог хэлбэрийн ГШХО-д орно учир нь хоёрдогч улсаар дамжин гардаг</p>
<p>Перу улс</p>	<p>Засгийн газар бараг бүх салбарт гадаад болон дотоод хөрөнгө оруулалтыг татах зорилготой; Боловсрол гэх мэт салбарын дэд бүтэц муу хөгжсөн.</p>	<p>Худалдааг дэмжих хэлэлцээр нь бүх хөрөнгө оруулалтыг хамгаалдаг; Гадаадын хөрөнгө оруулагчид татвараас чөлөөлөх гэх мэт хөрөнгө оруулалтын урамшуулал, үр шимийг хүртэхдээ үндэсний хөрөнгө оруулагчдын адил эрх эдэлнэ.</p>

Ангол Улс	Газрын тос, байгалийн хий, алмаз эрдэнийн асар их нөөцтэй боловч ядуу улс хэвээр л байдаг; дээрх салбарт авилга, хээл хахууль, төрийн буруу менежмент байсан тул эдийн засаг хөгждөггүй; санхүүгийн салбарын хүчин чадлыг нэмэгдүүлэх мөн Анголын мөнгөн тэмдэгтийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн банкуудаар дамжуулан бүх төлбөр тооцоог өөрийн мөнгөн тэмдэг (кванз)-ээр хийнэ гэсэн гадаад валютын хуулийг баталсан.	Хөрөнгө оруулагчдыг сэтгэл хангалуун байлгах урамшууллын доод хэмжээг 100,000 ам.доллараас 1 сая ам.доллар хүртэл өсгөсөн. 10 сая ам.доллараас 50 сая ам.долларын хоорондох хөрөнгө оруулалт нь Сайд нарын зөвлөлөөр батлагдсан байх ёстой, түүнчлэн 50 сая ам.доллараас их хөрөнгө оруулалтыг Ерөнхийлөгчийн хороонд танилцуулан зөвшөөрөл авах шаардлагатай. Батлан хамгаалах газар, Дотоодын улсын аюулгүй байдлыг хангах байгууллага, Төв банк болон Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа банк, нисэх онгоцны байгууллага болон улсын онцгой үүрэг гүйцэтгэдэг нутгийн захиргаануудад хувийн хөрөнгө оруулалт хийхийг хориглодог.
Нигери Улс	Нигерийн эрх баригчид орлогоо хувиарлаж чаддаггүйн дээр буруу бодлого баримталдаг; дэд бүтэц дутагдалтай; Нигерийн засгийн газар импортоор бүтээгдэхүүнүүд оруулахаас илүүтэйгээр дотооддоо үйлдвэрлэхийг илүүд үзэж импортыг орлуулах бодлогыг дэмждэг.	Хөрөнгө оруулалт муу байдгых нь нэг шалтгаан нь хэт өндөр татвартай холбоотой; Нигерийн хөрөнгө оруулалтыг дэмжих комиссын тухай хуульд ГШХО-ын хязгаарлалт болон хяналт, бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, гадаадын эзэмшигч бүх салбарт 100% хөрөнгө оруулах боломж зэргийг оруулсан; Гадаадын хөрөнгө оруулагчид нь дотоодын хөрөнгө оруулагчдын адил эрхтэй байдаг; гадаад болон дотоод хувийн хөрөнгө оруулалтыг зэвсэг болон сумны үйлдвэрлэл, сэтгэцэд нөлөөлөх бодис, мансууруулах эмийн үйлдвэрлэл, цэргийн хувцас хэрэглэлийн үйлдвэрлэл, Холбооны гүйцэтгэх зөвлөлийн хэрэгсэл салбаруудад хориглодог.

ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын макро эдийн засгийн болон ГШХО-ын орчны судалгааг хийж, эдийн засагт үзүүлэх нөлөө болон ГШХО-д нөлөөлдөг хүчин зүйлс, ГШХО-ыг шингээх чадварыг тодорхойлсноор дараах дүгнэлтүүдэд хүрлээ. Үүнд:

1. Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар дахь ГШХО хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд 2011 оноос эхлэн уул уурхай дахь ШХО-ын 1%-ын өсөлт нь бусад салбартаа үзүүлэх нөлөө нь нэмэгдсэн. Харин дотоодын хөрөнгө оруулалтын нөлөө нь буурсан байна.
2. Уул уурхайн гарцад ХАА-ын эцсийн хэрэглээний зардлын үзүүлэх нөлөө буурч, хөрөнгийн нийт хуримтлалын нөлөө өсөж байна. Харин уул уурхайн гарцад тээврийн салбарын эцсийн хэрэглээний зарлын үзүүлэх нөлөө жил ирэх бүр буурч байсан хэрнээ уул уурхайн гарцад экспортын дүнгийн үзүүлэх нөлөө өсөж байна. Мэдээлэл холбоо, санхүү даатгалын үйлчилгээ, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд зэрэг үйлчилгээний салбарын уул уурхайд үзүүлэх нөлөө өндөр байна.
3. ГШХО-д нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаанаас бодит ДНБ болон төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш ГШХО-тай **урт хугацаанд эерэг** хамааралтай бол байгалийн баялаг сөрөг хамааралтай байдаг нь тогтоогдлоо. Урт хугацаанд бодит ДНБ 1%-иар өсөх нь ГШХО-ыг 9.6%-иар, нэрлэсэн ханш 1%-иар өсөх (сулрах) нь ГШХО-ыг 8.5-иар өсгөдөг. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулрах нь ам.доллар болон бусад валютаар хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагч нарт ханшийн дахин үнэлгээний ашиг олох боломжийг олгодог. Иймд ГШХО болон нэрлэсэн ханшийн хооронд урт хугацааны эерэг хамаарал оршин байдаг байна.
4. Хөрөнгө оруулалтыг шингээх чадварын индекс 1-тэй тэнцүү байх нь тухайн улс эдийн засгийн цар хүрээтэйгээ нийцтэй хөрөнгө оруулалтыг татаж байна гэдэг утгыг илэрхийлдэг. Аж үйлдвэржсэн, хөгжингүй, эсвэл аж үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлогч орнуудын хувьд ГШХО-ыг шингээх чадварын индекс дунджаар 1-тэй тэнцүү байдаг бол Монгол Улстай ижил төстэй шинжээр сонгосон 11 орны хувьд тус индекс дунджаар 3-тай тэнцүү гарсан. Иймд манай улсын хувьд ГШХО-ыг шингээх чадварын индексийг [1;3] засварт байлгах буюу ДНБ-д эзлэх ГШХО-ын хувиар илэрхийлбэл ГШХО нь ДНБ-ийхээ [3%; 9%] байлгах нь зохистой юм.
5. ГШХО-ын шингээх чадварын индекс тухайн ондоо 1-ээс их утгыг авбал тухайн улс зах зээлийн багтаамжаасаа давсан ГШХО-ыг татсан байгааг илэрхийлдэг бол уг индексийн хэлбэлзлийн далайц өндөр байх нь тухайн улс эдийн засгийн цар хүрээнээс үл хамааран бизнесийн орчин, эдийн засгийн болон бодлогын тогтвортой байдал, байгалийн нөөцийн төрх байдал, дэд бүтэц, ур чадвар болон технологи, ГШХО-ын дэмжлэгийн үр ашигтай байдал эсвэл өмч хувьчлалд оролцох боломж зэрэг хүчин зүйлүүдийн улмаас ГШХО хэлбэлзэж байгааг илэрхийлдэг. Манай улсын хувьд 2011 оноос хойш өнөөг хүртэл тус индексийн утга маш ихээр хэлбэлзсэн буюу буурсан. Энэ нь улс төрийн тогтворгүй байдал, болон

- гадаадын хөрөнгө оруулалт нь нэг салбараас, нэг том төслөөс хамааралтай байгаад, төслийн үйл явц тогтворгүй байсантай холбоотой.
6. Иймд нэг салбараас хамааралтай байдал, нэг том төслөөс хараат байдлыг арилгах тал дээр анхаарах нь зүйтэй. Манай улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг улсын хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын 1/3-аас хэтрэхгүй байх, гадаадын төрийн өмчит компанийн үйл ажиллагааг хязгаарласан байдаг нь нэг улсаас хамааралтай байдлыг хязгаарласан зохицуулалт мөн. Гэхдээ энэ заалт нь бодит байдалд биелэлээ олж чадаагүй байна. 2009 оноос өмнө гадаадын нийт хөрөнгө оруулалтын 60%-аас илүү хувийг зөвхөн Хятад Улсаас оруулдаг байсан бол 2011 онд гадаадын нийт хөрөнгө оруулалтын 38%, 2013 оны гадаадын нийт хөрөнгө оруулалтын 40% нь зөвхөн Нидерланд Улсаас орсон байна. Үндэстэн дамнасан үйлдвэрүүд охин компани нээн ажиллуулахад татварын нэн таатай нөхцөлийг олгодог Нидерланд, манай улсын хувьд хөрөнгө, орлогоос давхардуулан татвар авахгүй байх тухай хоёр талт хэлэлцээрийн сөрөг нөлөө харьцангуй ихтэй Нидерланд, Английн Виржини Арал, Люксембург улсуудаас орж ирсэн хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн байна. Иймд гадаадын хөрөнгө оруулагчтай хамтарч ажиллахдаа манай улс олон улсад хийгдсэн гэрээ, хэлэлцээрийн нөлөөг давхар тооцдог байх шаардлагатай. Олон улсын туршлагаас харахад бид уул уурхайгаас хэт хамааралтай байдлыг шийдэх үндсэн хоёр үе шатууыг хэрэгжүүлж болно. 1-р шатанд, уул уурхайн салбараас орж ирж буй орлогыг өнөөдөртөө бүрэн зарцуулж дуусгахгүйгээр, тодорхой сан үүсгэж хуримтлуулж, илүү сайн үр өгөөжтэй ашиглах боломжийг хайх, 2-р шатанд, хуримтлагдсан сангаасаа бусад салбаруудыг дэмжих бодлого баримтлах. Хоёр дахь шатанд Бостван Улс шиг зарим нэр төрлийн үйл ажиллагаанд зөвхөн дотоодын үйлдвэрлэгч нарт зөвшөөрөл олгодог байх шаардлагатай.
 7. Гадаадын хөрөнгө оруулалтыг татаад эдийн засгаа амжилттай хөгжүүлсэн орнуудын жишээг амжилт муутай болгосон улсуудтай харьцуулан судалахад дараах ерөнхий ялгаа харагдсан. Үүнд: амжилттай хөгжсөн орны институцийн чанар сайн, авилга, хүнд суртал багатай, бизнес эрхлэхэд харьцангуй хялбар байсан. Түүнээс гадна дэд бүтэц сайн хөгжсөн нь амжилтад хүрэх хоёр дахь үндсэн нөхцөл болж байжээ. Манай эдийн засагт ГШХО-ын үзүүлэх нөлөөг тодорхойлсон судалгаанаас ГШХО-ын хэмжээ 1%-ийн өсөлтийн нөлөө нь тээвэр, дэд бүтцийн салбарыг 2011 онд 0,19%-аар, 2012 онд 0,066%-аар, 2013 онд 0,041%-аар тус тус өсгөдөг болох нь тодорхойлогдсон. Энэ нөлөө нь 2011 ондоо бусад салбаруудтай харьцуулахад өндөрт тооцогдож байсан хэдий ч хугацаа өнгөрөхийн хэрээр буурч байна. Иймд дэд бүтцийг сайжруулахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татахаас гадна дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүбэл илүү үр өгөөжтэй байх болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Amy Jocelyn Glass and Kamal Saggi. (1998). International Technology Transfer and the Technology Gap. *Journal of Development Economics*, Vol.55 p. 69-398.
- Ancuta , P., & Andrei , D. (2013). *Multipliers of Romanian Economic Structure: An analysis in terms of input-output model*. Новини Ститовой наукив.
- Billington, N. (1999). The Location of Foreign Direct Investment: An empirical Analysis. *Applied Economics*, 65-78.
- Borensztein, E. J. (1998). How does foreign direct investment affect economic growth? *Journal of International Economics* 45 (1), 115-35.
- Caves, R. (1971). International Corporations: The Industrial Economics of Foreign Investment. *Economica*, 1-27.
- Chenery B, H., & Clark P, G. (1959). *Interindustry Economics (translation into Russian, 1962)*. Moscova” Editura de Literatură Străină.
- Cheng, L., & Kwan, Y. (2000). What are the Determinants of the Location of Foreign Direct Investment? The Chinese Experience. *Journal of International Economics*, 379-400.
- Dewhurst, J. H. (1991). The Relative Importance of Input Coefficients and Transactions, In: *Input/Output Structure în New Interpretations and Extensions of Regional Input/Output Modelling*. Gower Publishing.
- Dickey, D., & Fuller, W. (1979). Distribution of the Estimators for Autoregressive Time Series With a Unit Root. *Journal of the American Statistical Association*, 427-431.
- Dobrescu, E. (1970). *The Inter-branches Balance - An Instrument of Structural Analysis of Economy*. Economic Computation and Economic Cybernetics Studies and Research.
- Dobrescu, E. (2006). *Integration of Macroeconomic Behavioural Relationships and the Input-Output Block (Romanian Modelling Experience)*. <http://www.ecomod.org/files/papers/1564.pdf>.-ээс Гаргасан
- Dobrescu, E. (2009). Measuring the Interaction of Structural Changes with Inflation. *Romanian Journal of Economic Forecasting*, 5-99.
- Dunning, J. (1993). *Multinational Enterprises and the Global Economy*. Harlow, England: Addison-Wesley.
- Emilian, D., Viorel, G., & Cornelia, S. (2010). *Using the Leontief matrix to estimate the impact of investments upon the global output1*. Institute of Economic Forecasting.
- Engle, R., & Granger, C. (1987). Co-integration and Error Correction: Representation, Estimation, and Testing. *Econometrica*, 251-276.

- Erdal, F., & Tatoglu, E. (2002). Locational Determinants of Foreign Direct Investment in an Emerging Market Economy: Evidence from Turkey. *Multinational Business Review*.
- Ewe-Ghee, L. (2001). Determinants of, and the Relation between, Foreign Direct Investment and Growth: A Summary of the Recent Literature. *IMF Working Paper*, WP/01/175.
- Froot, K., & Stein, J. (1991). Exchange Rates and Foreign Direct Investment: An Imperfect Capital Markets Approach. *Quarterly Journal of Economics*, 1191-1218.
- Gaftea, V. (2003). *Analiza structurii economiei utilizând balanța legăturilor dintre ramuri*. Institutul Național de Cercetari Economice al Academiei Române.
- Gaftea, V. V. (2005). *Impactul creșterii prețurilor la utilități pentru firmele românești*. <http://www.gea.org.ro/documente/ro/impactpreturiutilitati.pdf>.-ээс Гапрасан
- Institute for Economic Forecasting. (2009). The «Dobrescu Macromodel» of the Romanian Market Economy – 2005 Version Yearly Forecast Autumn Using the Leontief Matrix to Estimate the Impact of Investments Romanian Journal of Economic Forecasting. *Journal of Economic Forecasting*, 224-226.
- Krugman Paul R., Obstfeld Maurice, Melitz Marc J. (2013). *International Economics*. Pearson.
- Liu X., Siler P., Wang C. & Wei Y. (2000). Productivity spillovers from foreign direct investment: Evidence from UK industry level panel data. *Journal of International Business Studies*, 31(3), 407-425.
- Love, J., & Lage-Hidalgo, F. (2000). Analysing the Determinants of US Direct Investment in Mexico. *Applied Economics*, 1259-1272.
- Lucas, R. (1990). Why Doesn't Capital Flow from Rich to Poor Countries. *American Economic Review*, 92-96.
- Lynde, C., & Richmond, J. (1993). Public Capital and Long-run Costs in U.K. Manufacturing. *The Economic Journal*, 880-893.
- M, C. (1974). *Balanța statistică a legaturilor dintre ramuri*. București: Editura Politică. .
- Michael Lenox and Andrew King. (2004). Prospective for Developing Absorptive Capacity Through Internal Information Provision. *Strategic Management Journal*, 331-345.
- Micheal Todaro P., Stephen C. Smith. (2014). *Economic Development*. New York: Pearson.
- Noorbakhsh, F., Paloni, A., & Youssef, A. (2001). Human Capital and FDI Inflows to Developing Countries: New Empirical Evidence. *World Development*, 1593-1610.

- P., D. S. (2005). Spillovers from foreign Direct Investment and Firm Growth: Technological, Financial and Market Structure Effects. *International Journal of the Economics of Business*, 12(1), 85-104.
- Pedro Sanchez-Sellero, Jorge Rosell-Martinez, Jose Manuel Garcia-Vazquez. (2013). Innovation as a Driver of Absorptive Capacity from Foreign Direct Investment in Spanish Manufacturing Firms. *Procedia-Social and Behavioral Sciences* (75), 236-245.
- Phillips, P., & Hansen, B. (1990). Statistical Inference in Instrumental Variables Regression with I(1) Processes. *Review of Economic Studies*, 99-125.
- Phillips, P., & Perron, P. (1988). Testing for a Unit Root in Time Series Regression. *Biometrika*, 335-346.
- Romer, P. (1986). Increasing returns and long run growth. *Journal of Political Economy* 94 (5), 1002-1037.
- Romer, P. (1990). Endogenous technological change. *Journal of Political Economy* 94 (5), 71-102.
- Ronald Findlay. (1978). Relative Backwardness, Direct Foreign Investment, and the Transfer of Technology: A Simple Dynamic Model. *The Quarterly Journal of Economics*, Vol. 92, p. 1-16.
- Shatz, H., & Venables, A. (2000). The Geography of International Investment. G. Clark, & M. G. Feldman-Д, *Oxford Handbook of Economic Geography* (хуудсд. 125-145).
- Shin, H. S. (2009). Reflections on Northern Rock: The Bank Run that Heralded the Global Financial Crisis. *Journal of Economic Perspectives*, vol.23, хуудсд. pp 101-109.
- Solow, R. (1956). A contribution to the theory of economic growth. *The quarterly Journal of Economics*, 70 (1), 65-94.
- U.S. Embassy in Ulaanbaatar Mongolia. (2014 July). *2014 Mongolia Investment Climate Statement*. Ulaanbaatar: U.S. Embassy.
- UNCTAD. (1998). *World Investment Report* .
- UNCTAD. (2002). *World Investment Report 2002: Transnational Corporations and Export Competitiveness*.
- UNCTAD. (2013). *Investment Policy Review*. New York.
- Wesley M. Cohen, Daniel A. Levinthal. (1990). Absorptive Capacity: A New Perspective on Learning and Innovation. *Administrative Science Quarterly*, Vol. 35, No. 1, pp. 128-152.
- World Bank Group. (2015). *Doing Business*.

- Yang, J., & Groenewold, N. T. (2000). The Determinants of Foreign Direct Investment in Australia . *The Economic Record*, 45-54.
- А.Ананд. (2010). Гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засгийн бодит салбарууд дахь нөлөө: Монголын жишээ. *Монголбанк “Судалгааны ажил”, Товхимол-6*, 155-177.
- Батсүх, Ц., & Будням, С. (1996). *Математик-Эдийн засаг*. Улаанбаатар.
- Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага. (2010-2013). *Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чадавхийг бэхжүүлэх төсөл*. Улаанбаатар: ЖАЙКА.
- Д.Мөнхцэцэг, Б.Оюу-Эрдэнэ. (2012). *Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчин болон эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн шинжилгээ*. Улаанбаатар: СЭЗДС.
- Монгол дахь дэлхийн банкны групп. (2013 оны 4-р сар). *Монгол Улсын эдийн засгийн тойм*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. (2010). *Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал*. Улаанбаатар: УИХ.
- Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. (1991-2014). *Статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо. (2011). *Монгол Улсын хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа*. Улаанбаатар: ҮХШХ.

Хавсралт 1. ГШХО-ын гүйцэтгэлийн индекс

2013 оны индексийн эрэмбэ	Улсууд	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Кайманы арлууд	5.7	-1.3	4.0	48.3	42.0	3.4	69.7	130	94.2	86.9	77.8	65.5	-4.3	-67.2	212	157	159	187	189	295	120	185	110	155
2	Либерти	50.2	2.9	-5.8	-30.6	11.2	2.4	-52.0	39.6	19.8	14.9	0.9	0.6	0.3	54.3	8.3	6.4	5.2	4.6	10.5	10.3	19.0	18.5	36.1	32.9
3	Люксембург	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4	Мозамбик	0.3	1.2	1.9	1.8	1.7	1.7	1.8	1.1	2.4	2.5	0.8	2.4	4.5	4.6	2.5	0.8	0.7	1.5	2.0	4.5	5.0	8.9	21.1	19.6
5	Мавритан	0.5	0.2	0.6	1.3	0.2	0.4	0.0	-0.1	0.0	0.3	0.7	2.3	2.7	4.1	12.8	17.3	1.7	1.2	3.3	-0.1	1.9	5.6	19.6	14.6
6	Хонг Конг	4.6	1.8	5.6	6.7	6.2	3.8	5.2	4.1	3.6	4.5	9.5	7.2	2.2	7.3	7.6	10.5	7.9	8.3	10.4	12.2	16.4	16.2	15.5	14.3
7	Сингапур	15.6	16.5	6.4	9.0	12.6	12.2	9.6	10.0	3.0	6.5	3.8	7.6	3.7	11.2	12.6	6.7	8.6	7.6	2.2	6.1	10.8	7.9	12.1	11.5
8	Шинэ Каледони	1.3	0.2	0.0	0.8	0.0	0.0	0.0	0.2	0.0	0.0	-0.3	1.2	0.9	1.5	0.3	-0.1	3.7	1.3	6.6	6.5	9.4	7.4	14.2	10.1
9	Жибути	0.0	0.8	0.7	0.3	0.3	0.6	0.5	0.4	0.3	0.2	0.1	0.2	0.3	1.4	3.4	1.5	4.8	6.5	8.0	4.6	1.1	2.6	4.4	10.1
10	Ангуйла	15.5	12.0	27.6	8.1	11.7	15.0	24.1	11.0	8.8	7.5	6.7	8.8	13.1	12.7	26.6	24.2	17.3	9.6	9.7	7.5	1.9	5.6	8.4	9.8
11	Сент-Винсент ба Гренадин	3.6	5.4	7.6	12.9	17.8	8.7	10.3	16.9	10.3	4.3	2.2	1.9	4.0	7.2	7.4	3.5	6.1	5.0	7.8	7.9	6.5	5.3	9.1	9.0
12	Монгол	0.0	1.2	0.2	0.7	0.5	0.6	0.9	1.3	0.7	0.8	1.1	1.9	3.0	5.2	2.7	3.5	2.4	2.5	5.1	6.6	12.4	22.5	23.7	8.9
22	Кыргыз			0.0	0.6	2.7	5.7	2.0	3.0	2.9	1.0	0.0	0.1	0.2	1.5	4.6	0.8	2.2	1.5	2.5	1.9	4.1	4.7	2.5	5.8
39	Чили	2.1	3.2	3.0	2.4	4.8	3.5	4.9	3.9	2.5	3.4	1.5	2.3	2.0	3.6	4.2	2.7	1.6	2.1	2.9	3.6	3.3	3.9	5.8	3.7
48	Намиби	1.2	6.5	5.5	2.0	2.8	3.4	2.6	1.3	0.9	0.1	1.1	4.0	2.9	1.9	2.0	2.5	1.6	2.4	2.8	2.8	3.3	2.7	3.7	3.0
60	Перу	0.2	0.0	-0.3	2.5	7.9	4.2	4.9	2.3	1.3	1.1	0.4	0.8	2.1	1.4	1.3	1.5	1.3	1.4	1.8	2.4	2.4	1.9	3.3	2.5
63	Казахстан			0.6	6.0	3.2	4.1	4.3	3.7	2.3	2.5	1.6	4.9	5.6	4.2	5.6	2.1	3.2	3.2	4.3	5.9	2.3	3.1	3.7	2.3
74	ОХУ			0.4	0.3	0.2	0.5	0.5	0.8	0.4	0.5	0.2	0.3	0.5	1.2	1.5	0.9	1.3	1.2	1.5	1.4	1.3	1.2	1.4	1.9
75	Азербайжан			0.0	0.0	0.7	4.5	14.8	16.8	10.0	3.3	0.6	1.5	12.1	28.5	23.9	5.9	-0.9	-4.1	0.0	0.5	0.5	0.9	1.6	1.9
83	Габон	1.4	-1.4	3.2	-2.3	-2.4	-5.3	-6.5	-3.5	0.9	-1.3	-0.2	-0.7	0.4	2.0	1.5	1.6	0.9	0.6	1.6	1.8	1.2	1.2	1.6	1.7
125	Узбекистан			0.1	0.4	0.6	-0.2	0.5	0.7	0.4	0.2	0.1	0.3	0.4	0.5	0.9	0.6	0.3	0.9	0.8	1.2	1.9	1.5	0.7	1.0
145	Хятад	0.9	1.6	3.3	5.0	6.3	4.4	3.7	2.9	1.9	1.1	0.8	1.4	2.0	2.0	1.8	1.5	0.9	0.7	0.8	0.9	0.9	0.7	0.8	0.7

